



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ



БАГШИЙН ХӨГЖЛИЙН ОРДОН



"ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ"

ОНОЛ, ПРАКТИКИЙН IV БАГА ХУРАЛ

Улаанбаатар хот
2016 он



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ



“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ”

ОНОЛ, ПРАКТИКИЙН IV БАГА ХУРАЛ

*Боловсролын чанар нь хичээлийн чанараас,
хичээлийн чанар нь хичээлийн судалгаанаас*

Улаанбаатар, 2016

**"ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ" СЭДЭВТ
ОНОЛ, ПРАКТИКИЙН IV БАГА ХУРАЛ**
2016 оны 11 сарын 22-23

Илтгэлийн дэлгэрэнгүйг хүлээн авах хугацаа:
2016 оны 11-р сарын 30

Хүлээн авах хаяг:
hicheeliin.sudalgaa2014@gmail.com

Зохион байгуулагч:

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ
МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ

Санхүүжүүлэгч байгууллага: Азийн хөгжлийн банк

СОДПРЕСС ХХК-д хэвлэв 2016

ӨМНӨХ ҮГ



Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт үндэсний хэмжээний онол, практикийн бага хурлыг 4 дэх жилдээ амжилттай зохион байгуулж байна. Энэхүү үйл ажиллагаанд оролцогчдын тоо жилээс жилд өсч, илтгэлийн чанар улам сайжирч байгаагаас харахад хичээлийн судалгаа нь багш нар ажлын байрандаа хамтран хөгжиж, харилцан суралцах хамгийн оновчтой арга хэлбэрүүдийн нэг болон хөгжиж байгаагийн илрэл юм. Энэ жилийн хурал нь Монгол улсад боловсролын мэргэжил, арга зүйн байгууллага болох Багшийн мэргэжил дээшлүүлэх институт үүсэж хөгжсөний 60 жилийн ойн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж байгаагаараа онцлог юм.

Японд үүсэж хөгжсөн хичээлийн судалгааны арга нь манай боловсролын салбарт нэвтрээд багагүй хугацаа өнгөрч байгаа ч цаашид улам хөгжүүлэх, зохистой байдлаар нутагшуулах хэрэгцээ шаардлага бидний өмнө тавигдсаар байна. Хичээлийн судалгаа нь сурагч төвтэй суралцахуйг бүтээх нэг хэрэгсэл учраас дэлхийн олон оронд хичээлийн судалгаагаар дамжуулан боловсролын багшлахуйн болон суралцахуйн чанарыг сайжруулах судалгааны чиглэл түлхүү хөгжиж байна. Цаашид хичээлийн судалгааг хөгжүүлэхэд бидний хамтын ажиллагаа улам нягтарч, илүү үр дүнтэй болно гэж найдаж байна.

Та бүхний багшлах, судлан шинжлэх их үйлсэд өндөр амжилт хүсээд хүүхэд бүрийн сурч мэдэх хүсэл тэмүүллээр жигүүрлэн ажиллахыг хүсье.

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ
ЗАХИРАЛ
А.ТУЯА

ӨМНӨХ ҮГ



Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгууллага үүсэж хөгжсөний 60 жилийн ойн арга хэмжээний нэг болох “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт онол практикийн IV бага хурлын индэр дээр уулзаж байгаадаа туйлын баяртай байна. БСШУЯ ба Жайка ОУХАН-ийн багшлах арга зүйг хөгжүүлэх чиглэлээр 2006 онд “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төсөл анх хэрэгжиж, хичээлийн судалгааны арга зүйд эхлэн суралцаж байсан тэр цаг үеэс хойш 10 жил өнгөрсөн байна. Хоёр үе шаттай хэрэгжсэн энэхүү төсөл нь хүүхдийг хөгжүүлэх сургалтын шинэ арга зүйг бүтээх, тэдний бие даан суралцах чадварыг нээн хөгжүүлэх үндсэн арга зам болох хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлсийг эхлүүлж, үндэс суурийг тавьсан билээ. Энэхүү суурийг цаашид хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, дотоодод төдийгүй олон улсад сурталчлах үйлсэд БМДИ ба МХСН үр дүнтэй хамтран ажиллаж байна.

Жил бүр тогтмол зохион байгуулагддаг “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт энэхүү онол практикийн бага хурал нь харилцан туршлага солилцох, судалгааны шинэлэг арга зүйд суралцах онол, практикийн чухал ач холбогдолтой байдаг төдийгүй багш нар ажлын байрандаа мэргэжлээ тасралтгүй дээшлүүлдэг хамтын ажиллагааны нэгэн том талбар болж байгаад бид баяртай байна. Хурлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах нөр их ажлыг санаачлагатай, сэтгэл зүтгэлээрээ амжилттай биелүүлж байдаг БМДИ-ийн удирдлага, арга зүйчид болон МХСН-ийн мэргэжлийн багийн эксперт, зөвлөхүүдэд талархал илэрхийлье.

Та бид энэ хурлаараа суралцагчийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйг хөгжүүлэх үйлсэд олсон амжилт ололт, туршлага, тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлуудаа хэлэлцэхийн зэрэгцээ

хичээлийн судалгааны дараагийн шатны зорилго, зорилтоо дэвшүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

МХСН нь хичээлийн судалгааны чиглэлээр

- Сургалт, судалгаа явуулах;
- Хичээлийн судалгааны эксперт, зөвлөх, сургагч бэлтгэх;
- Япон дахь сургалтад багш, удирдлага, судлаачдыг хамруулах;
- Мэргэжлийн цахим хуудас (mals.mn)-аар онол арга зүй, туршлагыг сурталчлах;
- Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, дэлхийн хичээлийн судалгааны нийгэмлэгийн хуралд тогтмол оролцох;

Сургууль, багш нартай хамтран ажиллах зэргээр багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулж байгааг эцэст нь тэмдэглэе.

Та бүгдийн бүтээсэн шинэ санаа, арга зүй түгэн дэлгэрэх болтугай

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.ОЮУНЦЭЦЭГ

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ.....	3
УДИРТГАЛ	10
Хичээлийн судалгааны хөгжилд багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн гүйцэтгэж буй үүрэг, оролцоо	10
Хичээлийн судалгааны хөгжилд монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн оролцоо, хувь нэмэр.....	14
НЭГ. МЭРГЭЖЛИЙН БАГИЙН ҮНДСЭН ИЛТГЭЛ	17
Хичээлийн судалгааны илтгэлийн онцлог.....	17
<i>Ж.Энэбиш, М.Ганбат</i>	
Химийн “Сайн хичээл”-д хийсэн анализын зарим үр дүнгээс.....	18
<i>Ш.Сайнбилэг, Н.Оюунцэцэг</i>	
Шинжлэн судлах арга зүй ба хичээлийн судалгаа	19
<i>Ц.Пагмасүрэн</i>	
Газарзүйн хичээлд сорил, туршилтын аргазүйг нэвтрүүлэх асуудалд	20
<i>Г.Юмчмаа, Ц.Цэндсүрэн</i>	
VI-IX ангийн сурагчдын сурах бичигтэй бие дааж ажиллах арга барилыг даалгаврын сорилын аргаар судалсан дүн	21
<i>С.Цогбадрах, Д.Алтангэрэл, М.Оюунчимэг</i>	
ХОЁР. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА	21
Хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйд олон улсын стандартыг түшиглэх боломж	22
<i>Ц.Үрэлмаа Ph.D, Д.Оргилмаа, О.Оюунтунгалаг</i>	
Эрүүл мэндийн хичээлээр эрүүл зан үйл төлөвшүүлэх нь	23
<i>Б.Нарантуяа, А.Мөнхжаргал</i>	
ГУРАВ. СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА.....	25
Самбар, дэвтрийн бичилтээр хүүхдийг хичээлийн дэг соёлд сургах нь.....	25
<i>Ж.Бямбасүрэн</i>	
Хичээлийн судалгааны менежментийг боловсронгуй болгох замаар сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулах нь.....	27
<i>Л.Сувдаа,</i>	
Менежментэд үндэслэсэн “хичээлийн хэлэлцүүлэг”багшийн хөгжилд нөлөөлөх нь	28
<i>Н.Азжаргал., Б.Чулуун-Эрдэнэ</i>	

Сургуульд суурилсан хичээлийн судалгаагаар сурагчдын асуудал дэвшүүлэн шинжлэн судлах үйл ажиллагаа нь	31
<i>З.Болормаа, Б.Алтансарнай, С.Гэрэлмаа, Д.Ганхуяг</i>	

ДӨРӨВ. СУДЛАГДАХУУНД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА.....33

Сурагчдын мэдээлэл боловсруулж, тайлбарлан ярих чадварыг хөгжүүлэх нь....	33
<i>Х.Сарантуяа, М.Ичинноров, О.Оюунчимэг, Б.Хүрэлбаатар, Н.Сарангэрэл</i>	
Тулгуур дохионы аргаар эхийг хялбарчлах арга зүй	34
<i>С.Батдаваа, Г.Одончимэг, Ч.Ариунжаргал, Б.Бүжидмаа</i>	
Сургалтын идэвхтэй аргуудыг ашиглан суралцагч нэг бүрийн оролцоог хангах нь	35
<i>Д.Нансалмаа, Ч. Цэрэнлхам, Э.Алтанцэцэг</i>	
5 алхамт эсээ бичлэгийн аргаар суралцагчдын бичих чадварыг хөгжүүлэх арга зүй.....	37
<i>Б.Сувдаа</i>	
Хөтөч санааг баримтаар дэмжих арга зүйгээр ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг дэмжих нь.....	39
<i>С.Энхжаргал</i>	
“Сайн хичээл”-ийн хөтөлбөрүүдэд хийсэн судалгаа (Бага боловсролын монгол хэл).....	41
<i>Д.Ганболд</i>	
“Өөрийгөө бүтээхүй” эх зохион найруулах арга зүй.....	42
<i>Д. Дэлгэрмаа, Б.Бүжинлхам, С.Тэгшдүүрэн, Г.Нямзаяа</i>	
Хүүрнэл зохиолын сэдэв, гол санааг тайлбарлах арга зүй.....	43
<i>Б.Буяннэмэх, Н.Дэлгэрмаа, Б.Бямбасүрэн, Г.Оюунаа, П.Өлзиймаа, Д.Цэрэнбат, Н.Дэлгэржаргал</i>	
Хөтөч санаа /түлхүүр өгүүлбэр/-г баримтаар дэмжих арга зүйгээр ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг дэмжих нь.....	44
<i>С.Энхжаргал</i>	
Зургийн хичээлд оюуны зураглалын аргыг хэрэглэх нь.....	47
<i>Б.Гэрэлчимэг</i>	
Лаборатори туршилтаар нэхмэл материалыг таних нь — хичээлийн интеграци эхийг хялбарчлах арга зам	48
<i>Я.Сэлэнгэ</i>	
Далайгаар аялцагая.....	49
<i>Д.Оюунмаа, М.Хараа, Г.Оюунтуяа, Ч.Цагаанхүүхэн</i>	
Суралцагчдын суурь чадварыг түүх, нийгмийн ухааны хичээлээр оношлон, хөгжүүлж буй ажлын үр дүн.....	51
<i>Б.Өлзийжаргал</i>	
Ажлын хуудсаар сурагчдын мэдлэг чадварыг үнэлэх нь	52
<i>Ж.Дэлгэрмаа</i>	

Нийгмийн ухааны хичээлд баримтат кино болон аудио, видео материалыг ашиглах нь	53
<i>Б.Ариунаа</i>	
Ээлжит хичээлийн засан сайжруулалтын үр дүн.....	53
<i>Д.Байгалмаа, Г.Бадамханд, Д.Байгалмаа, Г.Бадамханд, Д.Анхбилэг, Д.Бүжин</i>	
Түүхийн хичээлээр мэдлэг бүтээлгэх арга зүйг боловсруулсан нь	55
<i>Д.Оюунчимэг</i>	
Иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээ.....	57
<i>Н.Нарантуяа, Н.Олонбаяр</i>	
“Металл, металл бишийн нягт” ээлжит хичээлийн арга зүйн туршлага	58
<i>А.Дэмбэрэлнямбуу, Ц.Чимэдрэгзэн, Г.Дэмбэрэлмаа, Я.Нарангэрэл, Б.Нямдаваа</i>	
Фарадейн хуулийг батлах туршилтын багажийг сургалтын хэрэглэгдэхүүн болгон туршсан нь	59
<i>Н.Баярсайхан, Р.Отгонхүү</i>	
Цахим ажлын хуудсаар хүүхдийн хөгжлийг дэмжих нь	61
<i>Ч.Оюун-Эрдэнэ, Ц.Энхжин, Ц.Батхуяг</i>	
Хүүхдийг өөрийн удирдлагатайгаар сургах арга зүй.....	62
<i>А.Батцэцэг, Б.Сундуй</i>	
Математикийн хичээлийг хэрэглээтэй холбож сурагчдыг жигд хөгжүүлэх арга зүй.....	64
<i>Н.Доржмаа, Ш.Шинэхүү, Д.Энхжаргал</i>	
Нэгж хичээлээр хүүхэд бүрийг хөгжүүлэхэд оношилгооны арга зүйг ашиглах нь.....	65
<i>Д.Анхбаяр</i>	
“Зүг чиг” агуулгын хүрээн дэх интеграц хичээлийн ач холбогдол	66
<i>Г. Баярмаа, Д.Лхагвасүрэн, Т.Хоролгарав, Т.Нанжидмаа</i>	
Хүүхэд нэг бүрийг ажлын хуудас болон жишиг даалгавраар хөгжүүлэх нь	67
<i>Б.Дуламжав, Ч.Ууганбаяр, С.Чимис, С.Болор</i>	
Гэрийн даалгаврыг хүүхдэд дарамт биш хөгжих боломж болгох нь	69
<i>М.Энхтуул, А.Оюунгэрэл, Б.Даваадулам, Ч.Эрдэнэбулган</i>	
Урмын үгийн хэрэглээг судалж, туршсан байдал.....	70
<i>Б.Буянхишиг, Л.Галтмаа, Т.Эрдэнэцэцэг, О.Янжмаа, Э.Сэрсэндэмид</i>	
“Надад туслаач” нэгж хичээл.....	71
<i>М. Хандсүрэн, Г. Хэрлэн, З. Золзаяа</i>	
Багшийн бүтээлч хандлага хүүхдийн хөгжилд нөлөөлөх нь.....	72
<i>Ц.Нарантуяа, Ж. Гантуяа</i>	
Луувангийн ач тус	73
<i>Д.Лхагвабаасан</i>	
Хичээлийн шинжлэх ухаанч арга барилын шинжийг үнэлэхэд мониторингийн хуудсыг туршсан үр дүнгээс.....	74
<i>Б.Энхбилэг, Ш.Сайнбилэг, Н.Оюунцэцэг</i>	

Туршилтаар хүүхдийн хөгжлийг дэмжих, мэдлэг бүтээлгэх арга зүй	75
<i>Г.Лхамноржин Ц.Түмэнжаргал Б.Бадамханд М.Мөнхбаяр Э.Бурмаа</i>	
Соронз юуг татдаг вэ?	77
<i>Ж.Урантогос, М.Энхчимэг, Л.Өнөржаргал,</i>	
Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаагаар сурагчдыг сэдэлжүүлэх нь	79
<i>Г.Оюунтуяа, М.Хараа, Д.Оюунмаа</i>	
Дунд ангид ороход бэлэн үү.....	80
<i>П.Болорцэцэг, Д.Цэрмаа, С.Хэрлэн</i>	
Бага ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх боломж	81
<i>А.Мөнхжаргал</i>	
Анхны тоог таниулах арга зүйн туршлага	82
<i>Н.Оюунхүү, У.Алтанцоож, Б.Дүгэрмаа, Т.Мөнхцэцэг</i>	
Ээлжит хичээлээр хүүхэд бүрийн сэтгэхүйг хөгжүүлэх 5 хором	83
<i>Ч. Түмэндэмбэрэл</i>	
Шулууны хувьд тэгш хэмтэй дүрс байгуулах.....	84
<i>Ч.Агваантогтох Б.Оюумаа Д.Оюунтүлхүүр, Б.Мөнхтуяа Б.Ариунжаргал</i>	
Чээж тооллоор сурагчдыг хөгжүүлэх нь.....	86
<i>Ц.Мөнхцэцэг</i>	
Эргүүлэлтээр хээ үүсгэх мэдлэг бүтээлгэх арга зүй.....	87
<i>Ж.Эрдэнэцэцэг Б.Амарцэцэг У.Нямхүү</i>	
Тоо бүтээж тоглонгоо тоймлож сурцгаая.....	88
<i>М.Хараа, Ч.Цагаанхүүхэн, Д.Оюунмаа, Г.Оюунтуяа</i>	
Хүүхэд бүрийг ярих урлаг ба жүжигчилсэн тоглолтоор хөгжүүлэх нь.....	90
<i>Н.Наранжаргал</i>	
Дуурайн бичих аргаар сурагчдыг чадваржуулах арга зүй.....	91
<i>Б. Долгорсүрэн, Н.Оюунгэрэл, Д.Содномпэлжээ, А.Долгормаа, Одгэрэл, Г.Цэндорж</i>	
Дуурайн бичих арга зүйгээр хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нь.....	92
<i>Сумьяажав Болортуяа</i>	

ТАВ. ХАНЫН ИЛТГЭЛ95

Төлөвшилд хүрсэн сургуулийн соёл.....	95
<i>О.Мөнхгэрэл, Г.Бүдтуяа, Ч.Цогзолмаа, Р.Оюунтуяа, Л.Нямсүрэн, Я.Наранбаяр, Д.Галцолмон</i>	
Манай нутагт ургадаг ургамал	96
<i>Д.Пунсал</i>	
Сургуульд суурилсан байгалийн ухааны хичээлийн судалгааг зохион байгуулж буй туршлагаас	97
<i>У.Энхтуяа, С.Алтанзул</i>	
Бүтээлээр хүүхдийг хөгжүүлэх нь	99
<i>З.Тунгалаг, Л.Дашдолгор, С.Ариунаа</i>	

УДИРТГАЛ

Хичээлийн судалгааны хөгжилд багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн гүйцэтгэж буй үүрэг, оролцоо



Багшийн мэргэжил дээшлүүлэх институт “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” онол практикийн бага хурлыг 4 дэх жилдээ зохион байгуулж байгаа ба энэ удаагийн хурал Монгол улсад Боловсролын эрдэм шинжилгээ судалгаа, арга зүйн төв байгууллага үүсэж хөгжсөний түүхт 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж байгаагаараа онцлогтой юм.

БСШУСЯ, Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ЖАЙКА)-тэй хамтран 2006-2013 онуудад “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил”, “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх нь” төслийг хоёр үе шаттай хэрэгжүүлсэн билээ. 2016 оноос энэхүү төслийн III үе шат болох “Суралцахуйг дэмжсэн мэргэжлийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх” төслийг Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ЖАЙКА)-ийн дэмжлэгтэйгээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Эдгээр үе шаттай хэрэгжсэн төслүүдийн үр дүнд хичээлийн судалгааны эхлэл, суурь тавигдаж манай багш нар хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга зүй, технологийн нэг болох хичээлийн судалгааны арга зүйг эзэмшин хэрэгжүүлж байгааг багш нарын үйл ажиллагаа, ажлын үр өгөөж бодитоор харуулж буйг онцлон дурдмаар байна. Төслийн үйл ажиллагаа, гадаад, дотоодын зөвлөхүүд болон багш нарын боловсруулсан арга зүй, технологи, багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, хичээлийн судалгааг тогтвортой үргэлжлүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон. Энэ цаг үед БМДИ шинээр байгуулагдаж, хичээлийн судалгааны арга зүйг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг БСШУСЯ-ны удирдлага дор (БСШУ-ны сайдаар ахлуулсан Үндэсний Зөвлөлдөх хороо) мэргэжлийн багуудтай хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн юм.

Бид хамтран Үндэсний хэмжээнд 2013-2017 онд “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх” үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, БМДИ-ийн захирлаар батлуулан хамтран ажиллагч байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан 2 үндсэн зорилтын хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд

Зорилт 1-ын хүрээнд:

- БМДИ-ийн бүтэц орон тоонд хичээлийн судалгааны менежментийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хариуцсан гэрээт ажилтанг /2013 оны 9 сараас -2015 оны 6 сар / ажиллуулахын зэрэгцээ бүх арга зүйчдийн ажлын байрны тодорхойлолтод “хичээлийг судалгааны арга зүйг хэрэгжүүлэх” чиг үүргийг тусган ажиллаж байна.
- БМДИ-ийн хүний нөөцийг чадавхижуулах зорилгоор 2013 онд албадын дарга, арга зүйчид 10 хүн, 2014 онд арга зүйч 15 хүн, 2015 онд арга зүйч, мэргэжилтэн-7 хүн, 2016 онд арга зүйч мэргэжилтэн 10 хүн, нийт -42 хүнийг Япон улсад “ Хичээлийн судалгааны арга зүй”-н туршлага судлах, сургалт-уулзалтад үе шаттайгаар хамруулж байна.
- Хичээлийн судалгаагаар гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд оролцох, харилцан суралцахаар 2013 онд Хичээлийн судалгааны Олон Улсын нийгэмлэгээс Швед улсад зохион байгуулагдсан хуралд-2 хүн оролцож илтгэл тавьж хэлэлцүүлсэн.
- Хүүхдийн хөгжлийг дэмжсэн арга зүй технологийн нэг хичээлийн судалгааны менежмент, төрөл, арга хэлбэрийг өөрийн сургуульд хэрэгжүүлсэн арга туршлага, үр дүн, ололт амжилт, шийдлийн талаар хэлэлцэж туршлага солилцох зорилгоор МХСН-тай хамтран жил бүр ЭШХ /онол практикийн бага хурал/ зохион байгуулж байна.
- “Хичээлийн судалгаагаар дамжуулан боловсролын болон багшийн чанарыг сайжруулах” сэдвийн хүрээнд жил бүр Азийн орнуудад зохион байгуулагддаг сургалт хэлэлцүүлэгт нийт 5 арга зүйчийг оролцуулж өөрийн оронд хичээлийн судалгааг хэрэгжүүлэхэд гардаг асуудал, бэрхшээл, шийдвэрлэх боломж, арга замыг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл гаргасан.

Зорилт 2-ын хүрээнд:

- Хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэхэд орон нутгийн хэмжээнд хүний нөөцийг бэлтгэх, бүтэц зохион байгуулалт бий болгох хэрэгцээ шаардлага үүсэж БМДИ-ийн захирлын 2013 оны А/17 тоот тушаалаар үндэсний болон орон нутгийн багийг байгуулан үйл ажиллагааны чиглэл хүргүүлэн хамтран ажиллаж байна.
- ЕБС-д 1,5,10 жил ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрт “Хичээлийн судалгааг хэрэгжүүлэх арга зүй”-г тусган, түүнийг ажлын байрандаа хэрэгжүүлэх хөшүүрэг болгон үндсэн сургалтын үргэлжлэл болсон онлайн сургалтын даалгаврын агуулгад оруулж үр дүнг тооцож байна.
- МХСН-тэй хамтран орон нутгийн боловсролын газрын мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулах, зөвлөн туслах, хамтран ажиллах хичээлийн судалгааны үндэсний сургалтууд, орон нутагт захиалгат болон ажлын байран дахь сургалтуудыг хийж байна.
- Хичээлийн судалгааны мэргэжлийн баг, Япон улсын багш бэлтгэдэг их дээд сургуулийн олон улсын зөвлөх багш нартай хамтран Дорноговь, Хэнтий аймгуудад хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй анги танхимд хэрхэн хэрэгжиж буй байдалд мониторинг хийж, арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөн тусалж байна.

Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахын зэрэгцээ цаашид эрдэм шинжилгээний хурлын хүрээг тэлэх, чанаржуулах, их дээд, ЕБС-ийн багш нартай хамын судалгаа туршилт хийх, БМДИ-ээс эрхлэн гаргадаг “Багшийн хөгжил” сэтгүүлд хичээлийн судалгааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөмж арга зүйн булантай болох, шинэ судлагдахуунуудад хичээлийн судалгааг хэрэгжүүлэх гарын авлага гаргах, хичээлийн судалгааг хэрэгжүүлж буй тэргүүн туршлагыг боловсролын үндэсний технологийн санд байршуулах, нийтийн хүртээл болгох, түшиц сургуулиудад “сургуульд суурилсан хичээлийн судалгааны шинэ менежмент”-ийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, мониторинг хийх, зөвлөн туслах сургалт үйл ажиллагааг хийх хэрэгцээ байна.

Та бүхэнд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт үндсэн чиг үүрэгтэй тусган хэрэгжүүлж буй ажлаараа Хичээлийн судалгааны

хөгжилд гүйцэтгэж буй үүрэг, оролцоогоо товч танилцуулахын хамт “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй-2016” онол практикийн IV бага хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг ахалж буйн хувьд БМДИ-ийн нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж, хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэж байна.

Анхны хурлыг бид одоогоос 4 жилийн өмнө төслийн баг хамт олонтой хамтран зохион байгуулж төслийн үр дүнд бий болсон ололт амжилтаа хуваалцаж байсан билээ. Энэ удаагийн хуралд оролцогчдын тоо нэмэгдсэн, багш өөрийгөө хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ажлын байрандаа тасралтгүй хөгжих арга хэрэгслүүдээс хэрэглэх, хамтын судалгаа туршилт хийх, мөн өмнөх жилийн хурлуудад илтгэлээ хэлэлцүүлж байсан багш нар илүүтэйгээр оролцож нэг сэдэвт судалгаагаа үргэлжлүүлэн хийж үр дүнгээ танилцуулж байгаа зэргээрээ онцлогтой болж байна.

Хурлыг зохион байгуулахад хамтран ажиллаж байгаа МХСН, Хичээлийн судалгааны мэргэжлийн багийн ахлагч, гишүүд, БМДИ-ийн арга зүйчиддээ нийт оролцогчдынхоо өмнөөс талархал илэрхийлье.

Аливаа ажлын үр дүн нь бэлтгэл-зохион байгуулалтаасаа маш ихээр хамаардаг. Тийм ч учраас манай ажлын хэсгийн залуус энэхүү хурлыг үр дүнтэй, зохион байгуулалттай хийхээр хариуцлагатай ажиллаж байгааг онцлон хэлмээр байна.

Оролцогч та бүхнийг ирсэн зорилгоо биелүүлж, мэдлэг туршлагаа харилцан солилцож, шинэ санаа, урам зоригоор дүүрэн байхыг хүсэн ерөөе.

Хамтран ажиллаж
Хамтдаа бүтээцгээе.

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН
ДЭД ЗАХИРАЛ
О.ОЮУНТУНГАЛАГ

Хичээлийн судалгааны хөгжилд монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн оролцоо, хувь нэмэр

2006-2013 онд Японы олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллагын төсөл хэрэгжсэнээр Монголд хичээлийн судалгааны эхлэл, суурь тавигдаж 10 дэх жилдээ золгож байна. Хоёр үе шаттай хэрэгжсэн төслийн үйл ажиллагаа, боловсруулсан арга зүй, технологи, багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх, хичээлийн судалгааг тогтвортой үргэлжлүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон. Энэ хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх замаар суралцахуйн чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор 2013 онд Монголын Хичээлийн Судалгааны Нийгэмлэг (МХСН) байгуулагдсан. МХСН нь сургалт, судалгаа арга зүй, мэдээлэл сурталчилгааны чиглэлээр үндсэн үйл ажиллагаа хийж байна. МХСН нь хичээлийн судалгааны мэргэжлийн багийн гишүүдээс бүрддэг ба мэргэжлийн багийн гишүүд нь хичээлийн судалгааны менежмент, хичээлийн чанарыг сайжруулах, хичээлийн судалгааг тогтвортой үргэлжлүүлэх гэх мэт олон чиглэлээр судалгааны ажил хийж байна. Нийгэмлэгийн 3 жилийн хугацаанд хийсэн ажлын заримаас тоймлон танилцуулья.

- Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйн хүрээнд жил бүр явагддаг хичээлийн судалгааны онол практикийн хурлыг дөрөв дэх жилдээ БМДИ-тэй хамтран зохион байгуулж байна.
- Дэлхийн Хичээлийн Судалгааны Нийгэмлэг (WALS)-ийн хуралд манай гишүүд 2012- оноос оролцож, өнөө хүртэл 9 илтгэл хэлэлцүүлсэн байна.
- БМДИ-тай хамтран хичээлийн судалгааны үндэсний сургалт, орон нутагт захиалгат сургалт, нийслэлийн ерөнхий боловсролын захирлуудад зориулсан сургалтуудыг зохион байгуулахаас гадна хичээлийн судалгааны мониторинг хамтран хийж байна.
- Япон дахь сургалтыг 2013 оноос зохион байгуулж 40 гаруй хүнийг хичээлийг судалгааны чиглэлээр сургасан байна.
- Япон зөвлөх багш нартай хамтран математик, байгалийн ухааны багш нарт зориулсан цуврал сургалт, лекцүүдийг хамтран зохион байгуулж байна.
- Хичээлийн судалгааны онол арга зүйг хөгжүүлэх мэргэжилтний нөөцийг бий болгох зорилгоор 2016 оноос Хичээлийн судалгааны үндэсний эксперт, үндэсний зөвлөх, бүсийн

- сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж байна.
- “Суралцахуйг дэмжих мэргэжлийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх” төсөлд (2016-2019)-д МХСН-ин гишүүдийг хамруулан сургаж, туршлага хуримтлуулж байна.
- Хичээлийн судалгааны арга зүйг хөгжүүлэх замаар багшлах арга зүйг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор **mals.mn** сайтыг ажиллуулж Та бүхэнд зориулсан мэдээлэл, туршлага, эксперт, зөвлөхүүдийн хичээл зөвөлгөө, онол практикийн бага хурлын илтгэлүүд зэрэг мэдээллүүдийг хүргэж байна. Мөн энэхүү сайтаас цаг үеийн үйл ажиллагааны мэдээллийг цаг тухайд нь авч байх боломжтой.

МХСН нь цаашид мэдээлэл, сурталчилгаа, эрдэм шинжилгээний чиглэлээ үргэлжлүүлж, хичээлийн судалгааны сэтгүүлтэй болох, сургуулийн менежмент-сургуульд суурилсан хичээлийн судалгаа сургалтыг зохион байгуулах, тодорхой сургуулийг сонгож жишиг хичээлийн судалгаа зохион байгуулах, турших гэх мэт ажил олон ажлуудыг шинээр хийхээр төлөвлөж байна.

БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТИЙН
ДЭД ЗАХИРАЛ
О.ОЮУНТУНГАЛАГ

Илтгэлийн үнэлгээний баг

Н.Оюунцэцэг	Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, Ph.D
Ч.Нямгэрэл	МУИС, ШУС, БУС-ийн химийн тэнхимийн багш, Ph.D
Г.Юмчмаа	МУИС, ГГС-ийн багш, Дэд профессор, Ph.D
М.Ганбат	МУИС, ШУС, БУС-ийн физикийн тэнхимийн багш
Ш.Сайнбилэг	МУИС, ШУС, БУС-ийн химийн тэнхимийн багш
Л.Мөнхтуяа	МУБИС, МБУС-ийн багш, Ph.D
Э.Чойсүрэн	МУБИС, МБУС-ийн дидактикийн тэнхимийн багш
Ц.Пагмасүрэн	МУБИС, МБУС-ийн дидактикийн тэнхимийн багш
Э.Мөнгөтулга	МУБИС, МБУС-ийн дидактикийн тэнхимийн багш
Д.Энхцэцэг	МУБИС, Багшийн сургуулийн тэнхимийн эрхлэгч, Ph.D
Я.Мөнхсайхан	МУБИС, МБУС-ийн багш
Ө.Цэндсүрэн	НБСГ-ын ахлах мэргэжилтэн
М.Оюунчимэг	БМДИ, Биологийн сургалт хариуцсан арга зүйч
Ж.Энэбиш	БМДИ, Химийн сургалт хариуцсан арга зүйч
С.Отгонтуяа	БХ, эрдэм шинжилгээний ажилтан
Ж.Буянт	БМДИ-ийн математикийн сургалт хариуцсан арга зүйч
Н.Мөнхбаяр	БМДИ, СӨБББСА-ны дарга
Д.Энхтулга	БМДИ, СӨБББСА-ны математикийн сургалт хариуцсан арга зүйч
Б.Цасанчимэг	БМДИ, монгол хэлний сургалт хариуцсан арга зүйч
Ш.Оюунцэцэг	БМДИ, ХНХУСА-ны дарга
Ч.Гажиддулам	БМДИ, ХНХУСА-ны ТНУ-ы сургалт хариуцсан арга зүйч
С.Амарсайхан	БМДИ, уран зохиолын сургалт хариуцсан арга зүйч
А.Уламбаяр	БМДИ, гадаад хэлний сургалт хариуцсан арга зүйч
Б.Баттулга	БМДИ, дүрслэх урлаг, дизайны сургалт хариуцсан арга зүйч
Т.Гэрэлтуяа	БМДИ, дүрслэх урлаг, дизайны сургалт хариуцсан арга зүйч
Д.Мэндбаяр	БМДИ, Биеийн тамирын сургалт хариуцсан арга зүйч
З.Самданжамц	БМДИ, Биеийн тамирын сургалт хариуцсан арга зүйч
П.Одсүрэн	БМДИ, Бага боловсролын Монгол хэлний сургалт хариуцсан арга зүйч
Б.Нацагдорж	БМДИ, ТМА мэргэжилтэн
Б.Энхбилэг	БМДИ, ТНУ-ы сургалт хариуцсан арга зүйч
Ц.Нарантуяа	БМДИ, Бага боловсролын нийгмийн ухааны сургалт хариуцсан арга зүйч

Техникийн редактор:

Н.Оюунцэцэг	МХСН-ийн гүйцэтгэх захирал, Ph.D
Д.Энхтулга	БМДИ, арга зүйч
Ж.Буянт	БМДИ, арга зүйч
Б.Цасанчимэг	БМДИ, арга зүйч
А.Уламбаяр	БМДИ, арга зүйч
З.Самданжамц	БМДИ, арга зүйч
Ж.Энэбиш	БМДИ, арга зүйч
М.Оюунчимэг	БМДИ, арга зүйч

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Ж.Энэбиш	БМДИ, арга зүйч
М.Оюунчимэг	БМДИ, арга зүйч

НЭГ. МЭРГЭЖЛИЙН БАГИЙН ҮНДСЭН ИЛТГЭЛ

Хичээлийн судалгааны илтгэлийн онцлог

¹Ж. Энэбиш, ²М.Ганбат

¹БМДИ-ийн химийн сургалт хариуцсан арга зүйч

²МУИС-ийн ШУС, БУС-ийн багш

Хичээлийн судалгаа нь чанарын судалгааны нэг арга юм. Багшлахуйн практик үйл ажиллагаанд суурилан хийгддэг учраас хичээлийн судалгааны илтгэл нь бусад эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлээс бүтэц, агуулгын хувьд ялгаатай байна. Багш нарын илтгэлээс харахад судалгааны үр дүнд тоон анализ хийж байгаа нь түгээмэл ажиглагддаг. Гэвч хичээлийн судалгаагаар юуг судалж, багшлахуй болон суралцахуйн чанарын хувьд ямар үр дүнд хүрсэнийг тусгахгүй байна. Хичээлийн судалгааны илтгэлийн бусад эрдэм шинжилгээний илтгэлээс ялгагдах онцлог ялгааг дараах үзүүлэлтээр авч үзсэн. Үүнд: судалгааны асуудлын тавил, судалгааны арга, өгөгдөл цуглуулах арга, өгөгдлийг боловсруулах арга, үр дүнд анализ, дүгнэлт хийх, илтгэлийн томъёолол гэх мэт. Шалгуурын дагуу Монголын хичээлийн нийгэмлэгээс явуулсан эрдэм шинжилгээний бага хуралд сүүлийн хоёр жилд ирүүлсэн зарим илтгэлд чанарын анализ хийж, алдаа онооны талаар зөвлөмжилсөн болно.

Түлхүүр үг: Хичээлийн судалгаа, чанарын судалгаа

Химийн "Сайн хичээл"-д хийсэн анализын зарим үр дүнгээс

¹Ш.Сайнбилэг, ²Н.Оюунцэцэг

¹МУИС, ШУС-ийн багш, ²Доктор, МУИС, ШУС-ийн доктор, зөвлөх проф

Суурь боловсролын химийн сургалтын цөм хөтөлбөр (2014 он)-ийг хэрэгжүүлэхэд боловсролын төв байгууллагууд тодорхой үйл ажиллагааг санаачлан явуулж байна. Эдгээр үйл ажиллагааны нэг нь 2016 онд орон даяар үе шаттайгаар зохион байгуулсан туршлага солилцох зорилго бүхий "Сайн хичээл" үйл ажиллагааны улсын зөвлөгөөн юм.

Бид энэхүү илтгэлээр үндэсний түвшинд шалгарсан 6-9 дүгээр ангийн химийн "Сайн хичээл"-д хийсэн анализын үр дүнг танилцуулж байна. Судалгаанд анх заасан хичээлийн төлөвлөгөө, химийн сургалтын хөтөлбөр боловсруулсан багийн гишүүдийн санал, дүгнэлт, хичээлд ажиглалт хийсэн ажиглагчдын тэмдэглэл, сайжруулан хэвлэсэн хичээлийн төлөвлөгөө зэрэг баримт материалыг хамруулан судалж, дүгнэлт гаргасан.

Сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл санааг анги танхимын хичээлд буулган хэрэгжүүлж байгаа хичээлийг хамгийн ерөнхий утгаар нь "Сайн хичээл" гэж үздэг. 2014 оноос хэрэгжиж буй суурь боловсролын химийн сургалтын цөм хөтөлбөрийн зорилго нь сурагчдад шинжлэх ухаанч арга барил төлөвшүүлэхэд чиглэгдэж байгаа билээ. Иймд суурь боловсролын түвшний байгалийн ухааны сайн хичээлийн гол шалгуур нь шинжлэх ухаанч арга барил байх нь тодорхой юм.

Бид сайн хичээлийн төлөвлөгөөний үйлийн алхмуудад шинжлэх ухаанч арга барилыг төлөвшүүлэх хичээлийг төлөвлөдөг 5Е циклийн дагуу тойм анализ хийсэн болно.

Мөн Бодзин, Карен Беерер нарын 2004 онд боловсруулсан шинжлэх ухаанч арга барилд суурилсан байгалийн ухааны хичээлийг үнэлэх рубрикийн аргыг ашиглан нарийвчилсан судалгаа хийсэн. Энэ арга нь суралцагчид хичээлд шинжлэх ухааны үүднээс асуулт асуух, хариулах; үнэлэлт дүгнэлт өгч, тайлбарлах; томъёолох; эргэцүүлэн бодох, тайлбарын хувилбараа сонгон үнэлэх; тайлбараа танилцуулан, харилцан ярилцах гэсэн 5 багцтай бөгөөд багц тус бүрийг таван гүйцэтгэлийн түвшингээр үнэлэхээр боловсруулагдсан байдаг.

Энэхүү илтгэлд судалгааны үр дүн, тухайлбал шинжлэх ухаанч

арга барил, хичээл, сайн хичээл, судалгаат хичээл гэж юу болох талаар нэгдсэн ойлголтод хүрэх, сайн хичээлийн шинж, сайн хичээлийг бүтээж бий болгох үйл ажиллагаа, сайн хичээлийг үнэлэх арга замуудыг судлах, сайн хичээлээр дамжуулан багшлах арга зүйг хөгжүүлэх зэрэг хэрэгцээ шаардлага бий болсон талаар танилцуулна.

Түлхүүр үг: Сайн хичээл, судалгаат хичээл, шинжлэх ухаанч арга барил, хичээлийн төлөвлөгөө

Шинжлэн судлах арга зүй ба хичээлийн судалгаа

Ц.Пагмасүрэн

МУБИС, МБУС дидактикийн багш

Орчин үеийн байгалийн ухааны сургалтад шинжлэх ухааны баримтын мэдлэгийг бэлнээр дамжуулах бус, “мэдлэгийг хүн өөрийн туршлага болон үйл ажиллагаа, ялангуяа нийгмийн туршлагадаа тулгуурлан бүтээх” тухай Piaget, Dewey, Vygotsky, Freire нарын конструктивист философид тулгуурласан *шинжлэн судлах арга зүйн хандлага (scientific inquiry)* давамгайлах болжээ. 1960 онд үүсч, хөгжсөн энэ хандлага эдүгээ дэлхийн улс орнуудын байгалийн ухааны хөтөлбөрт чухал байр суурь эзлэх болжээ. Тухайлбал: Суурь боловсролын байгалийн ухааны сургалтын цөм хөтөлбөрт (2015, х-58) сурагчид шинжлэх ухаанч арга барилд суралцах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүний тулд багш нар шинжлэн судлах хичээл зохион байгуулах арга зүйн үндсийг мэддэг байх хэрэгцээ, шаардлага тулгарч байгаа юм. Хичээлийн судалгаа нь багш нарын шинжлэн судлах хичээл зохион байгуулах арга зүйг сайжруулах, улмаар “шинжлэн судлах сайн хичээл” бүтээх зорилгоор ашиглах тохиромжтой арга юм. Тиймээс шинжлэн судлах арга зүйн мөн чанар, онцлог болон хичээлийн судалгааны баг хамтран судалгаат хичээл зохион байгуулах олон улсын туршлагаас танилцуулахыг зорилоо.

Түлхүүр үг: Шинжлэн судлах, 5Е загвар, хичээлийн судалгааны зөвлөмж

Газарзүйн хичээлд сорил, туршилтын аргазүйг нэвтрүүлэх асуудалд

¹Г.Юмчмаа, ²Ц.Цэндсүрэн

¹Ph.D, МУИС-ШУС-БУС Газарзүйн тэнхим, ²БХ, СХСС-ын ЭША

Газарзүйн сорил, туршилтыг хичээлд нэвтрүүлэхэд түүний шинж чанар, онцлогийг тодорхойлох, хэрхэн хэрэглэх арга замыг боловсруулах анхны шанг татахаас энэхүү судалгааны ажил эхэлсэн билээ. Үүний тулд бидний (geographic advantage) бусдаас ялгарах онцлогийг тодорхойлж, түүндээ үндэслэн газарзүйн гэх сорил туршилтыг байгалийн ухааны бусад хичээлийн туршилтаас хөрвүүлэн газарзүйн хичээлд тусган хэрэглэх, багш нар болон сурагчдад газарзүйн дадлыг хэвшүүлэх, цаашилбал монголын газарзүйн сургалтыг дэлхийн газарзүйн боловсролын чиг хандлагатай хөл нийлүүлэхэд дэмжлэг болох, газарзүйн боловсролын чанарыг дээшлүүлэх боломжийг эрэлхийлэн судалсан ажлаа танилцуулж байна. Газарзүйн давуу талыг ухамсарласнаар, газарзүйн хичээлд сорил туршилтыг шинжлэх ухаанч арга барилд суурилан төлөвлөх, зохион байгуулах нь багшийг хичээлд судалгаатай хандах, багшийн ажлын байранд хөгжих үндэслэл болно. Үүндээ, газарзүйн үндсэн ойлголтууд, газарзүйн учир шалтгаан, газарзүйн боловсролын түүхийг тодорхойлох газар орны нэр, байрлал, шинжлэх ухааны нэр томьёонд суралцахын чухлыг орхигдуулахгүйгээр, тэнцвэртэйгээр хадгалах нь чухал юм.

Түлхүүр үг: Газарзүйн шинжлэх ухаанч арга барил, inquiry based learning, газарзүйн сорил туршилт

ХОЁР. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГАА

VI-IX ангийн сурагчдын сурах бичигтэй бие дааж ажиллах арга барилыг даалгаврын сорилын аргаар судалсан дүн

*¹С.Цогбадрах, ²Д.Алтангэрэл, ³М.Оюунчимэг
¹БХ-ийн ЭША, ²БХ-ийн ЭША, ³БМДИ-ийн арга зүйч*

Сургалтын үндсэн зорилт бол сурагчдад тасралтгүй суралцах арга барил эзэмшүүлэх явдал юм. Сургах онол, арга зүй өөрчлөгдөн шинэчлэгдэж багш зааж сургадаг, сурагч багшийн заасан зүйлийг хүлээн авч цээжлэн тогтоож, үүнийгээ шалгуулдаг хандлагаас, сурагчид өөрийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд мэдлэгээ бүтээдэг онол, арга зүй давамгайлах болсон өнөө үед суурь боловсролын цөм хөтөлбөр хэрэгжиж байгалийн ухааны судлагдахуун тус бүрээр шинжлэн судлах арга барил эзэмшихээр болсон. Иймд 6-9 дүгээр ангийн сурагчид сурах бичигтэй бие дааж ажиллах болон шинжлэн судлах арга барилыг хэрхэн эзэмшиж буй бодит түвшинг тогтоосон судалгааны үр дүнг танилцуулж байна.

Түлхүүр үг: Бие дааж ажиллах арга барил, туршилт болон дадлага ажлыг гүйцэтгэх арга барил

Хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйд олон улсын стандартыг түшиглэх боломж

¹Ц.Үрэлмаа Ph.D, ²Д.Оргилмаа,

³О.Оюунтунгалаг

¹CELPA Шалгалт Мэдээллийн Төвийн захирал

²Сантис Боловсролын Төвийн Ерөнхий Захирал

³Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтийн дэд захирал

Бүх шатны сургуулийн англи хэлний сургалтын агуулга, заах арга зүй, англи хэлний багш нарын мэргэжил, хэлний болон заах арга чадварыг сайжруулах зорилго бүхий “Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах үндэсний хөтөлбөр”, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлэх... “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” зэрэг Монгол Улсын Их Хурал, Засгийн Газраас англи хэлний боловсролын талаар баримталж буй бодлогын баримт бичгээс үзэхэд англи хэлний мэдлэгийн стандартын төвшин тогтоох үйл ажиллагааг зохион байгуулах, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлэх, сургуулиудыг олон улсын боловсролын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй болгох шаардлагатай байгаа талаар нэлээд дурдагдсан байна. Гэсэн хэдий ч мэдлэг чадварыг бодитойгоор үнэлж, дүгнэлт гаргах асуудал чухал хэвээр байсаар байна.

Үүнтэй уялдан ерөнхий боловсролын түвшинд хийгдэж буй шинэчлэлийн үйл ажиллагаанд хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйд хамгийн чухал нөлөөлөх багшийн мэргэжлийн мэдлэг чадвартай холбоотой хийгдсэн судалгааны үр дүнгийн талаар танилцуулж байна.

Хүүхдийн хөгжлийг дэмжихэд ерөнхий боловсролын түвшинд олон улсын стандартыг түшиглэн сургалтын чанарыг сайжруулах боломжийн талаар авч үзлээ.

Түлхүүр үг: Ажлын байрны англи хэлний мэдлэг чадвар, олон улсын стандарт

Эрүүл мэндийн хичээлээр эрүүл зан үйл төлөвшүүлэх нь

Б.Нарантуяа, А.Мөнхжаргал

Дорнод аймаг 8-р сургууль,

Зорилго: Эрүүл мэндийн итгэл үнэмшлийн онол, шийдвэрийн мод загварыг хослуулан ашигласан аргыг кейс дээр дүн шинжилгээ хийснээр хүүхдийн төлөвшилд хэрхэн дэмжлэг үзүүлж чадаж буйг судалгаат хичээлээр судлах, үр дүнг тооцоход оршино.

Судалгааны загвар/арга зүй/хандлага: Эрүүл мэндийн “Итгэл үнэмшил”-ийн онол, загвар дээр тулгуурлан амьдрах ухааны чадварт суурилсан эрүүл мэндийн хичээлийн агуулгаар “Шийдвэр гаргах” бүлэг сэдвийн хүрээнд агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Энэхүү “Миний шийдвэр” судалгаат хичээлээр өдөр тутмын шийдвэр, шийдвэр гаргах загвар, шийдвэрийн үр дагавар, боломжуудаа цэгнэх, хорт зуршил ба бэлгийн хавьтал, эрсдэлд үнэлгээ хийх нь, шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсийг судлах агуулгын хүрээнд амьдралын жишээ баримт дээр тулгуурласан кейс дээр ярилцан, кейсийн баатрын өмнөөс хүүхдүүд хэрхэн зөв, эрсдэлгүй шийдвэр гаргах алхам, шийдвэрийн модны загварыг ашиглан бүтээлчээр суралцахуйн үйлийг хийснээр сурагчдын мэдлэг чадварт өөрчлөлт гарч байгааг тогтоосон.

Практик ач холбогдол: Сурагчдад зөв шийдвэр гаргах чадварыг 10, 11, 12-р ангиудын спорт-эрүүл мэнд, сургалтыг дэмжих үйл ажиллагааны цагаар “Иргэний боловсрол”, “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа”, “Хичээлээс гадуурх үйл ажиллагаа” хичээлийн агуулгад оруулж үзэх боломжтой.

Шинэлэг тал/ашиг тус: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн сэдвийн хүрээнд хүсээгүй жирэмслэлт, жирэмслэлтээс хамгаалах аргууд, охидын үр хөндөлт ба төрөлтийг бууруулахад чиглэгдсэн сурагчдыг зөв шийдвэр гаргах чадварт суралцахад дэмжлэг үзүүлсэн арга зүйг ашиглан эрүүл мэндийн багш нарт шинэ санаа өгөх болно.

Түлхүүр үг: Зөв шийдвэр, судалгаат хичээл, хичээлийн судалгаа, хүүхдийн мэдлэг, чадвар, хандлага

Товч агуулга

Эрүүл мэндийн хичээл нь амьдрах чадварт суурилсан боловсрол эзэмшүүлдэгээрээ онцлог юм. Иймд багш нарт сурагчдад эрүүл харилцааг бий болгох, эрсдэлт зан үйлээс татгалзах, ухаалаг шийдвэр

гаргах зэрэг эрүүл зан үйл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга зүй бүхий хичээлийг хэрхэн чанартай зохион байгуулах вэ? гэсэн асуудал зүй ёсоор тулгарч байна.

Хүүхдэд зан үйлийг өөрчлөх онол болон итгэл үнэмшлийн онол, загвар дээр тулгуурласан арга зүйг хөгжүүлсэн хичээлийн судалгааг “Шийдвэр гаргах” бүлэг сэдвийн хүрээнд зохион байгуулж, туршин агуулга, арга зүйг хэлэлцэн сайжруулсан үр дүнг танилцуулж байна.

“Миний шийдвэр” судалгаат хичээлээр бэлгийн хавьталд орох шийдвэр гаргах, түүний эрсдэлд үнэлгээ хийх, шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсийг судлах агуулгын хүрээнд амьдралын жишээ баримт дээр тулгуурласан кейс дээр ярилцан, кейсийн баатрын өмнөөс хүүхдүүд зөв, эрсдэлгүй шийдвэр гаргах даалгаврыг боловсруулан суралцахуйн бүтээлч үйлээр дамжуулан мэдлэг чадвар эзэмшүүлэхээр төлөвлөн 2 жилийн хугацаанд 10-12-р ангийн 5 бүлэгт заан туршлаа.

Хичээлийг зохион байгуулахдаа сонгон авсан кейс буюу өгүүлэг дээр тулгуурлан “итгэл үнэмшлийн онол” болон шийдвэрийн мод, шийдвэр гаргах алхам, эвлүүлгийн загварыг хослуулсан нь сурагчдаар эргэцүүлэн бодож, түүнд хариу өгч, дүн шинжилгээ хийж, гарах үр дүнд анализ хийж, дүгнэлт гаргуулж, тэдний хүүхдийн сурах үйл явцад дэмжлэг үзүүлж чадах эсэхийг судалсан. Хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн явц ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнд багшийн зүгээс шийдвэрийн мод загварыг сайжруулах, самбарын төлөвлөлтийг хийх, багшийн бэлтгэсэн кейс нь сурагчдын суралцах үйл явцад хэрхэн дэмжлэг үзүүлж буй эсэх, мөн сурагчдын гаргасан шийдвэрийн хувилбар, гаргасан алдаа, үл ойлгосон байдал, асуултанд хэрхэн хариулсан зэргийг нарийн тооцон хэд хэдэн засан сайжруулалтыг хийв.

Ингэснээр сурагчид аюулгүй бэлгийн харилцааны давуу талыг ойлгож, эрсдлээс өөрийгөө хамгаалах, хүсээгүй жирэмслэлтийн үр дагаврыг тодорхойлж, урьдчилан сэргийлэх аргыг эзэмших мэдлэг чадварт /хандлага/ өөрчлөлт гарч байгааг тогтоосон. Судалгаат хичээл бүрийн өмнө судалгаа авахад бэлгэвчтэй бэлгийн хавьталд орох шийдвэрийг нийт сурагчдын 28-37 хувь нь гаргасан бол судалгаат хичээлийн дараа харьцангуй зөв шийдвэр гаргаж байсан сурагчдын тоо нэмэгдэж байсан ба 13-18 хувь болтлоо буурч байсан.

ГУРАВ. СУРГУУЛЬД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

Самбар, дэвтрийн бичилтээр хүүхдийг хичээлийн дэг соёлд сургах нь

Ж.Бямбасүрэн

*Булган аймаг, Хишиг-Өндөр сум БСШУСЯ-ы харьяа лаборатори
сургуулийн захирал*

Зорилго: Хичээлийн төлөвлөлт, самбарын төлөвлөлтөөр багш, дэвтрийн бичилтээр сурагч хичээлийн дэг соёлд суралцаж, төлөвших

Практик ач холбогдол: Самбар төлөвлөлт, самбарын бичилт нь хичээлийн чанарт нөлөөлж багшийн хөгжлийг илтгэдэг төдийгүй багш хүүхдийг хичээлийн дэг, соёлд сургадаг.

Шинэлэг санаа: Бэлтгэл судалгаа хийгдсэн “Самбар төлөвлөлт” нь хичээлийн судалгааг ерөнхийд нь харуулдаг төдийгүй самбарын бичилт багш хүүхдийг тодорхойдог, соёлд сургадаг

Түлхүүр үг: Самбар төлөвлөлт, самбарын бичилт, дэвтрийн бичилт, багш хүүхдийн хөгжил, хичээлийн дэг соёл.

Судалгааны арга зүй: Судалгаанд бага ангид 1-5-р ангийн 8 багш, 238 сурагч, дунд ангийн 7 бүлгийн 203 сурагч, 24 багш оролцсон. Судалгааны ерөнхий арга зүйг хичээлд сууж ажиглалт хийх, ингэхдээ голчлон анхаарч буй зүйл буюу самбарын бичилт, хүүхдийн дэвтэрт бичиж буй байдалд анхаарч ажиглах, зураг авалт хийх, баримт бичигт үзлэг хийх буюу ээлжит хичээлийн төлөвлөлтөд самбар төлөвлөсөн байдал, судалгаат хичээл зохион байгуулах зэрэг арга зүйг сонгон ажиллав.

Судалгааны үр дүн: Манай сургуулийн хувьд багш нарын ээлжит хичээлийн бэлтгэл сайжирсан, ялангуяа арга зүйн төлөвлөлт гэж бидний нэрлэдэг хичээлийн цагчилсан төлөвлөлт, хэрэглэгдэхүүний төлөвлөлт бэлтгэл сайжирсан. Багш бүр самбараа төлөвлөдөг. Ер нь уламжлалт самбарын бичилт ард үлдсэн. Одоо бид залуу багш нараа сургуулийн түвшний “Сайн хичээл үйл ажиллагааг”-аар самбарын бичилт, дэвтрийн бичилтэд сургаж байна. Боловсролын чанарын шинэчлэлд хүүхдийг зөв дадал хэвшилд сургахыг чухалчилж байгаа. Үүнийг бид ээлжит хичээл, самбараар хичээлийг хөтлөх

багшийн чадварыг хөгжүүлснээр шийдвэрлэх боломжтой гэж харж ажиллаж байгаа. Нааштай үр дүн харагдаж байгаа. 1-9-р ангийн нийт сурагчдын 80 гаруй хувь нь дэвтрийн бичилтэд суралцсан, гэсэн тоон үнэлгээ гарсан. Хүүхдүүд зөв, цэгцтэй, гаргацтай бичиж байна. Энэ бол хүүхдийн хөгжил. Хэн ч, хэзээ ч ирээд манай багш нарын хичээлд сууж үзээд үнэхээр энэ сургуулийн багш нар “Самбарт бичдэг болжээ” гэж хэлэх болно. Бүс, аймаг, улсын “Сайн хичээл үйл ажиллагаа”-нд оролцож байгаа манай багш нарын самбарын төлөвлөлт, самбарын бичилт нь бусдад туршлага болохуйц хэмжээнд үнэлэгдэж байна. Илтгэл бичигч миний бие тойргийн 8 сургуулийн багш нарт болон Булган аймгийн ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад энэхүү туршлагаа танилцуулж, багшийн хөгжилд нь дэмжлэг үзүүлсэн гэж үздэг.

Товч агуулга

Илтгэгч би 2013 онд “Хүүхдийн хөгжил-хичээлийн судалгаа” сэдэвт үндэсний анхдугаар эрдэм шинжилгээний бага хуралд 2009-2012 онд өөрийн сургуульд хичээлийн судалгааг хэрхэн явуулсан үр дүнгээ илтгэсэн “Самбарын бичилт, дэвтрийн бичилтээр багш, хүүхдийг хөгжүүлэх нь” сэдэвт илтгэлээ танилцуулсан билээ. Бидний хувьд хичээлийн судалгаа шинэ зүйл байсан. Японд олон зууныг дамжин хөгжсөн энэ соёлыг бид төслийн 3 жилд бүрэн ойлгож эзэмших боломжгүй нь тодорхой ч бид эндээс өөрийн сургуулийн багш хүүхдийн хэрэгцээ шаардлагыг судлаад самбарын бичилтийг илүүтэй чухалчилж харсан. Манай сургуулийн хувьд төслийн эхний жил “Ээлжит хичээлээр хүүхэд хөгжүүлэх” гэсэн зорилгыг дэвшүүлсэн боловч их ерөнхий байсан учир тодорхой ахиц харагдаагүй. Төслийн 2 дахь жилээс хичээлийн судалгааны сэдвээ “Самбарын бичилт, дэвтрийн бичилтээр багш, хүүхдийг хөгжүүлэх” гэж тодорхойлсон. Энэ сэдвээ бид жил бүр хөгжүүлэн дэвшүүлсээр 2013-2014 оны хичээлийн жилээс “Самбарын бичилт, дэвтрийн бичилтээр багш хүүхдийг хичээлийн дэг соёлд сургахаар дэвшүүлэн ажиллаж байна. Энэ сэдвийг сонгосон эхний жилд бид хүүхдэд ээлжит хичээл дээр мэдлэг бүтээх боломж олгохоос гадна хүүхдийн бичих, унших, ярих, сонсох чадварыг чухалчилсан. Энэ чадварыг хөгжүүлэхэд багшийн самбараар дамжуулан хүүхэд удирдах чадвар их чухал гэж үзсэн. Багшийн ээлжит хичээлийн хөтөлбөр “самбар төлөвлөлт”-ийг заавал хийхийг шаардаж, зөвлөж ажилласан. Яагаад гэвэл хүүхдүүд самбараар дамжуулан өөрийн бодол санаагаа бусадтай хуваалцах, бусдын чухал санаануудыг дэвтэртээ бичих, эргээд дэвтрийн бичилтээ харан өмнөхийг сэргээн санах боломжтой болох нь тэдний сурлагын амжилтанд нөлөөлнө гэж тооцсон. Сургуулийн түвшинд энэ сэдвийн

хэрэгжилтэд улирал тутам мониторинг хийж үзсэн. Багш нар “самбар бол тухайн хичээл дээр багш хүүхэд хоёрын аль алиных нь эзэмших талбар байх ёстойг ойлгосон. Багш хүүхдийн нийт хандлага самбарын бичилт, дэвтрийн бичилт сайжирсан боловч сайжраагүй тодорхой хэсэг байна. Самбарын төлөвлөлт хийсэн ч түүнийгээ барьдаггүй, хүүхдийн дэвтэрт бичилтгүй үлдээдэг багш нар байсаар байна. Иймээс судалгааны зорилгыг “Самбарын бичилт, дэвтрийн бичилтээр багш хүүхдийг хичээлийн дэг, соёлд сургах” чиглэлд хандуулж байна. Ерөөсөө тухайн хичээлийн толь нь багшийн самбарын бичилт, хүүхдийн дэвтрийн бичилт байна. Үүнийг бид хичээлийн дэг, соёл гэж үзэж байгаа юм.

Хичээлийн судалгааны менежментийг боловсронгуй болгох замаар сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулах нь

Л.Сувдаа,

Сэлэнгэ, Шаамар сум бүрэн дунд сургуулийн сургалтын менежер

Зорилго: Хичээлийн судалгааны менежментийг боловсронгуй болгох замаар сургуульд суурилсан хичээлийн судалгааг хөгжүүлэх

Судалгааны загвар, хандлага: Хичээлийн судалгааны төрлөөс Японы сургуулийн туршлагаар “Хамгийн түгээмэл төрөл нь сургуульд суурилсан хичээлийн судалгаа юм”. Сургуульд суурилсан хичээлийн судалгаагаар нэг сургуульд ажилладаг багш нар нэгдмэл ерөнхий зорилгыг 5-7 жилд хангах, сургуулийн эрхэм зорилгыг хөгжүүлэхээр ажилладаг туршлагыг өөрийн сургуулийн онцлогт нийцүүлэн зохион байгуулсан

Судалгааны үр дүн: 2013 оны 9 дүгээр сараас 2016 оны 5 дугаар сарыг хүртэлх хугацаанд сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулсан явц, ач холбогдлыг дүгнэж үзэхэд “тодорхой арга зүйг хөгжүүлэх хичээлийн судалгааны менежментийн загварыг /тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх хичээлийн судалгааны менежментийн загвар болон тодорхой чадвар төлөвшүүлэх багшлах арга зүйг судлах хичээлийн судалгааны менежментийн загвар/” хэрэглэн, хичээлийн судалгааг зохион байгуулснаар багш нарын арга зүйг сайжирч, сурагчдын чадвар ахисан.

Практик ач холбогдол: Нэг мэргэжлийн багш ганц байдаг хөдөөгийн хүүхэд цөөн, жижиг сургуулийн багш нар сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийх замаар арга зүйгээ хамтран

хөгжүүлэхэд илүү тохиромжтой гэдгийг практикт харуулсан.

Шинэлэг тал/санаа: Хичээлийн судалгааны менежментийг боловсронгуй болгох замаар сургалтын менежерийн ажлын байранд тавигдах шаардлага болон хичээлийн судалгаа хийхэд гүйцэтгэх үүргийн нийцлийг гаргасан. Энэ нь сургалтын менежер сургуульд дээр хичээлийн судалгааг зохион байгуулснаар үүрэгт ажлаас нь гажууд, ачаалал нэмсэн, давхардсан хүндрэл биш, ажлын байрны тодорхойлолтонд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нь сургалтын менежерт мэргэжил, арга зүйн хувьд дэмжлэг болж, багш нарт зөвлөх, багш нараа манлайлах, өөрийгөө ажлын байран дээрээ хөгжүүлэх таатай боломжийг бүрдүүлдэг.

Түлхүүр үг: Хичээлийн судалгаа, судалгаат хичээл, сургуульд суурилсан хичээлийн судалгаа, судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа, хичээлийн судалгааны менежмент, багшлахуй, суралцахуй, хичээлээр хүүхдийг хөгжүүлэх чиглэл

Товч агуулга

Сургуулийн сургалтын менежерийн зүгээс хичээлийн судалгааны менежментийг боловсронгуй болгох замаар сургуульд суурилсан хичээлийн судалгааг хэрхэн зохион байгуулж, үр дүнд хүрч болох талаар 3 хичээлийн жилийн судалгааны үр дүнг бусадтай хуваалцахаар энэхүү илтгэлийг бичлээ. Сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулснаар багш бүрийг судлаач байлгах нэг гол арга бол хичээлийн судалгаа хийх үйл явц гэдгийг багш нартаа ойлгуулсан бөгөөд сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулахад сургалтын менежер арга зүйн зөвлөгөө өгч ажиллах нь чухал юм. Сургалтын менежер арга зүйн зөвлөгөө өгч ажиллахад өөрөө хичээлийн судалгааны талаар маш сайн судалсан, бас хуримтлуулсан туршлагатай байх шаардлагатай.

Менежментэд үндэслэсэн "хичээлийн хэлэлцүүлэг" багшийн хөгжилд нөлөөлөх нь

¹Н.Азжаргал., ²Б.Чулуун-Эрдэнэ

¹Архангай аймгийн IY сургуулийн сургалтын менежер

²МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн биеийн тамирын багш

Зорилго: Багш тасралтгүй хөгжих боломжит аргуудыг судалж илрүүлэх, хичээл сургалтын үйл ажиллагаанд ажиглалт, судалгаа хийн заах арга барилд суурилсан арга зүйн хэлэлцүүлгүүдийг

менежментийн үндсэн функцийн дагуу төлөвлөн туршсан үр дүнгийн талаар хуваалцахыг зорилоо.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Багш хөгжүүлэх үйлийг менежментийн шинэ үзэл санаагаар баяжуулах, багшлах үйлд тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж, шүүмжлэлт/яагаад?/, бүтээлч/яаж?/, латериал сэтгэлгээгээр /шинэ санааг задлан шинжлэх, хатуу логик хандлага/, сэтгэх, тулгамдаж буй асуудлыг дэс дараа, зохион байгуулалттайгаар шинжлэн судлах, сайжруулах ажил дутагдаж байгаа ба энэ бүгдийг шийдэх хичээлийн ажиглалт дээр тулгуурласан онол практикийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан болно.

Судалгааны арга зүй: Мэдээлэл цуглуулах, ажиглалт судалгаа хэлэлцүүлэг, үр дүнгийн мэдээллийн аргууд, баримтад задлан шинжилгээ хийж, төлөвлөлт, туршилт, анализ хийх аргыг сонгосон. Үүнд:

- Онолын судалгааны арга
- Баримтад задлан шинжилгээ хийх арга
- Ярилцлагын арга
- Хоёр од нэг хүсэл хэлэлцүүлгийн арга
- Сургууль дундын хэлэлцүүлэг /1,2,3,4, Ирээдүй сургуулиудын бага боловсролын багш нарын хичээл үйл ажиллагааны хүрээнд хэлэлцүүлэг хийж МУБИС-ийн заах аргын багш нараас зөвлөгөө авсан/
- Нөхцөл байдлыг тодорхойлох ажиглалт, судалгааны арга
- Менежментийн үүднээс зохион байгуулах арга
- Хэлэлцүүлэх буюу сайжруулах арга /Тухайн сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг хийн цаашдын зорилгоо тодорхойлох /

Судалгааны үр дүн: Багш нар хичээлд ажиглалт хийх, тухайн ажиглах чиглэлийн хүрээнд онолын мэдлэг хуримтлуулж, шинжлэх ухаанч байдлыг судлах, харилцан хэлэлцүүлэх чадвар дутмаг байгааг ажиглан менежментийн түвшинд төлөвлөсөн хичээлийн хэлэлцүүлгээр багш нараа хөгжүүлж доорх үр дүнд хүрч байна.

- 1: Хэлэлцүүлгийн мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд багш нар:
 - Ажиглалтын явцад алив асуудлыг шүүн тунгааж бодох чадвар нь ахиж байна.
 - Үйл явдлыг бодитоор таньж, зөв үнэлэхэд идэвхтэй оролцдог болсон.
 - Одоо бид хаана байна вэ? гэдгээ тодорхойлж байна.
 - Бидний дунд юу өөрчлөгдөөд байна вэ гэдгийг харж тодруулж байна.
- 2: Хэлэлцүүлгийн явцад оролцогчид:

- Цуглуулсан мэдээллүүдээ бүтээлчээр эргэцүүлж, нэгтгэх чадвар нэмэгдэж байна.
 - Нөхцөл байдлаа мэдэрч оролцох оролцоо сайжирч байна.
 - Хаана хүрэхийг хүснэ вэ? гэдгээ хамтдаа тодорхойлдог болсон.
 - Хэлэлцүүлгийн сэдэв онол аргагүйн хувьд шинэ мэдлэг, ойлголт хандлага бий болсон.
 - Харилцан бие биеэсээ суралцаж байна.
- З: Хэлэлцүүлгээс гарах үр дүн талаасаа:
- Цаашид яах вэ? гэж хэтийн зорилгоо тодорхойлж байна.
 - Бид үүнийг хэрхэн хийж гүйцэтгэх вэ? гэж хамтын шийдэлд хүрч байна.
 - Нөөцөө хуваалцах боломж нээлттэй болсон.
 - Хамтын шийдвэр гаргах, үр дүнд хүрэх нөхцөл бололцоо бүрдэж байна.

Практик ач холбогдол: Хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа ажиглалтын хуудсуудыг /хавсралт-1/ боловсруулсан ба хэлэлцүүлгийг менежментийн үндсэн функцийн дагуу системтэй төлөвлөсөн хуваарийн дагуу /хавсралт-2/ зохион байгуулсан.

Судалгааны шинэлэг тал/ санаа:

1. Сургуульд суурилсан хичээлийн судалгааны хэлэлцүүлгийг менежментийн 5 функц, боловсролын үр дүнгийн гинжин холбоо, хөгжлийн 5 түвшингөөр хэмжээсжүүлэн зохион байгуулж удирдах нь тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлсэн.

2. Хичээлийн хэлэлцүүлгийг соёл болгон хөгжүүлэх ажлыг нийт багш нарын оролцоотойгоор зохион байгуулсан.

Түлхүүр үг: Хичээлийн хэлэлцүүлгийг менежментийн үүднээс төлөвлөх, багш мэргэжлийн тасралтгүй хөгжил,

Товч агуулга

Боловсролын шинэчлэл нь “Багш-Хичээл үйл ажиллагааг чиглүүлэгч” төдийгүй, “Багш-хэлэлцүүлэгч”, Багш-багшлах үйл ажиллагаандаа асуулт тавьж шинжлэн судлагч, “Багш-суралцагч, эрэл хайгуул хийн боловсруулан хэрэгжүүлэгч”, “Багш-өөрөө идэвхтэй хөгжигч” байхыг шаардаж байна. Багшийн мэргэжлийн үйл ажиллагаа нь зорилго зорилтоо ухамсартай тодорхойлж, хэрэгжүүлэх арга технологио боловсруулж, хэрэглэх, хэлэлцүүлэх, сайжруулахад оршино. Боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад аливаа зүйлс, юмс, үзэгдэл үйл явцыг асуултаар шинжин шүүн тунгааж хэлэлцүүлэх нь багш ажлын байрандаа хөгжих оновчтой арга бөгөөд багшийн хичээлд ажиглалт хийх, заах арга барилд суурилсан арга зүйн хэлэлцүүлгүүдийг менежментийн үүднээс төлөвлөн туршсан үр дүнгийн талаар танилцуулахыг зорилоо.

Сургуульд суурилсан хичээлийн судалгаагаар сурагчдын асуудал дэвшүүлэн шинжлэн судлах үйл ажиллагаа нь

*З.Болормаа¹, Б.Алтансарнай², С.Гэрэлмаа³, Д.Ганхуяг⁴
Багануур дүүрэг, Гүн галуутай цогцолбор сургууль*

Зорилго: Асуудал дэвшүүлэн шинжлэн судлах үйл ажиллагаа нь хүүхдийн илэрхийлэх чадварт хэрхэн нөлөөлөхийг судлах

Судалгааны арга: Судлагдахуун бүр дээр АДШС үйл ажиллагааг оновчтой зохион байгуулснаар хүүхдийн илэрхийлэх чадварт гарч буй өөрчлөлтийг 6 судлагдахууны хичээл тус бүрд судалгааг хэрэгжүүлсэн.

Судалгааны үр дүн: АДШС үйл ажиллагааг хичээлийн үе шатуудад тусгаж буй аргачлал, хүүхдийн илэрхийлэх чадварын хэлбэр, төрлүүдийг ажиглан хувилбарыг оновчтой сонгох, цаашилбал АДШС үйл ажиллагааг оновчтой хэрэглэснээр хүүхдийн илэрхийлэх чадварт гарч буй өөрчлөлт, сайн ба сөрөг талуудыг тогтоосон.

Практик ач холбогдол: Хичээлийн аль ч үе шатуудад АДШС үйл ажиллагааг оновчтой хэрэглэснээр хүүхдийн хичээлд оролцох оролцоо нэмэгдэж өөрийгөө илэрхийлэх хандлага сайжрах боломжтой. Багш өөрийн хичээлд анализ хийж аль үе шатад яаж чиглүүлснээр хүүхдийн илэрхийлэх чадварын өөрчлөлтүүдийг олж арга барилаа сайжруулах боломжтой.

Түлхүүр үг: АДШСҮА, илэрхийлэх чадвар, хичээл, судлагдахуун, багшийн арга, хандлага, өөрчлөлт, сайжруулалт

Товч агуулга

Хүүхдийн илэрхийлэх чадварыг сайжруулахад багшийн арга барил маш чухал. Багшийн арга барилд нөлөөлөх гол хүчин зүйл бол багшийн өөрийн үйл ажиллагаандаа байнга дүгнэлт хийж, туршиж, судлаж байх шаардлагатай. Багшид дэмжлэг болох үүднээс хичээлийн судалгаагаар тодорхой нэг асуудлыг хэрэгжүүлэн гарч буй өөрчлөлтөд анализ хийн сайжруулах үр дүнг тооцон ажиллах явдал юм. Сургуулийн түвшинд хичээл, судлагдахуун бүрд тодорхой нэг асуудлыг дэвшүүлэн үйл ажиллагаагаар чиглүүлэн хамтран ажилласнаар үр дүнд хүрнэ гэж үзсэний учир энэ удаагийн хичээлийн судалгааны гол тулгамдсан асуудал бол хүүхдийн илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд чиглүүллээ. АДШС үйл ажиллагааг 6 судлагдахуун дээр туршин хүүхдийн оролцоо, илэрхийлэх чадварт тандалт хийж үзлээ. Энэхүү зорилгын хүрээнд 6-10 ангийн нийт 6 судалгаат хичээлийг зааж туршлаа. Сургуульд суурилсан судалгаагаар хүүхдийн илэрхийлэх чадварыг сайжруулахад

тодорхой нэг үйл ажиллагааг сонгон хэрэгжүүлснээр хэрхэн нөлөөлж байгааг судалснаараа онцлог юм. Судалгаанаас харвал АДШСҮА-г оновчтой зохион байгуулснаар

- Хүүхдийн хичээлд оролцох идэвх, оролцоо судлагдахуун тус бүрээр 5-8 хүүхдээр ахисан
- Сул оролцдог сурагчдын өөрийгөө илэрхийлэх чадвар сайжирсан. Тухайлбал: бичих чадвар 5-6 хүүхэд, унших-3-4, ярих-3-4, үйлээр гүйцэтгэх, хэрэглэх чадвар-2-3 хүүхдээр нэмэгдсэн.
- Сайн болон дундаж оролцоотой сурагчдын хэрэглэх, үйлээр үзүүлэх, нотлох, батлах, үзэл бодлоо хамгаалах зэрэг чадварууд 2-3 хүүхдээр ахисан байна.

Багшийн чиглүүлэг, ур чадвараас хамааран асуудлыг хэр оновчтой дэвшүүлэн шинжлэн судлаж байгаагаас шалтгаалан хүүхдийн илэрхийлэх чадварт харилцан адилгүй нөлөө үзүүлж байна. Хэрвээ асуудлыг сул чиглүүлбэл, хүүхдийн илэрхийлэх чадварт гарах өөрчлөлт төдий чинээ сул ажиглагдаж байна. Тухайлбал: зөвхөн бичих, унших, асуултад хариулах хэлбэрээр илэрч сонголт цөөн, хүүхэд бүрийн онцлогт хязгаарлагдмал байдал ажиглагдаж байна.

ДӨРӨВ. СУДЛАГДАХУУНД СУУРИЛСАН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА

Сурагчдын мэдээлэл боловсруулж, тайлбарлан ярих чадварыг хөгжүүлэх нь

¹Х.Сарантуяа, ¹М.Ичинноров, ¹О.Оюунчимэг,

¹Б.Хүрэлбаатар, ¹Н.Сарангэрэл

¹Улаанбаатар, ¹Бага нуур, Гүн галуутай ЦС-ын Англи хэлний багш нар

Зорилго: Энэхүү өгүүллээр бид ээлжит хичээлд их агуулгатай унших сэдвийг богино хугацаанд хэрхэн эвлүүлгийн аргаар шийдэж болох сайжруулсан хичээлийн үр дүнг танилцуулж байна.

Судалгааны загвар: (арга зүй): Сайжруулсан хичээлийн хүрээнд бүтээлч чадварыг хөгжүүлдэг эвлүүлгийн “Jigsaw reading” аргыг бусад арга зүйтэй хослуулан төлөвлөлт бэлтгэж, ахлах ангийн 10-р ангид “Famous place” сэдвээр явуулсан болно.

Үр дүн: Энэхүү сайжруулсан ээлжит хичээл нь их хэмжээтэй текстэн мэдээллийг хурдан хугацаанд бүрэн ойлгож авах боломжийг бүрдүүлсэн, сурагчид мэдлэгийг өөрсдөө бүтээх, тайлбарлан ярих чадварыг хөгжүүлсэн хичээл болж чадсан.

Ач холбогдол: Уг судалгааны ажил нь ямар ч мэргэжлийн багш ээлжит хичээл дээрээ ашиглан сурагчдаар мэдлэг бүтээлгэх боломжтой. Мөн ажлын байрандаа хөгжих нөхцөл боломж нь хичээлийн судалгаа болон сайжруулсан хичээлээр илэрч сургууль, багш нарт гарын авлага, онол арга зүйн үндэслэл болно.

Шинэлэг тал: Өнөө үед шинэ мэдлэг чадвар, туршлагыг бий болгосноор сайжруулсан хичээлтэй, тасралтгүй хөгжиж буй багш нар бие биеэсээ суралцах, сурагчид харилцан мэдээлэл солилцож мэдлэгийг өөрсдөө бүтээх боломжтой гэдгийг харуулахыг зорьсон.

Түлхүүр үг: Сайжруулсан ээлжит хичээл, “Jigsaw reading”, бүтээлчээр унших чадвар

Товч утга:

Монгол улсын засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх “Эрдэм боловсролтой Монгол хүн” мөрийн хөтөлбөрийн 3-р бүлэгт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор БШУ-ны сайдын 2012-11-22 ний А/136 тоот тушаалаар батлагдсан “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд 3-р үе шат буюу 2014-2016 онд хэрэгжих

“Багш өөрийгөө хөгжүүлэх, мэргэших, ур чадвараа сайжруулснаар боловсролын чанарт эерэг өөрчлөлт гарах үе шат” үргэлжилж байна. Иймээс сурах үйлийг хамтын хүчээр ажлын байран дээрээ багш өөрийгөө хөгжүүлж, танин мэдэхүйн үйл ажиллагааг явуулах нь багшийн тасралтгүй суралцах хэрэгцээг хангах арга зам юм. Багшийн тасралтгүй хөгжлийн үр дүнд 40 минутын ээлжит хичээлээр хүүхдийн чадварыг хөгжүүлэхэд оршдог. Тийм учраас эрдэмтэд хичээлийн судалгаа гэдэгт их ач холбогдол өгч “Хичээл бол багш, сурагчдыг хамарсан оюуны амьдралын чухал орчин[1] гэжээ. Багануур дүүргийн хэмжээнд хэлцэгдсэн хичээлийн судалгаа, 44 багшийн санал асуулга зэргийг үндэслэн “Jigsaw reading” арга ашиглан сурагчдаар мэдлэг бүтээлгэх англи хэлний хичээлийн судалгааг зохион байгуулав. Ийнхүү зохион байгуулсан судалгаат хичээлүүдийн нэг болох 10-р ангийн “Famous place” судалгаат хичээлээр туршсан дүнг танилцуулж байна.

Тулгуур дохионы аргаар эхийг хялбарчлах арга зүй

¹С.Батдаваа,¹ Г.Одончимэг, ¹Ч.Ариунжаргал, ¹Б.Бүжидмаа

¹Орхон аймаг, “Эрдэм” ахлах сургуулийн Англи хэлний багш нар

Зорилго: Тулгуур дохионы аргаар агуулга ихтэй эхийг хялбар аргаар, богино хугацаанд хүүхэд нэг бүрт ойлгомжтойгоор зааж, тэдний унших, бичих, ярих, сонсох, хэлзүйн хэрэглээний чадварыг нэгэн зэрэг хөгжүүлэхэд оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Уншсан эхийн гол болон туслах санааг тулгуур дохионы аргыг ашиглан хялбарчилж, богино хугацаанд суралцагчдад ойлгуулах улмаар зураглалаа ашиглан утга санааг яриулах замаар ахлах ангийн суралцагчдад хичээлийн судалгааг зохион байгуулсан.

Судалгааны үр дүн: Энэхүү аргачлалаар ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулан хичээлийн судалгааг зохион байгуулж, судалгаат хичээл зааснаар хүүхдүүд эхийг богино хугацаанд бүрэн ойлгож, гол болон туслах утга санааг бусдадаа ойлгуулан ярих, бие биенээ сонсох, хэлзүйн дүрмийг оновчтой хэрэглэх, ижил төстэй эх, өгүүлбэр зохион бичих чадварт суралцсан.

Практик ач холбогдол: Тулгуур дохионы аргыг ашиглан агуулгын багтаамж ихтэй томоохон эх бүхий ээлжит хичээлийг хүүхэд нэг бүрийг оролцуулан зохион байгуулж, тэдний англиар ярих, бичих чадварыг түлхүү хөгжүүлэх боломжтой.

Шинэлэг тал /санаа: Агуулгын багтаамж ихтэй эхийг цаг хэмнэж хүүхэд нэг бүрт ойлгуулах, эх бүхий ээлжит хичээлийг оновчтой зохион байгуулахад англи хэлний багш нарт арга зүйн дэмжлэг болно.

Түлхүүр үг: Тулгуур дохио, эх, гол болон туслах санаа, ажлын хуудас, ярих, сонсох, унших, бичих, хэлзүйн хэрэглээний чадвар

Товч агуулга:

Бид эхийг хэрхэн яаж богино хугацаанд суралцагч нэг бүрт ойлгуулах арга зүйг сайжруулах судалгааг 2014 оноос хойш хамтран хийж эхэлсэн ба дээрх хугацаанд 21 удаагийн судалгаат хичээлийг Тулгуур дохионы аргаар зааж туршлаа. Энэ удаад бид 10-р ангийн хичээлийн агуулгын хүрээнд “Language Learning Experiences” сэдэвт агуулгын багтаамж ихтэй эх бүхий судалгаат хичээлийг 10-р ангийн нийт 3 бүлгийн 75 суралцагчдад 3 удаа зохион байгуулж, хичээлийн агуулга, арга зүйг сайжруулсан талаарх өөрсдийн судалгааны ажлын үр дүнг танилцуулж байна.

Энэхүү судалгаат хичээлийн явцад суралцагчид эхийг уншиж, өөрсдөө тулгуур үгсийг ашиглан эхэд задлал хийж, утга санааг хураангуйлан, хялбаршуулсан зураглалаа ашиглан өөрийн үгээр гол болон туслах санааг илэрхийлэх, бусдыгаа сонсох чадварт суралцсан. Түүнчлэн эхийг унших явцдаа хэлзүйн дүрмийг багшийн чиглүүлэгтэйгээр тодорхойлж, түүнийгээ хэрэглээ болгон өгүүлбэр, богино цогцолбор зохиож бичих чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг болсон. Хичээлийн судалгааг зохион байгуулахын өмнө бид суралцагчдынхаа унших, уншсанаа ойлгох, ойлгосноо илэрхийлэх чадваруудын гарааг тусгай шалгуураар оношилж тогтоосны дараа өөрсдийн боловсруулсан тулгуур дохионы аргаар хичээлийн судалгааг тодорхой давтамжтайгаар зохион байгуулсны үр дүнд суралцагчдын унших чадвар гарааны түвшингээсээ 6-12%, уншсанаа ойлгох чадвар 5-10%, ойлгосноо илэрхийлэх чадвар 3-6%-иар ахисан нь хүүхэд нэг бүрийн үнэлгээний хуудаснаас харагдаж байлаа.

Бид бүхэн судалгаат хичээлийг зохион байгуулах явцдаа хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн явц, ажиглалт, хэлэлцүүлгийн үр дүнд ээлжит хичээлийн хөтөлбөрөө хэд хэдэн удаа засан сайжруулсан. Үүнд: эхээ хялбаршуулан хэлзүйн дүрмийг тусгаж өгсөн, тулгуур дохиог гаргах аргад суралцагчдыг сургасан, багшийн чиглүүлэх асуултуудыг оновчтой болгосон, ажлын хуудсыг хэлний 5 чадварт тохируулан хоорондын уялдаа холбоотойгоор боловсруулан бэлтгэсэн.

Сургалтын идэвхтэй аргуудыг ашиглан суралцагч нэг бүрийн оролцоог хангах нь

¹Д.Нансалмаа, ¹Ч. Цэрэнлхам, ¹Э.Алтанцэцэг

Орхон аймаг, Англи хэлний багш нар

Зорилго - Англи хэлний хичээлд сургалтын идэвхтэй аргуудыг ашиглах нь суралцагсдын унших, сонсох, ярих чадваруудыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд чухал төдийгүй сурагч нэг бүрийг хичээлд татан оролцуулж, мэдлэгийг өөрсдөөр нь бүтээлгэхээс гадна, хичээлийн цагийг үр дүнтэй өнгөрүүлж, багш, суралцагчдын сурах, сургах үйл ажиллагаанд эерэг үр дүн гарч байгаад дүн шинжилгээ хийхэд оршино.

Судалгааны загвар /арга зүй/: Бэлтгэл судалгааны хүрээнд ЕБС-ийн 9-р ангийн ээлжит хичээлийн арга зүйг оновчтой боловсруулан “Clothes in the past”/хуучин загварын хувцас/ сэдвээр хичээлийн судалгааг явуулж, дахин сайжруулж хэрэгжүүлсэн үр дүнгээ танилцуулж байна.

Судалгааны үр дүн: Энэхүү судалгаат хичээлээр сургалтын идэвхтэй аргуудаас оновчтой сонгон хичээлд хэрэглэх нь сурагчдыг ганцаар, багаар, хосоор ажиллах, бие даан мэдлэг бүтээхэд сургахаас гадна, тэдэнд онолын мэдлэгээ хэрэглээ болгох чадвар суулган, хичээлд оролцох идэвх сонирхлыг нь нэмэгдүүлэх боломжтойг олж харсан.

Практик ач холбогдол: Энэхүү хичээлийн судалгаагаар багш нь сургалтын идэвхтэй аргуудаас оновчтой сонгон хэрэглэснээр хичээлээ цөм хөтөлбөртэй уялдуулан зааж, сурагч нэг бүрийг хичээлд хэрхэн бүтээлчээр татан оролцуулж байгааг болон сургалтын хэрэглэгдэхүүнийг гарын доорх материал ашиглан бүтээлчээр бэлдэж байгаад суралцах чухал ач холбогдолтой.

Шинэлэг тал /ашиг тус: Гадаад хэлний хичээлийг өртөөчлөх маягаар өртөө бүр дээр өөр өөр сургалтын идэвхтэй арга зүй ашиглан явуулах нь суралцагч бүрийг хичээлд татан оролцуулахаас гадна богино хугацаанд тэднээр олон даалгаврыг зэрэг, бүтээлчээр гүйцэтгүүлж байгаад оршино.

Түлхүүр үг: Хичээлийн судалгаа, багшийн арга зүй, сургалтын идэвхтэй арга, хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, идэвх сонирхол, сурлагын ахиц, амжилт

Товч агуулга:

Сүүлийн гурван жилийн хугацаанд хичээлийн судалгаагаар анги зохион байгуулалтыг өртөөчилсөн хэлбэрээр зохион байгуулж, өртөө бүр дээр өөр өөр сургалтын идэвхтэй аргуудыг ашиглан суралцагчдаар богино хугацаанд нэгэн зэрэг олон бүтээлч даалгавруудыг хийлгэх боломжтой арга зүйг туршин хэрэгжүүлж байна. Хичээлийн судалгааг хэрэгжүүлснээр суралцагчид гадаад хэлний хичээл дээр өөрсдийгөө голохгүй, ичиж зовохгүй, санаа бодлоо нээлттэй, чөлөөтэй ярьж, хүүхэд бүрийн хичээлд оролцох идэвх сонирхол нь нэмэгдэхээс гадна өөртөө итгэлтэй, бүтээлчээр даалгавраа гүйцэтгэх хүсэл сонирхолтой болж байгаагаараа онцлог юм. 9-р ангийн Англи хэлний хичээлд хэрэгжүүлж “Clothes in the past” буюу “Хуучин загварын хувцас” сэдвийг /Сурагчдын унших, ярих, сонсох чадварыг хөгжүүлэн хувцасны нэрсийг цээжлүүлж, өнгөрсөн цагийн “Used to” дүрмийг ашиглан 1950-2016 оны хоорондох хувцас загварын талаар яриулж сургах зорилготой судалгаат хичээлээр сургалтын идэвхтэй аргуудаас хичээлийн хэсэг тус бүр дээр хэрхэн туршиж ашигласан арга зүй, үр дүнг энэхүү илтгэлд тусгасан болно. Өртөөчилсөн хэлбэрээр баг бүрт өөр өөр даалгавруудыг оновчтой арга зүйгээр өгч, ижил хугацаанд гүйцэтгүүлснээр сурагч бүрийн оролцоо нэмэгдэж хөгжихөөс гадна хичээлийн үр дүнд эерэг өөрчөлтүүд гарч байна. Тухайлбал: Багш бид өмнө нь гурван багтай, нэг даалгавар нь таван минутанд гүйцэтгэх хоёр ажилтай алхам байлаа гэхэд арван минутанд гурван баг хоёрхон ажил хийнэ гэсэн үг. Тэгвэл судалгаат хичээлээр багш арга зүйгээ өөрчлөн сургалтын идэвхтэй аргуудыг ашиглан гурван баг тус бүрд хоёр өөр даалгаврыг гурван өөр арга зүйгээр гүйцэтгүүлж, сурагчид нийт зургаан даалгаврыг зургаан өөр арга зүйгээр арван минутанд биелүүлж байгаагаас үзэхэд багшийн оновчтой хэрэглэсэн сургалтын идэвхтэй аргууд сурагчийн хөгжилд хэрхэн чухал нөлөө үзүүлж байгааг харж болно.

5 алхамт эсээ бичлэгийн аргаар суралцагчдын бичих чадварыг хөгжүүлэх арга зүй

Б.Сувдаа

Өмнөговь аймаг, Цогтцэций сум, 6 дугаар сургуулийн
Англи хэлний багш

Зорилго: Эсээ бичих энгийн алхамууд болон “5 алхамт эссе —ний арга” нь суралцагчдын бичих чадварыг дээшлүүлэхэд хэрхэн дэмжлэг

үзүүлж буйг судлан үр дүнг тооцоход оршино.

Судалгааны загвар арга зүй хандлага: 9-р ангид энгийн болон 5 алхамт эссэ бичлэгийн аргыг ашиглан “Around the world” “бүлэг сэдвийн хүрээнд ‘My favorite food’”, 11-р ангид “My favorite pet”, 12-р ангид “Why English is important” сэдвээр эх бичих судалгаат дөрвөн хичээлийн арга зүйг сайжруулан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Энгийн хялбар аргаар өөрийн үзэл бодлыг зөв, цэгцтэй илэрхийлэх чадварт суралцан, суралцагчдын бичих чадварт ахиц гарч, оролцоо нэмэгдэн, масстай болж байгааг тогтоосон.

Практик ач холбогдол: Энгийн болон 5 алхамт эссэ бичлэгийн загвар нь суралцагчдыг анхан шатнаас эхлэн ахисан төвшний эссэ хүртэл бичих дадалтай болоход ач холбогдолтой тул багш, сурагчдад хичээлдээ хэрэглэхэд хялбар, оновчтой арга тул эссэ бичихэд гарын авлага болгон ашиглах боломжтой. Багш нарт хичээлдээ хэрэглэн сурагчдын чадварыг дээшлүүлэхэд ач холбогдолтой. Суралцагчдын нэлээд хэсэг нь өөрийн CV-г хэрхэн бичих талаар анхан шатны дадал хэвшилтэй болсон.

Шинэлэг тал: Эсээ бичих хялбар алхмуудыг ашиглан өөрийн санаа бодлыг англи хэлээр чөлөөтэй илэрхийлэн, бичих чадвараа нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Түлхүүр үг: Бэлтгэл судалгаа, судалгаат хичээл, эсээний энгийн томьёо, 5 алхамт эссэ бичлэгийн арга, суралцагчдын хөгжил, word wall

Товч агуулга: Эсээ бичих энгийн болон 5 алхамт аргыг ашиглан 9а, 11а, 12б ангиудад хичээлийн судалгааг зохион байгуулж, суралцагчдын хөгжлийг дэмжсэн талаар өөрийн судалгаат хичээлийн үр дүнг танилцуулж байна.

Хөтөч санааг баримтаар дэмжих арга зүйгээр ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг дэмжих нь

С.Энхжаргал

Хөвсгөл аймаг, “Сод Эрдэм” ахлах сургуулийн Монгол хэлний багш

Зорилго: Амьдралын аливаа асуудлыг олон талаас харж, үнэлж шийдвэр гаргахдаа өөрийн байр суурийг баримт нотолгоогоор дэмжин, бусдад нөлөөлөх үйл нь ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшилд дэмжлэг үзүүлж чадаж буйг судалгаат хичээлээр судлах, үр дүнг тооцоход оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Уран сайхны эсээ /ятган итгүүлж /1// бичих агуулгын хүрээнд эх хэл бичгийн шалгалтад бэлтгэж буй 12-р ангид “Хөтөч санаа /түлхүүр өгүүлбэр/- г баримтаар дэмжих нь” сэдэвт хичээлийг зааж агуулга, арга зүйг сайжруулан хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Энэхүү хичээлийн судалгаагаар уран сайхны эсээний хөтөч санаа /түлхүүр өгүүлбэр/-г өгөөд түүнийг дэмжсэн баримтыг гаргах аргыг туршин сайжруулсан. Энд асуудлыг олон талаас харж өвөрмөц сэтгэх түүнийг дэмжсэн нотолгоо гаргах, нотолгоо баримтаас няцааж үгүйсгэх боломж багатайг сонгох арга зүй зонхилсон. Энэ нь хүүхдийн тогтсон хэвшмэл сэтгэлгээг өөрчилж, бүтээлч, шугаман бус сэтгэлгээгээр/1/ төлөвшүүлэх, мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг болж байгааг судалж тогтоосон болно.

Практик ач холбогдол: Хүүхэд амьдралыг, аливаа асуудлыг бусдаас өөрөөр харах, тэрхүү үзэл бодлоо хамгаалах, өөртөө итгэлтэй байх, өөрийн үзэл бодолдоо бусдыг нэгтгэх, өөр байр сууринаас бусдыг ойлгох гэсэн чадвар, төлөвшлийн олон эерэг нөлөөтэй.

Шинэлэг тал /ашиг тус: Зөвхөн эсээ бичихэд бус бусад хичээлд асуудлыг хийсвэр сэтгэлгээний үүднээс олон талтай авч үзэх, тогтсон нэг хэвшмэл сэтгэлгээнээс давж аливаад баригдахгүй чөлөөтэй сэтгэх боломжоор хангахад чиглэж байгаа.

Нөгөө талаас монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарт хүүхдээр эсээ бичүүлэхдээ хялбар бөгөөд үр дүнтэй аргыг боловсруулан хичээлдээ ашиглах санааг өгөх явдал юм.

Түлхүүр үгс: Эсээ, хүүхдүүд, судалгаат хичээл, хичээлийн судалгаа мэдлэг, чадвар, төлөвшил

Товч агуулга:

Уран сайхны эсээ бичих агуулгын хүрээнд 12-р ангид “Түлхүүр

өгүүлбэрийг баримтаар дэмжих арга зүйгээр ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг дэмжих нь” судалгаат хичээлийг зохион байгуулж түүний агуулга аргазүйг сайжруулан үр дүнг нь танилцуулж байна.

2015-2016 оны хичээлийн жилд 12-р ангид монгол хэл уран зохиолын сургалтын хөтөлбөр, эх хэл бичгийн шалгалтын бэлтгэлийн шаардлагын дагуу эсээ бичвэрийн хичээл орж эхэлсэн. Ингээд нэгжийн өмнө ангийн 32 сурагчид гарааны үнэлгээ хийж үзэхэд бүгд хувилаад олшруулсан юм шиг нэг загварын, ямар ч бүтэц, сэтгэлгээний эрэл хайгуул үгүй, эмх замбараагүй, үгийн тоонд хүргэхийн тулд нэг санааг олон давтсан, бичвэрийн аль ч төрөлд хамааруулж боломгүй зүйл бичсэн байлаа. Эсээний бүтэц, хэл найруулга, дэвшүүлсэн санаа гээд бүхий л шалгуурт дундаж үнэлгээ авсан нэг ч бичвэр байгаагүй нь эсээ бичүүлж сургах хялбар бөгөөд үр дүнтэй аргын эрэлхийлэл болсон юм. Үүний хүрээнд эсээ бичүүлж сургах арга зүйг судлан боловсруулаад 10 цагийн агуулга бүхий нэг нэгж хичээлийг бэлтгэн 12 дугаар ангийн 3 бүлэгт туршин зааж үзсэн.

Уг нэгжийг:

1. Эхний 2 цагт уран сайхны эсээ задлах замаар эсээний бүтцийг ойлгох
2. Дараагийн 4 цагт өөрийн үзэл бодол, байр сууриа баримт нотолгоотойгоор илэрхийлэх энгийн аргаар түлхүүр өгүүлбэр, түүнийг дэмжсэн баримтыг гаргах.
3. Дараагийн 2 цагт эсээний эхлэл, цогцолборын толгой өгүүлбэр, цогцолборын дүгнэлт, ерөнхий дүгнэлт, зохиогчийн санааг бичиж эсээг эмхлэх
4. Сүүлийн 2 цагт бичсэн эсээг үнэлэх

гэсэн дэс дарааллаар хэрэгжүүлсэн. Би өөрөө эсээ бичих болон хүүхдээр бичүүлэхдээ эхнээс нь биш хөтөч санаанаас эхэлж бичээд дараа нь түүнийг дэмжих баримтыг олох, эцэст нь эхлэл төгсгөл болон бусад хэсгүүдийг бичиж эмхлэх арга зүйг ашигладаг. Ерөнхийдөө эсээ бичүүлж сургах энэхүү 10 цагийн ээлжит хичээлээр сурагч анхан шатны ойлголт, арга зүйтэйг эзэмшихээс бүрэн гүйцэт бичиж сурна гэсэн үг биш. Ийнхүү цааш давтан бичсээр арга зүйгээ бүрэн эзэмшихээр нь задгай хэлбэрээр бичих арга зүйд сургадаг. Эсээ бичүүлэх энэхүү үйл нь мэдлэг, чадвар, төлөвшилд дэмжлэг үзүүлж ахиц өөрчлөлт гаргахын зэрэгцээ гарааны үнэлгээг нэгжийн үнэлгээтэй харьцуулахад бүтэц- 38%, дэвшүүлсэн асуудал, шинэ санаа- 41%, хэл найруулга- 11% ахисан үзүүлэлт гарсан. Үүнээс хойш сурагчид мэдлэг, чадвараа бататгаж багшийн зөвлөгөөний дагуу бие дааж эсээ бичих болсон нь энэхүү арга үр дүнтэй байсны нэгэн баталгаа юм./Хавсралт 1-а,б,в,г,д,ж,з,и/

"Сайн хичээл"-ийн хөтөлбөрүүдэд хийсэн судалгаа (Бага боловсролын монгол хэл)

*Д.Ганболд МУБИС, БС
ganbold_taij@yahoo.com*

Зорилго: ЕБС-ийн багш нар, судлаачид, багш мэргэжлээр суралцаж буй оюутнууд, нийгмийн хариуцлагатай оролцогч болон сонирхогч талуудыг мэдээллээр хангах зорилго бүхий веб сайтуудын агуулга (хичээлийн хөтөлбөр) нь хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхэд судалгаа хийж, сайжруулах арга замыг тодорхойлох

Судалгааны арга зүй: Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн <http://teacher.sur.mn/> вэб сайтад байрлаж буй хөтөлбөрүүдийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх

Судалгааны үр дүн: Бага боловсролын түвшинд боловсруулагдаж буй ээлжит хичээлийн хөтөлбөрийн арга зүйн хөгжлийг судлан, хөтөлбөрийн үнэлгээний арга зүйг боловсруулан туршиж, үнэлгээний хуудас (Check list) боловсруулсан.

Практик ач холбогдол: Хөтөлбөрийн үнэлгээний хуудастай болсноор багш нар болон багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнууд тухайн хөтөлбөртөө үнэлгээ хийж, багшлахуйг сайжруулах, суралцахуйг дэмжих арга боловсруулах боломж бүрдэнэ.

Шинэлэг тал: Хөтөлбөрийг үнэлэх үнэлгээний хуудас (Check list) боловсруулсан.

Түлхүүр үг: Ээлжит хичээлийн хөтөлбөр, вэб сайтад буй агуулга, үнэлгээний хуудас (Check list), арга зүйн баримт бичиг, сайн хичээл

Товч танилцуулга

Хөтөлбөр(curriculum) бол боловсролын зүрх бөгөөд нэг талаас юу заах тухай асуудал байдаг бол нөгөө талаас бодол, үйлдэл, зорилгын нэгдэл юм. (Null, 2010)

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн <http://teacher.sur.mn/> вэб сайтад 16365 хичээлийн хөтөлбөр байгаа бөгөөд үүнээс 1298 нь бага боловсролын Монгол хэлний хичээл байна. Эдгээрээс 50 хөтөлбөрт судалгаа хийлээ.

Дээрх хөтөлбөрийг боловсруулсан багш нар, хамт олныг шүүмжлэх гэсэн зорилго байгаагүй гэдгийг тэмдэглэн хэлэхийг хүсэж байна. Харин олон мянган хэрэглэгчдэд нээлттэй байдаг сайт дээр байрлуулж байгаа бүтээл(агуулга)-ийг мэргэжлийн байгууллага, хамтлаг, багууд хянах, тодорхой хэмжээний шалгуурыг гаргаж шаардлага хангасан мэдээллийг түгээн дэлгэрүүлбэл илүү үр дүнтэй гэж үзэж байна. Энэ бол сайн хичээлийн эцсийн үр дүн юм.

“Өөрийгөө бүтээхүй” эх зохион найруулах арга зүй

*¹Д. Дэлгэрмаа, ¹Б.Бүжинлхам, ¹С.Тэгшдүүрэн, ¹Г.Нямзаяа
Дархан-Уул аймаг, Дархан сум, “Од цогцолбор” сургуулийн монгол
хэлний багш нар*

Зорилго: “Өөрийгөө бүтээхүй” эх зохион найруулах аргаар сурагчдын зохион найруулах чадвар болон хөгжил төлөвшилд хэрхэн нөлөөлж байгааг судалгаат хичээлээр судлах, үр дүнг тооцоход оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: “Өөрийгөө бүтээхүй” эх зохиох аргаар 8-р ангид “Дүрслэн тайлбарласан эх бичих”, 9-р ангид “Баримтыг дүрслэлээр илэрхийлэн эх зохион бичих” гэсэн хоёр судалгаат хичээлийн агуулга, арга зүйг сайжруулан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Энэхүү хичээлийн судалгаагаар сурагчид зохиох эхийн бүтцээ хүний биеийн харьцаатай холбож, оюуны зураглал хийснээр бүтэц агуулгаа төлөвлөх, эхийн харьцааг зөв гаргах, уран дүрслэл, хэлц, баримт ашиглан санаагаа уран яруу илэрхийлж, зохион найруулж бичих зэрэг бүтээлчээр суралцахуйн үйлийг хэрэгжүүлснээр сурагчдын мэдлэг чадварт ахиц гарч байгааг тогтоож судалж байна.

Практик ач холбогдол: “Өөрийгөө бүтээхүй” эх зохиох аргыг 6-12 ангийн монгол хэл, уран зохиол, нийгмийн ухааны болон гадаад хэлний хичээл дээр эх зохион найруулахад энэ аргыг хэрэглэх боломжтой.

Шинэлэг тал: Эхийн агуулгын бүтцийг хүний биеийн харьцаатай зүйрлэн эхийн эхлэл гол төгсгөл хэсгийг өнгөөр ялган бичүүлж, уран дүрслэлийг монгол үндэсний хувцас, чимэг зүүлттэй адилтган авч үзнэ.

Түлхүүр үг: хүүхэд, арга зүй, эхийн бүтэц, агуулга, уран дүрслэл, чадвар, төлөвшил, судалгаат хичээл.

Товч агуулга:

“Өөрийгөө бүтээхүй” эх зохиох аргаар 9,10-р ангид “Дүрслэн тайлбарласан эх бичих” сэдвээр судалгаат хичээлүүд заалаа. Хичээлийн агуулга, арга зүйг хэрхэн сайжруулсан талаар өөрсдийн судалгаат хичээлийг танилцуулж байна.

Энэхүү судалгаат хичээл нь сурагчдыг эхийн агуулгын бүтцийн дагуу, уран яруу дүрслэлтэй эх зохион найруулах чадвар эзэмшүүлэх зорилготой.

Бид судалгаат хичээлээрээ хүүхдийг эх зохион найруулах аргад сургахын тулд эхийн агуулгын бүтцийн харьцааг зөв гаргуулж, өнгөөр ялган бичүүлж, уран дүр, дүрслэл, хэлц үгийг ашиглан зохион найруулж бичүүлж байна. Сүүлийн 2 жилд 9,10 дугаар ангийн 67 сурагчид нийт 10 цагийн судалгаат хичээлийг зааж туршлаа. Үүний дүнд сурагчдын зохион найруулах чадварт үгийн тоогоо зөв баримжаалах, оюуны зураглал хийх, эхийн бүтцээ зөв гаргах, дүрслэх ур маяг, хэлц үгийг ашиглах, өөрийн бодол санаагаа цэгцтэй зөв илэрхийлэх, үгээ зөв сонгон найруулах зэргээр сурагчдын бичих чадварт ахиц гарч байна.

Сурагчдаа хөгжүүлэх, аргаа бататгах зорилгоор 2015 оны 10-12 дугаар сард 8а, 8е ангийн 59 сурагч, 9а, 9б ангийн 57 сурагч, 2016 онд 8б, 8в ангийн 6б, 9а, 11д ангийн 58 сурагч, давхардсан тоогоор 240 сурагчид уг аргаар “Дүрслэн тайлбарласан эх бичих”, “Баримтыг дүрслэлээр илэрхийлэн эх зохион бичих” сэдвээр хичээл заалаа.

Хүүрнэл зохиолын сэдэв, гол санааг тайлбарлах арга зүй

*¹Б.Буяннэмэх, ¹Н.Дэлгэрмаа, ¹Б.Бямбасүрэн, ¹Г.Оюунаа,
¹П.Өлзиймаа, ¹Д.Цэрэнбат, ¹Н.Дэлгэржаргал
¹Завхан Улиастай Чандмань-Эрдэнэ лаборатори сургууль
багш нар*

Зорилго: - Хүүрнэл зохиолын сэдэв, гол санааг зөв тодорхойлж, тайлбарлаж сургах ямар арга зүй байж болохыг эрэлхийлж, түүнийг туршин хэрэгжүүлж, үр дүнг тооцох

Судалгааны загвар \арга зүй\ хандлага: - Хичээлийн судалгааны ерөнхий арга зарчим дээр тулгуурлан судалж буй асуудлаа хөгжил, хөдөлгөөнд нь цогц байдлаар судлахдаа

- Үйлийн судалгааны арга
- Ажиглалтын арга
- Анализ синтезийн аргыг ашиглалаа.

Судалгааны үр дүн: — Үлгэр, өгүүлэг зэрэг хүүрнэл зохиолын сэдэв гол санааг дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдэл, зан төрх зэрэг дэлгэрэнгүй задлал хийж, түүнээс ургуулан тодорхойлж тайлбарлавал хүүхдэд энгийн ойлгомжтой, хялбар болох нь харагдаж байлаа.

Практик ач холбогдол: — Бага ангиас дунд ангид дэвшин суралцаж байгаа хүүхдүүдийн өмнөх мэдлэг чадвар дээр тулгуурлан тэдэнд хүндрэл бэрхшээлгүйгээр зохион байгуулсан.

Шинэлэг санаа: — Зохиолын сэдэв, гол санааг тайлбарлах

чадваруудыг бага дунд ангийн залгамж холбоон дунд нь авч үзэн, түүний үзэл санааны дагуу заах арга зүйг боловсруулан, туршиж хэрэгжүүлсэн.

Түлхүүр үг: – дүрийн задлал, зохиолын сэдэв, гол санаа

Товч утга: – Зохиолын сэдэв, утга санааг тодорхойлж тайлбарлах тал дээр багш бүр өөр өөрийн арга зүйтэй ч гэсэн шинэчилсэн сургалтын цөм хөтөлбөрийн үзэл санаанд нийцүүлэн түүнийгээ өөрчлөх шаардлага бий болж байна. Үүний тулд цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамж, багшийн ном зэргийг судалж зохиолын сэдэв, агуулгыг хэрхэн заах талаар тусгасныг үзэж, түүн дээр тулгуурлан зохиолын дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдэл, зан төрх дээр тулгуурлан үлгэр, өгүүллэг зэрэг бага хэмжээний хүүрнэл зохиолын сэдэв, гол санааг тайлбарлах арга зүйг туршин хэрэгжүүлж, үр дүнг тооцон ажиллалаа. Хичээлийн бэлтгэл судалгааны үе шатанд эхлээд бага дунд ангийн цөм хөтөлбөрт эхийн, зохиолын сэдэв, агуулга утга санааг эзэмшүүлэх суралцахуйн зорилтын хүрээнд ямар чадваруудыг энгийнээс өргөсөн гүнзгийрэх байдлаар яаж төлөвлөсөн болохыг босоо тогтолцоонд судлан гаргасны дараа суралцахуйн энэ зорилтыг өмнө нь хэрхэн зааж байсан арга туршлагаа АНУ-аас эхтэй үйлийн судалгааны алхмаар дүгнэн шинжилж, ямар арга зүйгээр хэрэгжүүлбэл оновчтой болохыг шийдэж, түүний дагуу хичээлийг зохион байгуулсны үр дүнд зохиолын сэдэв гол санааг уялдаа холбоотой, тодорхой үйл алхмын дагуу, энгийн хялбар байдлаар оновчтой тодорхойлж чадаж байлаа.

Хөтөч санаа /түлхүүр өгүүлбэр/-г баримтаар дэмжих арга зүйгээр ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг дэмжих нь

С.Энхжаргал

Хөвсгөл аймгийн Сод-Эрдэм ахлах сургуулийн багш

Зорилго: Амьдралын аливаа асуудалыг олон талаас харж, үнэлж шийдвэр гаргахдаа өөрийн байр суурийг баримт нотолгоогоор дэмжин, бусдад нөлөөлөх үйл нь ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшилд дэмжлэг үзүүлж чадаж буйг судалгаат хичээлээр судлах, үр дүнг тооцоход оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Уран сайхны эсээ /ятган итгүүлж /1// бичих агуулгын хүрээнд эх хэл бичгийн шалгалтанд бэлтгэж буй 12-р ангид “Хөтөч санаа /түлхүүр өгүүлбэр/- г баримтаар дэмжих нь” сэдэвт хичээлийг зааж агуулга, арга зүйг сайжруулан

хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Энэхүү хичээлийн судалгаагаар уран сайхны эсээний хөтөч санаа /түлхүүр өгүүлбэр/-г өгөөд түүнийг дэмжсэн баримтыг гаргах аргыг туршин сайжруулсан. Энд асуудлыг олон талаас харж өвөрмөц сэтгэх түүнийг дэмжсэн нотолгоо гаргах, нотолгоо баримтаас няцааж үгүйсгэх боломж багатайг сонгох арга зүй зонхилсон. Энэ нь хүүхдийн тогтсон хэвшмэл сэтгэлгээг өөрчилж, бүтээлч, шугаман бус сэтгэлгээгээр/1/ төлөвшүүлэх, мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг болж байгааг судалж тогтоосон болно.

Практик ач холбогдол: Хүүхэд амьдралыг, аливаа асуудлыг бусдаас өөрөөр харах, тэрхүү үзэл бодлоо хамгаалах, өөртөө итгэлтэй байх, өөрийн үзэл бодолдоо бусдыг нэгтгэх, өөр байр сууринаас бусдыг ойлгох гэсэн чадвар, төлөвшлийн олон эерэг нөлөөтэй.

Шинэлэг тал/ашиг тус: Зөвхөн эсээ бичихэд бус бусад хичээлд асуудлыг хийсвэр сэтгэлгээний үүднээс олон талтай авч үзэх, тогтсон нэг хэвшмэл сэтгэлгээнээс давж аливаад баригдахгүй чөлөөтэй сэтгэх боломжоор хангахад чиглэж байгаа.

Нөгөө талаас монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарт хүүхдээр эсээ бичүүлэхдээ хялбар бөгөөд үр дүнтэй аргыг боловсруулан хичээлдээ ашиглах санааг өгөх явдал юм.

Түлхүүр үгс: Эсээ, хүүхдүүд, судалгаат хичээл, хичээлийн судалгаа мэдлэг, чадвар, төлөвшил

Товч агуулга

Уран сайхны эсээ бичих агуулгын хүрээнд 12-р ангид “Түлхүүр өгүүлбэрийг баримтаар дэмжих арга зүйгээр ахлах ангийн сурагчдын мэдлэг, чадвар, төлөвшлийг дэмжих нь” судалгаат хичээлийг зохион байгуулж түүний агуулга аргазүйг сайжруулан үр дүнг нь танилцуулж байна.

2015-2016 оны хичээлийн жилд 12-р ангид монгол хэл уран зохиолын сургалтын хөтөлбөр, эх хэл бичгийн шалгалтын бэлтгэлийн шаардлагын дагуу эсээ бичвэрийн хичээл орж эхэлсэн. Ингээд нэгжийн өмнө ангийн 32 сурагчид гарааны үнэлгээ хийж үзэхэд бүгд хувилаад олшруулсан юм шиг нэг загварын, ямар ч бүтэц, сэтгэлгээний эрэл хайгуул үгүй, эмх замбараагүй, үгийн тоонд хүргэхийн тулд нэг санааг олон давтсан, бичвэрийн аль ч төрөлд хамааруулж боломгүй зүйл бичсэн байлаа. Эсээний бүтэц, хэл найруулга, дэвшүүлсэн санаа гээд бүхий л шалгуурт дундаж үнэлгээ авсан нэг ч бичвэр байгаагүй нь эсээ бичүүлж сургах хялбар бөгөөд үр дүнтэй аргын эрэлхийлэл болсон юм. Үүний хүрээнд эсээ бичүүлж сургах арга зүйг судлан боловсруулаад 10 цагийн агуулга бүхий нэг нэгж хичээлийг бэлтгэн 12 дугаар ангийн 3 бүлэгт туршин зааж үзсэн. Уг нэгжийг:

1. Эхний 2 цагт уран сайхны эсээ задлах замаар эсээний бүтцийг ойлгох
2. Дараагийн 4 цагт өөрийн үзэл бодол, байр сууриа баримт нотолгоотойгоор илэрхийлэх энгийн аргаар түлхүүр өгүүлбэр, түүнийг дэмжсэн баримтыг гаргах.
3. Дараагийн 2 цагт эсээний эхлэл, цогцолборын толгой өгүүлбэр, цогцолборын дүгнэлт, ерөнхий дүгнэлт, зохиогчийн санааг бичиж эсээг эмхлэх
4. Сүүлийн 2 цагт бичсэн эсээг үнэлэх

гэсэн дэс дарааллаар хэрэгжүүлсэн. Би өөрөө эсээ бичих болон хүүхдээр бичүүлэхдээ эхнээс нь биш хөтөч санаанаас эхэлж бичээд дараа нь түүнийг дэмжих баримтыг олох, эцэст нь эхлэл төгсгөл болон бусад хэсгүүдийг бичиж эмхлэх арга зүйг ашигладаг. Ерөнхийдөө эсээ бичүүлж сургах энэхүү 10 цагийн ээлжит хичээлээр сурагч анхан шатны ойлголт, арга зүйтэйг эзэмшихээс бүрэн гүйцэт бичиж сурна гэсэн үг биш. Ийнхүү цааш давтан бичсээр арга зүйгээ бүрэн эзэмшихээр нь задгай хэлбэрээр бичих арга зүйд сургадаг. Эсээ бичүүлэх энэхүү үйл нь мэдлэг, чадвар, төлөвшилд дэмжлэг үзүүлж ахиц өөрчлөлт гаргахын зэрэгцээ гарааны үнэлгээг нэгжийн үнэлгээтэй харьцуулахад бүтэц- 38%, дэвшүүлсэн асуудал, шинэ санаа- 41%, хэл найруулга- 11% ахисан үзүүлэлт гарсан. Үүнээс хойш сурагчид мэдлэг, чадвараа бататгаж багшийн зөвлөгөөний дагуу бие дааж эсээ бичих болсон нь энэхүү арга үр дүнтэй байсны нэгэн баталгаа юм.

Зургийн хичээлд оюуны зураглалын аргыг хэрэглэх нь

Б.Гэрэлчимэг

Орхон аймаг, “Ийгл” сургууль

Зорилго: Хичээлийн хөтөлбөрийн хөгжлийг судалж, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцоход оршино.

Зорилт:

- Сургалтын хөтөлбөрт харьцуулсан судалгаа хийж загварчлах
- Дүрслэх урлагийн хичээлд оюуны зураглалын аргыг хэрэглэж хүүхэд нэг бүрийн хөгжил, үр дүнг тооцох
- Судлагдахуун бүр дээр оюуны зураглалын нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан, сурагчдын ахиц амжилтыг тооцох

Судалгааны загвар/арга зүй/хандлага: Дүрслэх урлагийн хичээлд уламжлалт аргыг хэрэглэж зурсан 3а ангийн сурагчдын хүүхэд бүрийн хөгжлийг тооцож, Оюуны зураглалын аргаар зурсан хүүхэд бүрийн хөгжлийг 3б анги нийтийн гүйцэтгэлийг тооцон хоёр хичээлийн агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно.

Практик ач холбогдол: Оюуны зураглалын аргыг хичээл бүр дээр хэрэглэж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх боломжтой.

Шинэлэг тал/ашиг тус: Үндэсний уламжлал, хөгжил болон даяаршлаас үүдэлтэй, соёл нийгмийн харилцааны өөрчлөлтийн өнөөгийн зааг дээр монгол хүүхдийн хөгжил төлөвшлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, өөрийн заах арга барил, ур чадвараа практикаар нотолж, шинэлэг алхмыг эрэлхийлэн, түгээн дэлгэрүүлэх

Түлхүүр үг: Оюуны зураглал, дүрслэл, бүтээлч сэтгэлгээ,

Товч агуулга

Боловсролын зорилго, үндсэн зарчим, дүрслэх урлагийн боловсролын стандарт дахь зорилгод үндэслэн монгол зураг, оюуны зураглалын холбоо хамаарлыг судлах замаар бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нэгэн арга болох оюуны зураглалаар Монгол зургийн үндсэн ухагдахуун, элементийн талаар мэдлэг олгон чадваржуулах сурагч бүр өөрийн бүтээлийг бий болгох, сурагч бүрт гарч буй хөгжил, өөрчлөлтийг бүтээлд анализ хийх замаар судлах зорилго, зорилт тавьж хэрэгжүүлсэн. Оюуны зураглалыг хэрэглэх арга зүйг “Монгол зураг” нэгж хичээлийн хөтөлбөрөөр, хэрэгжүүлсэн байдлыг сурагчдын бүтээлээр, ухагдахууны эзэмшилтийг 3а,3б-р ангийн 2 бүлгийн сурагч бүрийн гүйцэтгэлээр тооцсоноор оруулсан болно

Лаборатори туршилтаар нэхмэл материалыг таних нь – хичээлийн интеграци эхийг хялбарчлах арга зам

Я.Сэлэнгэ

Орхон аймаг, “Баян-Өндөр” ЦС, дизайн технологийн багш

Зорилго: Сургууль түшиглэсэн хичээл хоорондын уялдаа холбоо ба интеграцилах замаар лаборатори туршилтаар нэхмэл материалын гарал үүслийг таних, мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх.

Судалгааны загвар \арга зүй\ хандлага: Лаборатори туршилтийн хичээлээр “Нэхмэл материалыг таних нь” сэдвээр химийн багштай хамтран “Нэхмэл материалыг таних” ээлжит хичээлийг сорил туршилтын явцад мэдлэг бүтээлгэх аргыг ашиглан сурагчдаар химийн бодисоор таних, дизайн технологийн хичээлээр таньдаг аргуудтайгаа харьцуулан жишиж, дүгнэлт хийсэн.

Судалгааны үр дүн: “Нэхмэл материалын шинж чанарыг таних” ээлжит хичээл нь физик, механик, технологи талаас таних туршилтууд ихэнх мэргэжлийн багш хийдэг байсан бол химийн аргаар таних нөхцөл боломж муу байдаг тул химийн багштай хамтран “Хими ба амьдрал” сэдэвт хичээлтэй холбон явуулсан нь үр дүнд хүрч байна. Дизайн технологийн багш нараас судалгаа авахад химийн бодис ашиглан туршилт явуулж болох юм гэсэн санааг илэрхийлсэн байсан.

Практик ач холбогдол: Сурагчид “Нэхмэл материалыг таних” туршилт лаборатори хичээлээр уг материалын гарал үүсэл, шинж чанар, ямар түүхий эдээр хийсэн зэргийг тодорхойлон судлан таньдаг. Хичээл хоорондын холбоог бодитой гаргаж, хэрэгжүүлснээр сурагчдын мэдлэгийн хүрээг цэгцтэй, нягтралтай болгон нэг сэдвийг олон талаас нь танин мэдэх, хэрэглээ хэрэгцээ болгон ашиглахад дөхөм болж байна. Сурагчдын бие даан ажиллах практик ажлын цагийг нэмэгдүүлэх боломж бүрэлдэнэ. Сорилын явцад мэдлэг бүтээлгэх аргаар химийн бодис ашиглан нэхмэл материалыг таньсан нь сурагчдад сонирхолтой байсан.

Шинэлэг тал: Хичээлийн жилийн болон улирлын эхэнд багш нар хамтарч бүлэг сэдвийн төлөвлөгөөг зохиохдоо хичээл хоорондын холбоог хэрэгжүүлэхээр төлөвлөнө. Хичээл хамтран бэлтгэх үедээ сургалтын ямар хэрэглэгдэхүүн ашиглах, сурагчдаар хийлгэх бие даасан туршилт, дадлага ажлууд нь аль аль хичээлийн үндсэн цөм хэсэг болохыг тодорхойлно. Лаборатори хичээлээр хүчил шүлтийн тухай ерөнхий ойлголттой болно.

Түлхүүр үг: Интеграци, лаборатори хичээл, химийн бодис, хүчил шүлт

Товч агуулга

Сургуульд суурилсан интеграциар 2 болон түүнээс дээш хичээлүүдийн ижил төстэй агуулгуудыг хооронд нь уялдаа холбоотой, олон талаас судлах боломжтой болж байна. Энэ хичээл дээр физик, механик, технологийн шинж чанаруудыг шатаах, ажиглах аргуудаар таньж тодорхойлдог.

Далайгаар аялцгаа

Д.Оюунмаа, М.Хараа, Г.Оюунтуяа, Ч.Цагаанхүүхэн

Дорнод аймаг 12 дугаар сургуулийн багш

Судалгааны ажлын зорилго: Сурагчдыг сэдэвт зураг зурахаас гадна үйл явдлыг харуулсан сэдэвт баримал барьж болохыг өөрсдийн төсөөллөөр хийлгэж, сурагчдын урлан бүтээх чадварыг хөгжүүлэх судалгаат хичээл зохион байгуулах

Судалгааны аргазүй, хандлага: Дүрслэх урлагийн хичээлээр сурагчдын мэдэрч хүлээж авах, бүтээх, гүйцэтгэх, бүтээлч эрэл хайгуул хийх чадварыг хөгжүүлэхэд сэдэлжүүлэлт нь сурагчдын сонирхлыг татахуйц байхаар сонгон, өөрсдөөр нь гүйцэтгүүлэх, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргах орчинг гарын доорх материалаар хийж хүүхэд өөрсдөө нэмж орчноо баяжуулах, хүүхэд бүр өөрийн чадварт тулгуурлан дуртай амьтнаа урлан бүтээх түвшингийн даалгаврыг өгч, хийсэн бүтээлээр нь өөрсдийн сэтгэгдлийг яриулах зэрэг аргазүйг боловсруулж хичээлийг багаар зохион байгуулсан.

Судалгааны үр дүн: Судлагдахууны багаар хичээлийн бэлтгэл судалгааг чанартай хийснээр сайн хичээл нь багшийн удирдлага дор биш хүүхэд өөрөө оролцож, бүтээж, сонирхон судалж хийх, сурах арга барил эзэмшиж байна.

Сурагчдын хувьд 70%-иас дээш хувь нь гарын доорх материалыг ашиглан бүтээл урлах аргыг хэрэглээ болгон, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд ахиц гарч, бие даан хамтран ажиллах чадвар сайжран эрэл хайгуул хийх, аливаа зүйлд дүгнэлт хийх чадвартай болж байна.

Эцэг эхийн хувьд судалгаат хичээлд хүүхэд бүр оролцож ахиц үр дүнг тооцож буй үйл ажиллагаатай танилцаж багш сурагчдын хамтран зохион байгуулж буй туршилт, бүтээлийн талаар мэдлэгтэй байж, хүүхэд бүрийн хэрэглэгдэхүүн бэлтгэхэд оролцож, хүүхдэдээ гарч буй ахиц өөрчлөлтийг багшид мэдээлдэг болсон.

Практик ач холбогдол: Хүүхэд бүр дүрслэх урлаг, технологийн хичээлийн бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцсан, хийж

бүтээсэн зүйлээ дүгнэх, тооцоолох, хамтран зохион байгуулах, өөрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөр бусад хээрийн амьтад, таван хошуу малыг урлан бүтээж орчныг яаж бүрдүүлж болохыг мэдэх арга барилд суралцаж хамтран ажиллах чадварт ахиц гарлаа.

Шинэлэг тал санаа: Хичээлийн алхмуудыг оновчтой төлөвлөснөөр сурагчид харах, сонсох, хүртэх мэдрэхүйгээр хүлээн авах, гүйцэтгэх ур чадвар, бүтээлч эрэл хайгуул хийх, урлан бүтээх үйлээр төрсөн сэтгэгдлээ илэрхийлэх чадвар нэгэн зэрэг хөгжиж байгаа нь туршилт хичээлээс ажиглагдсан.

Хичээлийг засан сайжруулахдаа хэрэглэгдэхүүний судалгааг олон хувилбараар засан сайжруулж байсан нь хүүхэд бүр хөгжиж, сайн хичээл болох боломжийг бүрдүүлсэн.

Түлхүүр үг: хичээлийн бэлтгэл судалгаа, хамтын хичээл, хүүхдийн хөгжил, баримал,

Товч агуулга

Шинэчилсэн хөтөлбөрийн хүрээнд сайн хичээл үйл ажиллагааг бүтээлчээр хөтлөн явуулахад багш, сургалтын менежер, захирал, мэргэжилтэн хамтран ажиллаж, харилцан суралцаж, хэлэлцүүлэг судалгаа хийн, дидактик шийдэл гаргах зэргээр чанарын шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа билээ.

Иймд хүүхэд нэг бүрийн хөгжлийг хангахын тулд багш бид шинэчлэлийг өөрсдөөсөө эхлүүлж, багш ажлын байран дээрээ хамтын ажиллагаагаар тасралтгүй хөгжихөд хичээлийн судалгааг чанартай хийвэл багш сурагч хөгжих боломжтой.

“Дүрслэх урлаг” судлагдахууны баг 2015-2016 хичээлийн жилд 4-р ангийн “Баримлын шавраар далайн амьтдыг урлан бүтээх” сэдэвт судалгаат хичээлийг зааснаар, яагаад сайн хичээл болсон, бусдад хүргэх туршлага юу байв?, сайн хичээлийг хэрхэн зохион байгуулсан тухай болон түүний үр дүнд багш, сурагчид, эцэг эхэд гарсан өөрчлөлтийг судлан илрүүлсэн болно. Ингээд тухайн хичээлийг хэрхэн зааж туршсан туршлагаа хуваалцъя.

Суралцагчдын суурь чадварыг түүх, нийгмийн ухааны хичээлээр оношлон, хөгжүүлж буй ажлын үр дүн

Б.Өлзийжаргал

Орхон аймаг, БСУГ ын ахлах мэргэжилтэн

Зорилго: Суралцагч бүрээ судлан оношлох аргачлалд багшийг суралцуулах нь хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих дэмжлэг болдогийг үйл ажиллагааны үр дүнгээр тодорхойлох

Судалгааны загвар (аргазүй) хандлага: Хичээлийн судалгааны үндсэн үе шатыг баримталж ажиллалаа.

Судалгааны үр дүн: 6-7-р ангийн сурагчдын суурь чадварыг оношлон аймгийн дундаж тогтоосноор сургууль, багш бүр суралцагчаа, ялангуяа хоцрогдолтой суралцагчдыг дэмжин хөгжүүлэх давуу талыг олгосон. Ахицаар нь үнэлэх үзүүлэлтийн өсөлт 3,49-9,25%, бууралтаар тооцогдох үзүүлэлтийн ахиц 6,86-12,2%-иар нэмэгдсэн байгаа нь багш бүрийн хүүхэд нэг бүрт хүрч ажилласан ажлын үр дүн байлаа.

Практик ач холбогдол: Түүх, нийгмийн ухааны хичээлээр суралцагчдын суурь чадварыг оношилсон нь тухайн ангийн сурагч бүрийн гарааны үнэлгээ тогтоох, суралцагч бүрийг хөгжүүлэх арга зүйн дэмжлэг болно. Мөн боловсруулсан аргачлалыг аль ч мэргэжлийн багш өөрийн хичээлийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх боломжтой.

Шинэлэг тал: Суралцагчдын суурь чадварыг тогтоох нь судлагдахуун, хичээл бүрээр хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, тэднийг үнэлэх зорилтот хэсэг болно.

Түлхүүр үг: Суралцагч, хичээлийн судалгаа, аргачлал, зөвлөмж, арга зүй, оношилгоо, ахиц, үнэлгээ

Товч агуулга:

Сурагчдаа судлан оношлох замаар хичээл, үйл ажиллагаагаа зохион байгуулах нь хүүхдийн хөгжлийг дэмжих хичээлийн судалгааны чухал алхам юм. Суралцагчаа судлан оношлох арга аргачлал дутмаг, багшаас нэлээд цаг хугацаа шаарддаг шалтгаан нь сэдвийг сонгох үндэслэл болсон. Багш бүр суралцагчаа судлан оношилж, гарааны үнэлгээ тогтоон, хүүхэд бүрээ хөгжүүлэхэд нь дэмжлэг болно гэж үзээд 6-7-р ангийн сурагчдын суурь чадварыг тогтоох аргачлал боловсруулж, зөвлөмж хүргүүлснээр сургууль бүр тухайн хичээлээр судалгаа авч гарааны нөхцлөө тодорхойлж, мэргэжлийн багш нарын

баг хичээлийн явцад суурь чадварыг хөгжүүлэх бодлогоо төлөвлөн ажилласан. Тухайлбал, "3 минутын индэр", "Найзаа урих", "Шилдэг илтгэгч", "5 минутын бичгийн ажил"-ын арга, асуулт зохиолгон хариулт авах, ярилцлага хэлэлцүүлэг өрнүүлэх, улирлын шалгалтыг аман хэлбэрээр зохион байгуулах, эх сурвалж, баримт уншаад төрсөн сэтгэгдлийг яриулах, бичүүлэх, гэх мэт олон үйлдэл, арга аргачлалыг ашиглан хичээлийн жилийн эцэст үнэлгээ хийж, суралцагч бүрийн ахиц, бууралтыг тооцсон.

Ажлын хуудсаар сурагчдын мэдлэг чадварыг үнэлэх нь

Ж.Дэлгэрмаа

Төв аймаг, Цээл сумын ахлах сургуулийн түүх-нийгмийн багш

Зорилго: Ажлын хуудсаар сурагчдын чадварыг үнэлэх, ахицыг тооцох, бүтээлч чадварт дэмжлэг үзүүлж байгаа үйл явцыг судлах.

Практик ач холбогдол:

- Ажлын хуудсаар сурагчдын хичээлийн явц буюу хүүхэд нэг бүрийн хичээлийн идэвх оролцоо, эзэмшиж байгаа мэдлэг чадварыг үнэлэх боломжтой.
- Явцын үнэлгээний хамгийн чухал хэрэглэгдэхүүн нь ажлын хуудас болдог.

Шинэлэг тал: Ажлын хуудсаар дамжуулан хүүхдийг үнэлэх, тэдний ахицыг тооцох боломж илүү байна гэж бид үзэн ажлын хуудсыг хэрэглэх явцад гарч буй давуу болон сул тал, цаашид сайжруулах зүйл байгаа эсэх тал дээр судлах нь зүйтэй гэж үзсэн.

Ажлын хуудас яагаад шинэлэг зүйл болж байна вэ?

- Сурагчдын мэдлэг чадварын ахицыг бодитой үнэлдэг
- Ажлын хуудастай хичээл дээр сурагчид бие даан мэдлэг бүтээдэг
- Хүүхэд бүрийн чадварыг харгалзан ялгаатай боловсруулдаг.

Түлхүүр үг: Үнэлгээ, ажлын хуудас

Нийгмийн ухааны хичээлд баримтат кино болон аудио, видео материалыг ашиглах нь

Б.Ариунаа

Баян –Өлгий аймаг, Ногоон нуур сумын Бүрэн дунд сургууль

Зорилго: Сурагчдын идэвхтэй үйл ажиллагааг дэмжих, өөрийн хүсэл сонирхол эрмэлзлээр бие даан хөгжихөд техник технологийн хэрэглэгдэхүүнийг сургалтад ашиглаж мэдлэг чадвар эзэмшүүлэх, сурагч бүрийг хөгжүүлэх боломжийг эрэлхийлж, сургалтад ахиц гаргах аргазүйг боловсруулахад чиглэнэ.

Сэдвийг судлахын ач холбогдол: Хүүхэд нэг бүртэй тулж ажиллах, тэдний сонирхолд нийцүүлсэн хичээл сургалтыг өөрсдийн оролцоотойгоор зохион байгуулж явуулснаар хандлагыг нь өөрчлөх, мэдлэгийг хэрэглээ болгох, сурч хүмүүжиж төлөвшихөд нь сурагчийн өөрийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломж болж байна.

Нийгмийн ухааны хичээлээр баримтат кино болон видео материалыг ашиглан сурагчдын мэдлэг чадвар төдийгүй төлөвшилд нь өөрчлөлт ахиц амжилт гаргах боломжтой гэж үзсэнээрээ шинэлэг ач холбогдолтой юм.

Онолын үндэслэл: Хүн мэдрэхүйн эрхтэнээрээ мэдээллийг сайн хүртдэг төдийгүй, ойлгож тогтоох, сэргээн санах жишээ бол хүн ярьж илэрхийлсэн зүйлийг 2,8 сек; өнгөт фото зураг дээрх зүйлийг 0,9 сек; кинонд болон телевизээр гарч буй зүйлийг 0,7 сек; бодит байдлаар үзүүлсэн зүйлийг 0,4 секундэд тус тус хүлээн авдаг гэсэн судалгаа байдаг. Цахим хэрэглэгдэхүүн нь суралцагчийн танин мэдэх үйл ажиллагааг эрчимжүүлж аливаа асуудалд бүтээлчээр хандан мэдлэг боловсролоо дээшлүүлэн бодит чадвар эзэмшихэд чухал үүрэг гүйцэтгэж байна.¹

Ээлжит хичээлийн засан сайжруулалтын үр дүн

¹Д.Байгалмаа,¹ Г.Бадамханд,¹ Д.Байгалмаа,

¹Г.Бадамханд, ¹Д.Анхбилэг, ¹Д.Бүжин

Дорнод аймаг, Хэрлэн сум, 12дугаар сургуулийн багш нар

Зорилго: Ээлжит хичээлийг төлөвлөх, туршин хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл, бэрхшээл, түүнийг арилгахын тулд хийж буй эрэл хайгуул, арга ажиллагааны үр дүнг тодорхойлоход оршино.

Судалгааны загвар хандлага: Хүүхэд бүрийг шинжлэн судлах арга

барилд суралцахуйц үйлүүдийг тусгаж төлөвлөсөн ажлын хуудастай ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж, заан туршиж, засан сайжруулж ажилласнаар сурагчдын чадвар, хандлага, төлөвшилд тодорхой ахиц, үр дүн гарах төдийгүй өнөөгийн боловсролын чиг хандлага болох “Хүүхэд бүрийг өөртөө итгэлтэй, бүтээлч шийдвэр гаргах чадвартай иргэн болж төлөвшүүлэх” үйл хангагдана гэж үзлээ.

Судалгааны үр дүн: Дорнод аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 7абв, 8аб ангийн 135 сурагчийг судалгааны объектоо болгож 4 ээлжит хичээлийг заах явцад сурагчдын асуудал, таамаглал дэвшүүлэх чадвар өссөн.

Шинэлэг тал: Ээлжит хичээлийн үе шат бүрт шинжлэн судлах арга барилыг алхамчлан төлөвлөж, хийх үйлийн зааварчилгаа, судлах мэдээлэл, хэрэглэгдэхүүн, самбар төлөвлөлт, эх сурвалжийг цогцоор нь тусгасан хөтөлбөрүүд нь багшийг хичээлээ хөтлөн явуулахад шинэ санаа өгч дэмжлэг болно.

Түлхүүр үг: Гарааны үнэлгээ, ажлын хуудас, сурагчдын шинжлэн судлах чадвар, хөгжил, хандлага, төлөвшил

Товч агуулга

Бид 7 дугаар ангийн түүхийн “Өгэдэй хаан Монголын их гүрнийг байгуулсан нь”, “Монголын их Юань улсын төр, засаг захиргаа, хүн ам, нийгэм”, 8 дугаар ангийн “Бурхны шашин Монголд өргөн дэлгэрсэн нь”, “Наполеон Бонапарт ба Францын эзэнт гүрэн” гэсэн ээлжит хичээлээр хичээлийн судалгааг зохион байгуулж, үйлийн явцдаа багшийн олж авсан шинэ санаа, арга хэлбэр, хүүхдийн чадвар, хандлагад гарсан өөрчлөлт, үр дүнгийн талаар танилцуулж байна.

Хүүхдүүдийг хичээлийн явцад шинжлэн судлах арга барилд цогцоор суралцахад нь багшийн талаас дэмжлэг үзүүлэхүйц арга, хэлбэрээр хичээлийг төлөвлөн зааж туршин, тухайн арга барилыг сурагчид хэрхэн эзэмшиж байгааг хичээлийн ажиглалт, ажлын хуудсаар таних, цаашид хэрхэн шийдвэрлэх боломж байгааг олж харан туршлага, зөвлөмжөө хуваалцах зорилгоор өдөр тутмын үйлийн явц, түүний үр дүнд анализ хийлээ.

Сурагчдын мэдлэг чадварт өөрчлөлт гарч байгааг тогтоохын тулд сурагчдын ажлын хуудасны гүйцэтгэлд анализ хийж үзэхэд асуудал, таамаглал дэвшүүлэх чадвар 54 хувь, түүхэн асуулт боловсруулах чадвар 43 хувь, асуултанд хариулах чадвар 61 хувь, газрын зурагтай ажиллах чадвар 36 хувь, мэдээлэл боловсруулах чадвар 61 хувь, үр дүнг хэлэлцэх чадвар 46 хувьд хүрсэн тоон үзүүлэлттэй байна.

Түүхийн хичээлээр мэдлэг бүтээлгэх арга зүйг боловсруулсан нь

Д.Оюунчимэг

Увс аймаг, Цагаан хайрхан сумын сургууль, түүхийн багш

Зорилго: Хүүхдийн хөгжлийг дэмжсэн судалгаат хичээл явуулахад түүний хөтөч болох хэрэглэгдэхүүний хүүхдийн сурах үйл явцад хэрхэн дэмжлэг үзүүлж чадаж буйг судлах

Судалгааны загвар \арга зүй\ хандлага: Орон нутагт суурилсан биет үзмэрүүдтэй танилцан гарын доорх материал ашиглаж хэрэглэгдэхүүнийг загварчлан хийх аргын хүрээнд 8-р ангид “Эртний Монгол орон соёлын голомт нутаг болох нь” 6-р ангид “Монгол нутаг дах эртний нүүдэлчдийн дурсгал” чадамжид суурилсан судалгаат хоёр хичээлийн агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хэрэгжүүлэв.

Судалгааны үр дүн: Тус хичээлийн судалгаагаар танхимын болон танхимын бус сургалтын явцад эзэмшсэн мэдлэг мэдээллээ шинэ орчин нөхцөлд шилжүүлэн хэрэглэх, өөрт байгаа гарын доорх ямар ч материалыг ашиглан бодитоор харснаа загварчлан бүтээж, туршин хэрэгжүүлэх чадвартай болсон. Ялангуяа хийсэн бүтээлээрээ дамжуулан өөрийн бодол санаагаа бусадтай хуваалцах, бахархах сэтгэл зүйн таатай уур амьсгал бий болгох боломжтой болж бодож сэтгэх, өөрсдийн хүчинд итгэх, илэрхийлэх чадвар нэмэгдсэнээр сурагчдын мэдлэг чадварт өөрчлөлт гарч байгааг тогтоосон.

Практик ач холбогдол: Орон суурилсан биет үзмэрүүдтэй танилцаж бодит нөхцөлд үндэслэн гарын доорх материал ашиглан хэрэглэгдэхүүнийг загварчлан хийснээр багш болон суралцагчийн хамтын ажиллагааны хандлага, арга зүйн өөрчлөлтийг хослуулан харуулах боломжтой.

Шинэлэг тал \санаа\: Тухайн нийгмийн ахуй, соёлын амьдралын төлөөлөл бүхий дурсгалт зүйлсийг гарын доорх материалаар бэлтгэн агиглах нь ямар үр дүн, давуу тал байгааг, хэрхэн сайжруулах боломж арга зам буйг бодит нөхцөлд туршин дахин сайжруулснаа мэргэжил нэгт багш нартаа санаа болгон өгөхөд оршино.

Түлхүүр үг: Судалгаат хичээл, хичээлийн хэрэглэгдэхүүн, бэлтгэл судалгаа, гарын доорх материал

Товч агуулга

Хичээлийн судалгааг 2015 оны 05 сар, 2016 оны 01 сар, 2016 оны 09 сард тус тус туршин сайжруулж заахдаа 8-р ангид “ Монгол

орон эртний соёлын голомт нутаг болох нь” 6-р ангид “Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн дурсгал” сэдвийн хүрээнд хичээлийн хэрэглэгдэхүүнийг хэрхэн бүрдүүлж ашиглах, бүтээх үйл явцыг гол болгосон талаар өөрийн судалгаат хичээлийн үр дүнг танилцуулж байна.

2012 оноос эхлэн 6-12-р ангийн хүрээнд судалгаат хичээлийг аймаг, бүс, сумын багш нартайгаа хамтран зааж, суралцаж, хуримтлуулсан мэдлэг чадварынхаа түвшинд хүүхэд нэг бүрд хүрч ажиллах зорилгоо тодорхой болгож, туршилтаа явуулж үр дүнг тооцон анализ хийлээ. Ингэхдээ туршилтад ашиглах гарын доорх материал нь хүүхдийн сурах үйл явцыг дэмжсэн гол хэрэглэгдэхүүн байж чадах эсэхийг судлах шаардлага зүй ёсоор тулгарсан. Энэ үйл явцын эцэст сурагчид “Мини археологич, түүх судлаач”-ийн байр сууринаас хандаж хэрэглэгдэхүүнээр дамжуулан өөрийн бодол санааг илэрхийлэх, хийсэн бүтээлээ хараад бахархах, өөрсдийн хүчинд итгэх, сэтгэл зүйн таатай уур амьсгал бий болгох суралцахуйн үйлийг хэрэгжүүлснээр сурагчдын мэдлэг чадвар, хандлагад өөрчлөлт гарч байгааг тогтоолоо.

Түүхийг шинжлэн судлах нь асуулт тавих, боловсруулахад чиглэх нь сурагч бүрийн эзэмшсэн байх чухал чадвар юм. Хэзээ?, хаана?, юу?, хэн?, яагаад?, гэсэн асуултуудыг гаргаж түүндээ хариулж чаддаг байх нь чухал. Энэ зорилтын хүрээнд ажлын хуудсаараа дамжуулан түүхийн асуултуудаа Блум таксономийн аргын хүрээнд боловсруулж суралцахуйн үйлийг хэрэгжүүлсэн.

Судалгаанд 8-р ангийн 45, 6-р ангийн 36 сурагчид оролцож, Түүхийн асуулт - 5W, Блум таксономоор үнэлэх нэгж хичээлийн үнэлгээний даалгавар гүйцэтгэлийн хувьд 19% ахисан үзүүлэлт гаргасан. Эндээс дүгнэхдээ хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн явц, ажиглалт, хэлэлцүүлгийн дүнд хэд хэдэн сайжруулах алхмыг хийв. Юуны өмнө орчны нөхцөлийг судалсны дүнд орон нутгийхаа дурсгалт газруудаар тойрон аялал хийж, биет үзмэрүүдтэй танилцуулах, нүдээр үзсэнээ бодит байдлаар загварчлан хийх, багшийн асуултууд ба ажлын хуудас нь суралцагчийн суралцах үйл явцад дэмжлэг үзүүлж буй эсэх, сурагч нэг бүрийн оролцоо, хандлагыг илтгэх хуудсаар бичүүлэх зэргээр алхамчлан тооцож ажиллалаа.

Иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээ

‘Н.Нарантуяа, ‘Н.Олонбаяр

‘Говь-Алтай аймаг, 1 дүгээр сургуулийн Түүх нийгмийн ухааны багш нар

Зорилго: Суралцагч бодит үйл ажиллагаанд оролцох явцдаа эрэл хайгуул хийх, асуудал олж харах, эргэцүүлэн бодох, дүгнэх, асуудлыг шийдвэрлэх арга барил, чадварт суралцан бүтээлчээр хамтран ажиллах замаар зөв амьдрах арга ухаанд суралцах чадвар, хандлага төлөвшүүлэх юм.

Судалгааны загвар хандлага: Хичээлийн бэлтгэл судалгааны хүрээнд 10-р ангийн “Төрийн алба” нэгж хичээлийн “ Иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээ “ээлжит хичээлээр сурагчид өөрийн орон нутгийн төрийн үйлчилгээний 5 байгууллагууд дээр очиж тухайн байгууллагынхаа талаар мэдээлэл цуглуулан боловсруулж, үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч өөрсдийн байр суурийг илэрхийлж мэдлэг бүтээлээ.

Судалгааны үр дүн: Дээрх үйл ажиллагаа нь суралцагчийн хувьд их сонирхолтой, хөгжилтэй төдийгүй тодорхой дүрэм журамд баригдалгүй явагддаг учраас санаачлагатай оролцох боломжийг тэдэнд олгодгоороо давуу байлаа. Энд суудал шийдвэрлэх, эргэцүүлэн тунгаан бодож шийдвэр гаргах, бие даан суралцах хамтран ажиллах, харилцаа холбоо тогтоох гэх мэт суралцагчийн амьдрах чадварууд хөгжиж байна.

Судалгааны шинэлэгтэл: Судлагдхуунаар олж авсан мэдлэг чадвар, хандлагаа ашиглан өөрийн орон нутгийн төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний төрөл,чанар, хүртээмжид өөрийн үнэлэлт өгөх явдал юм.

Түлхүүр үг: Амьдрах чадвар, багшийн мэдрэмж хандлага, итгэл, хүсэл тэмүүлэл

“Металл, металл бишийн нягт” ээлжит хичээлийн арга зүйн туршлага

*А.Дэмбэрэлнямбуу, Ц.Чимэдрэгзэн, Г.Дэмбэрэлмаа, Я.Нарангэрэл,
Б.Нямдаваа*

Завхан аймаг, Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн сургалтын менежер, химийн багш нар, БСГ-ын мэргэжилтэн, математикийн багш

Зорилго: Энэхүү судалгаат хичээлээр металл, металл бишийн нягтын ялгааг тооцоолох, мэдээллийг загварчлан боловсруулах аргаар илрүүлэн, хүүхэд нэг бүрийн харьцуулан судалж, дүгнэлт гаргах чадварын хөгжлийг дэмжсэн үр дүнг танилцуулж байна.

Судалгааны загвар/арга зүй/ хандлага: Суурь боловсролын 7-р ангийн “Материалын шинж чанар” бүлгийн, “Металл, металл биш” нэгж хичээлийн, “Металл, металл бишийн нягт” ээлжит хичээлийн бэлтгэл судалгааны хүрээнд нягтын ялгааг тооцоолох болон загварчлах аргаар харуулах хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Металл, металл бишийн нягтын ялгааг тэдгээрийг бүрдүүлэгч жижиг хэсгийн хоорондын зай, жижиг хэсгийн хэмжээнээс хамаардаг болохыг үл харагддаг жижиг хэсгийг загварчлах аргаар төлөөлөн мэдэрч, тооцооллын үр дүн, эрдэмтдийн судалгааны үр дүнтэй харьцуулан судалсан. Энэ нь суралцагчдын сонирхон судлах эрэлтийг нэмэгдүүлэн, суралцахуйн бүтээлч үйлийг хэрэгжүүлсэн нь суралцах, харьцуулан дүгнэлт гаргах чадварын хөгжилд дэмжлэг үзүүлсэн эерэг үр дүнг тодорхой хэмжээгээр авчирдаг.

Практик ач холбогдол: Дээрх арга зүйн санааг ерөнхий боловсролын сургуулийн химийн болон байгалийн ухааны багш нар хичээлдээ туршин хэрэгжүүлэх боломжтой. Хичээлийн судалгаагаар дамжуулан хичээлийг тооцоолох болон загварчлах аргаар төлөвлөн хэрэгжүүлснээр суралцагчдын хөгжлийг дэмжсэн хичээлийн арга зүйг бүтээх боломжтойг харуулсан.

Шинэлэг тал/ашиг тус: Химийн гол концепцийг ойлгуулахад математик тооцооллын болон мэдээллийг загварчлах аргаар бодитоор мэдрүүлж, харьцуулах, сонирхон судлах хэрэгцээ, оролцоон дээр суурилан хүүхэд нэг бүрийн хөгжилд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Түлхүүр үг: Металл, металл бишийн нягт, жижиг хэсэг, жижиг хэсгийн хэмжээ, хоорондын зай, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, судалгаат хичээл, загварчлах арга, харьцуулан судлах, дүгнэлт гаргах чадвар

Товч утга

Суурь боловсролын химийн хичээлээр суралцагчид өөрсдийн бүтээлч үйлээр дамжуулан ахуйн мэдлэгийг ШУ-ы сорил туршилтын, мэдээлэл боловсруулах, тооцоолох, загварчлах аргаар танин мэдэж, материалын шинж чанарын талаар мэдээлэлтэй болдог. Иймээс хичээлийн үе шат бүрд, суралцагчийн оролцоог дэмжсэн тооцоолох болон загварчлах аргаар металл, металл бишийн нягтын ялгааг ойлгуулахаар төлөвлөн хэрэгжүүлэхээр хэрэглэгдэхүүн, агуулга, арга зүйн бэлтгэл судалгааг хийсэн. Шоо хэлбэртэй, металл, металл бишээс тогтсон бодит биетийг сонгон авч ижил, ялгаатай шинжүүдийг хэлэлцүүлж, эзэлхүүнийг нь математик аргаар тооцоолон ижил болохыг батлан, массаараа ялгаатай байгааг техник жингээр жинлэн тодорхойлсон. Массын ялгаатай байгааг бодисын нягтын ялгаа гэж үзэн, нягтаараа ялгаатай байгаа нь бодисыг бүрдүүлэгч жижиг хэсгийн хэмжээ, хоорондын зайнаас хамаардаг болохыг тодорхойлуулсан. Бодисыг бүрдүүлэгч жижиг хэсэг нь том байх тусам, хоорондын зай ихэсч, нягт багатай байна гэсэн дүгнэлтийг гаргасан. Химийн боловсролын аливаа хөтөлбөрийг суралцагчдын оролцоо, идэвх сонирхлыг дэмжсэн суралцахуйн бүтээлч үйлийг дэмжсэн ШУ-ы тооцоолох болон загварчлах аргаар зохион байгуулж, багшлахуйн нээлттэй асуултаар хүүхдээ сонсож суралцагчийн харьцуулан дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх алхмыг нарийн төлөвлөснөөр хүүхэд бүрийн хөгжлийг дэмжиж чадна гэсэн эерэг үр дүнг ямар нэг хэмжээгээр авчирдаг юм байна гэдгийг дүгнэсэн. Бодисыг бүрдүүлэгч жижиг хэсгүүдийг бодитоор харж, шинжийг нь тодорхойлох боломжгүй байдаг. Иймээс материал, бодисыг бүрдүүлэгч жижиг хэсгийг загвараар дүрслэн мэдэрч, шинж чанарын ялгааг тодорхойлох нь илүү үнэнд нийцэж байгааг тооцооллын үр дүнтэй харьцуулан гаргасан.

Фарадейн хуулийг батлах туршилтын багажийг сургалтын хэрэглэгдэхүүн болгон туршсан нь

¹Н.Баярсайхан, ²Р.Отгонхүү

¹33-р сургуулийн багш, ²58-р сургуулийн багш

Ахлах сургуулийн хөтөлбөрийн шинэчлэл 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн туршиж эхэлсэн бөгөөд ахлах боловсролын хөтөлбөрийн зорилго нь сурагчдад шинжлэх ухааны мэдлэг, арга арил эзэмшүүлэхэд чиглэж байгаа билээ. Мөн БДБ-ын ахлах сургуулийн

цөм хөтөлбөрийн агуулгад “Цахилгаан хими” бүлэг сэдвийн хүрээнд Фарадейн I, II хуулийг ашиглан тооцоо хийхтэй холбоотой суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэхийг сургууль, багш нарт зөвлөсөн байна. Иймд бид энэхүү илтгэлээр цайр-агаар батарей ашиглан Фарадейн хуулийг батлах туршилтын багажийг угсарч, ЕБС-ийн сургалтын хэрэглэгдэхүүн болгон боловсруулах зорилго дэвшүүлэн ажилласан судалгааны эхний үр дүнгээс танилцуулахаар бэлтгэлээ.

Судалгаанд Фарадейн хуулийг батлах туршилтын багажийг угсарч туршихдаа Япон улсын Гакугей их сургуулийн профессор Масахиро Камата (Masahiro Kamata), Мией Паку (Miei Paku) нар гарын доорх материал ашиглан хялбар багаж бүтээж, хэрэглэх зорилгоор цайр-агаар батарейг ашиглан Фарадейн хуулийг батлах “Цахилгаан гүйдэл тогтворжуулагч диод ба цайр-агаар батарейг ашиглан Фарадейн хуулийг тайлбарлах” сэдэвт судалгааны өгүүлэлийг судлах материал болгон ашигласан ба ЕБС-ийн ахлах ангид 2 давталттайгаар нийт 8 цагийн хичээлд зааж туршсан.

Судалгааны үр дүнгээс өөрийн оронд олдоцтой гарын доорх материал ашиглан Фарадейн хуулийг батлах туршилтын багажийг угсрах боломжтой болохыг тогтоосон. Мөн ЕБС-ийн сургалтад туршиж, сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах боломжтой байхаар боловсронгуй болгон угсарсан болно.

Түлхүүр үг: Хэрэглэгдэхүүний судалгаа, судалгаат хичээл, сургалтын хэрэглэгдэхүүн, Фарадейн хууль, туршилтын багаж, цайр-агаар батарей

Судалгааны ажлын үндэслэл өнөөгийн шаардлага: ЕБС-ийн химийн сургалтын суурь боловсролын хөтөлбөрийн шинэчлэл 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн орон даяар хэрэгжиж байна. Харин ахлах сургуулийн хөтөлбөрийн шинэчлэл 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн туршигдаж эхэлсэн бөгөөд ахлах боловсролын хөтөлбөрийн зорилго нь сурагчдад шинжлэх ухааны мэдлэг, арга барил эзэмшүүлэхэд чиглэж байгаа билээ. Мөн БДБ-ын ахлах сургуулийн цөм хөтөлбөрийн агуулгад “Цахилгаан хими” бүлэг сэдвийн хүрээнд Фарадейн I, II хуулийг ашиглан тооцоо хийхтэй холбоотой суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэхийг сургууль, багш нарт зөвлөсөн байна. Иймээс бид “Цайр-агаар батарей ашиглан Фарадейн хуулийг батлах туршилтын багаж”-ийг угсарч, ахлах ангийн сургалтад хэрэглэх боломжтой эсэхийг туршсан.

Цахим ажлын хуудсаар хүүхдийн хөгжлийг дэмжих нь

Ч.Оюун-Эрдэнэ, Ц.Энхжин, Ц.Батхуяг

Дархан-Уул аймаг, Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн багш нар

Зорилго: Мультмедиа программ хангамжийг сургалтад ашигласнаар суралцагчдын сурах идэвх оролцоог нэмэгдүүлэх улмаар тэдний хөгжилд үзүүлж буй нөлөөг судлан дүн шинжилгээ хийхэд оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Судалгаат хичээлийн хүрээнд энгийн мультмедиа программ хангамжийг сургалтад ашиглаж багш сурагчийн цахим хуудас бэлтгэсэн бөгөөд ЕБС-ийн 6-р ангид бодит амьдрал дээрх энергийн хувирлыг судалж “Энергийн хувирал” сэдэвт судалгаат хичээлийн агуулга, арга зүйг сайжруулсан хичээлийн судалгааг танилцуулж байна.

Судалгааны үр дүн: Энэхүү судалгаат хичээлээр сурагчдын хосоор болон багаар хамтран ажиллах, энергийн хувирлыг загварчлан таних, цахим ажлын хуудсаар мэдлэг бататгах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, суралцахуйн үйлийг хэрэгжүүлсэнээр сурагчид онолын мэдлэг, мэдээллээ амьдрал, практикт туршин хэрэгжүүлж, шинийг санаачлан физикийн хичээлийг сонирхох сурагчдын тоо өсч, тэдний идэвх оролцоо сайжрав.

Практик ач холбогдол: Суралцагсад танхимаас гадуур онлайнаар бие даан цахим ажлын хуудсыг олон дахин давтан хэрэглэж мэдлэгээ бататгах боломжтой. Багш хичээлийн төлөвлөлтөө чанартаа бүтээлчээр хийснээр сурагчдын сурах идэвх оролцоог нэмэгдүүлэн тэдний хөгжилд тодорхой хувь нэмэр үзүүлнэ.

Шинэлэг тал/ашиг тус: Сурагчдын сэтгэхүйн болон мэдээлэл хүлээн авч боловсруулах, танин мэдэхүйн үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзэж, тэдний өөрөө өөртөө мэдлэг бүтээх, мэдлэгт суурилсан чадвар, улмаар бодит чадвар төлөвшүүлэх үйл явцад аудио, видео бичлэг, анимейшин, апплет, вебсайт, компьютер болон гар утсанд суурилсан програмууд гэх мэт мэдээллийн технологид суурилсан сургалтын хэлбэрүүдийг сургалтад оновчтой ашиглах, үр дүнтэй арга зүйг боловсруулсан нь багш нарт шинэ санаа өгөх боломжтой.

Сайн загварчлагдсан мультимедиа хичээл нь суралцагчид үйлдлийн хувьд идэвхгүй байгаа юм шиг санагдсан үед ч идэвхтэй танин мэдэх боловсруулалтыг дэмжиж чаддаг. [1]

Түлхүүр үг: Мультмедиа программ хангамж, бүтээлч сэтгэлгээ, хүүхдийн хөгжил, цахим ажлын хуудас

Товч утга

Сургалтад мультмедиа программ хангамжийг хэрэглэснээр сурагчдын сурах идэвх оролцоог нэмэгдүүлэх, тэдний сурлагын чанарт ахиц дэвшил гарч улмаар хичээлийн чанар үр өгөөжийг дээшлүүлэх боломжтой. Багш нар хичээлээ төлөвлөхдөө тухайн хичээлийн туршид сурах үйл ажиллагааг хэрхэн чиглүүлэх, хичээлийн үеэр хамгийн тохиромжтой байдлаар ажлын хуудсыг хэрхэн ашиглахаа төлөвлөх хэрэгтэй болдог. Нөгөө талаас багшийн ажлын ачаалалыг багасгаж, цаг цаас хэмнэх боломжтой цахим ажлын хуудсыг бий болгож сургалтанд ашиглах боломжийг судлан энэхүү судалгаат хичээлээрээ харуулахыг хичээсэн болно. Багш, сурагчийн ажлын цахим хуудсыг оновчтой хийж төлөвлөснөөр сурагчдын идэвх оролцоо сайжирч, сурагч тэрхүү ажлын хуудсыг олон дахин ашиглан мэдлэгээ бататгаж болно. Мөн онлайнаар цахим ажлын хуудсан дээрээ багш сурагчид өөр хоорондоо санал бодлоо чөлөөтэй солилцох болсон зэрэг давуу талтай гэж үзлээ. Түүнчлэн физик мэдээлэл зүйн хичээл хоорондын залгамж холбоогоор сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх боломжтой юм. Энэхүү цахим ажлын хуудсыг сургалтандаа ашигласнаар физикийн хичээл хэцүү хүнд гэсэн сурагчдын айдас үгүй болж, тэдэнд сурах хүсэл эрмэлзлэлийг бий болгон дараа дараагийн хичээлээ хүсэн хүлээдэг хүлээлтийг бий болгож чадсан юм.

Анх 2015 оны 12 сард 7-р ангид “Цахилгаан” нэгж хичээлд ашиглан туршиж үзсэн. Улмаар цахим хуудсыг аль ангид хэрэглэвэл илүү тохиромжтойг судалж судалгаа хийсний үр дүнд 6-р ангийн “Энерги” нэгж хичээлд ашиглан үр дүнд хүрсэн. Шилжилтийн насны хүүхдүүдийг цахим ертөнцийн зөв хэрэглээнд сургах зорилгоор 6-9-р ангийн сургалтанд илүү түлхүү ашигласан болно.

Хүүхдийг өөрийн удирдлагатайгаар сургах арга зүй

¹А.Батцэцэг, ²Б.Сундуй

¹Өвөрхангай аймаг, 11-р сургуулийн багш, ²“Мэргэд” сургуулийн багш

Зорилго: Ээлжит хичээл дээр явцын үнэлгээний рубрикийн аргыг ашиглах нь хүүхдийн шинжлэх ухаанч арга барилыг хөгжүүлэх, физикийн бодлого бодох чадварыг дээшлүүлэх, өөрийн удирдлагатай суралцахад хэрхэн нөлөө үзүүлэхийг судлах, үр дүнг тооцоход оршино.

Судалгааны загвар/арга зүй/хандлага: Хүүхдийн чадварыг ээлжит хичээл бүр дээр үнэлж, ажигласан ажиглалт, бодит үр дүн дээр тулгуурлан хичээлээ сайжруулан зааж, хүүхдийн чадварын хөгжлийг судалсан болно.

Судалгааны үр дүн: Ээлжит хичээл дээр сурагчдын шинжлэх ухаанч арга барил, чадварыг 2015 оноос 8-р ангид, физикийн бодлого (асуудал шийдвэрлэх бодлого, тооцоолох бодлого) бодох чадварыг 2016 оноос хойш 9-р ангид рубрикийн аргаар үнэлэх энэхүү аргыг туршин хүүхдийг ажигласнаар сурагчдын таамаглал дэвшүүлэх, туршилт төлөвлөх, туршилт гүйцэтгэх чадваруудад ихээхэн ахиц гарсан, туршилтаас гарах үр дүнг таамаглалтай харьцуулан дүгнэлт хийх чадварт аажмаар ахиц гарч байгааг илрүүлсэн.

Практик ач холбогдол: Явцын үнэлгээний рубрикийн аргыг ээлжит хичээл дээр тогтмол ашиглаж, хүүхдийг ажигласнаар тэдэнд өөрийгөө ямар түвшинд сурч байгааг мэдэх, цаашид ямар түвшинд хүрч болохыг өөрөө хянах боломж олгодог энэхүү арга зүйг байгалийн ухааны багш нарт түгээн дэлгэрүүлэх, багшийн арга зүйд нэвтрүүлэх боломжтой.

Шинэлэг тал/ашиг тус: Рубрикийн аргаар хүүхдийг үнэлэх, ажиглах энэхүү аргыг физикийн хичээлд хэрэглэхэд физикийн багш нарт шинэ санаа өгөх болно.

Дэвшүүлж буй асуудал:

1. Багш бид сурагчдаа ямар чадвартай, ямар төвшинтэй болохыг өөрөөр нь үнэлүүлж, ямар хэмжээнд ахиж болохыг мэддэг, өөрийн удирдлагатай суралцах боломж олгох шаардлагатай.
2. Багш бид хүүхдээ хичээлийн явцад нь үнэлэх, ажиглах тодорхой шалгуур бүхий арга зүйтэй болох хэрэгцээ байна.

Түлхүүр үг: Явцын үнэлгээ, рубрикийн арга, шинжлэх ухаанч арга барилын хөгжил, физикийн асуудал шийдвэрлэх бодлого, өөрийн удирдагатай суралцах боломж, хичээлийн бэлтгэл.

Товч утга

“Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд зайлшгүй хүүхдийн чадварыг ажиглах шинэлэг арга зүй зайлшгүй хэрэгтэй болсон. Тиймээс 2015 оны 9-р сараас эхлэн хүүхдийн чадварыг ажиглах рубрикийн аргыг ашиглаж, хүүхдээ ажиглан тэрхүү ажиглалтан дээрээ тулгуурлан хичээлээ тогтмол сайжруулан зааснаар сурагчдын чадварт эерэг өөрчлөлт, ахиц гарсан. Харин 2016 оны 9-р сараас эхлэн сурагчдын тооцоолох, асуудал шийдвэрлэх бодлогыг төвшинөөр ангилж (Физикийн бодлогын хураамж 7-9 анги, Баасанжав, Физик-III, IV, V сурагчийн дэвтэр, Р.Энхбат, Н.Оюунчимэг) сурагчдад өөрийн сонголтоор бодох нөхцөлийг бүрдүүлэн, рубрикийн аргаар ажигласнаар сурагчдын бодлого бодох сонирхол маш их нэмэгдэж, ямар төвшинд байгаагаа мэдэхийн хирээр ямар төвшинд хүрэхээ тодорхойлж өөртөө хяналт тавих, өөрийн удирдлагатай суралцах, боломж байгааг тогтоосон.

Математикийн хичээлийг хэрэглээтэй холбож сурагчдыг жигд хөгжүүлэх арга зүй

Н.Доржмаа, Ш.Шинэхүү, Д.Энхжаргал

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, 1-р сургуулийн багш нар

Зорилго: Математикийн хийсвэр онолыг заахаас татгалзах хүүхэд бүрийг өөрийн чадварт суурилан хэрэглээтэй холбож хүүхэд нэг бүрийг жигд нийтээр нь хөгжүүлэх боломжтой эсэхийг судлахыг зорилоо.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Математикийн хичээлийг амьдрал ахуй болон бусад хичээлтэй холбон зааж сурагчдаар өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх нь сурагчдад гүн бат мэдлэг эзэмшүүлж байгаа эсэхийг судаллаа.

Судалгааны үр дүн: Сурагчдаар мэдлэг бүтээлгэн амьдрал ахуйтай болон бусад хичээлтэй холбон зааж сургах арга зүй нь сурагчдыг жигд хөгжүүлэх боломжтой байгааг харуулж байна

Практик ач холбогдол: Дээрх арга зүйг ерөнхий боловсролын сургуулийн математикийн судлагдахууны болон бүх мэргэжлийн багш нар хичээлдээ туршин хэрэгжүүлэх боломжтой

Шинэлэг тал/ашиг тус: Сурагчид насандаа тохирсон жижиг судалгаа хийж, бүтээлчээр хамтарч ажиллан мэдлэг бүтээх үйлд суралцаж байгаагаараа ач холбогдолтой

Товч агуулга

Төрөл бүрийн судалгаа, шалгалт болон ЭЕШ-ийн байдлаар харахад манай сурагчид жиших, харьцуулах, бүтээх, нөхөх, тооцоолол хийх зэрэгт тааруухан байдаг нь бидний заах арга барилд өөрчлөлт гаргах зайлшгүй шаардлага харуулж байна.

Энэ нь багшийн заасан хичээлийг сурагчид удалгүй мартдаг нь хичээлээ хэрэглээ болгож чадаагүйтэй холбоотой. Бидний судалгааны үр дүнд хүүхэд бүрийн сурч мэдэх математикийн үндсэн 4 үйлдлээс гадна зэрэг дэвшүүлэх, язгуур гаргах, логарифмчлах үйлдлийг зайлшгүй суурь мэдлэг болгон сургахад хүүхдүүд өөрсдөө бүтээлчээр суралцан цаашид эдгээр үйлдэл дээр амжилттай суурилан суралцаж байна. Ер нь ямарч хичээл заасан хэрэглээ тал руу хандаж бодлого дэвшүүлж, сэдэл төрүүлж, асуудал шийдвэрлэж шинэ мэдлэгийг суралцагчид багшийн чиглүүлэгтэйгээр олж суралцахад гүн бат эзэмшиж чадах боломж харагдаж байна.

Нэгж хичээлээр хүүхэд бүрийг хөгжүүлэхэд оношилгооны арга зүйг ашиглах нь

Д.Анхбаяр

Завхан аймаг, Баянтэс сумын сургууль, мэдээллийн технологийн багш

Зорилго: Сурагчийн өмнөх мэдлэгийн оношилгоог хийж, бусад хичээлтэй холбох зэргээр хүүхэд бүрийг хөгжүүлж, дэмжих ямар боломж байгаа талаар судалж, дүн шинжилгээ хийн сургалтдаа хэрэгжүүлж буй арга, туршлагаасаа бусад багш нартайгаа хуваалцахад оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: 7-р ангийн “Танилцуулга боловсруулах технологи” сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын оношилгоо хийж, түүн дээрээ тулгуурлан 8-р ангид энэ сэдвээр ямар мэдлэг, чадвар эзэмших чадварын жагсаалтыг сурагч бүрээр гарган, монгол хэлний хичээлийн “Баримт мэдээллийг дүрслэх” “Баримт жишээ ашиглан тайлбарламж бичих” нэгж хичээлүүдтэй холбон нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан туршин сайжруулсан.

Судалгааны үр дүн: Оношилгооны үр дүнд тулгуурлан багшийн зүгээс хүүхэд нэг бүрд тохирсон төлөвлөгөөг хүүхдийн мэдлэг, чадвар бүтээх үйлийг дэмжихэд туслах байдлаар сурагчидтай хамтран төлөвлөснөөр тэдний мэдлэг чадварт өөрчлөлт гарч байгаа нь ажиглагдсан.

Шинэлэг тал: Энэ аргазүйг интеграц хэлбэрээр бүх хичээл дээр ашиглаж үр дүнг нь тооцох боломжтойгоороо ач холбогдол нь оршино.

Түлхүүр үг: Оношилгооны аргазүй, Хүүхэд бүрийг хөгжүүлэх технологи

Товч агуулга

“Танилцуулга боловсруулах технологи” сэдвийн хүрээнд 8-р ангийн 6 цагийн нэгж хичээлийг зохион байгуулахдаа хүүхэд бүрийг оношлох аргазүйг ашиглан, хүүхэд бүрээр төлөвлөгөө гаргуулан ажилласан үр дүнгээсээ танилцуулж байна. Энэхүү судалгаат хичээлийг монгол хэлний хичээлийн сэдэвтэй холбон явуулсан нь бас нэг сайн аргазүй болсон гэж үзэж байна. “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, дэмжих = Хүүхэд нэг бүрийг оношлох” гэсэн таамаглал дэвшүүлж, 2 жилийн хугацаанд 4 ангийн 24 судалгаат хичээлийг зааж туршсан. Үүний дүнд мэдээллийн технологи хичээлийн амжилт сүүлийн жилд 12 %-иар ахиад зогсохгүй монгол хэлний хичээлийн амжилт 14%-иар ахисан үзүүлэлт гарсан.

“Зүг чиг” агуулгын хүрэн дэх интеграц хичээлийн ач холбогдол

*Г. Баярмаа, Д.Лхагвасүрэн, Т.Хоролгарав, Т.Нанжидмаа
Баянхонгор аймгийн “Эрдэм” ахлах сургуулийн багш нар*

Зорилго: Математик, физик, газарзүйн хичээлээр “Зүг чиг” сэдвийн хүрээнд суралцагчдад ажиглан, шинжлэн судлах чадварууд тус тусдаа салангад онолын түвшинд хэрэглэгддэг байсан бол хичээл хоорондын интеграц хийж зааснаар хэрэглээний чадварыг дээшлүүлэх боломжийг судаллаа.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Шинжлэн ухааны нэг хэсэг болох Хойд зүгийн одоор зүг чигээ хэрхэн зөв тойдорхойлж сурах, хэрэглэхэд физик, газарзүй, математик хичээлийн мэдлэг, чадварыг хэрхэн уялдуулан заахад сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүйг сонгон сайжруулж, хөгжүүлэх, хичээлийн судалгааг тасралгүй хийх менежментийн загварыг хандлага болгов.

Практик ач холбогдол: Суралцагчид ажиглалт туршилт хийж таамаглал дэвшүүлэх, эрэлт хайгуул хийж, хийсэн туршилтын үр дүнг тодорхойлж цаашид тухайн нөхцөл байдалд тулгуурлан Алтан гадас од буюу хойд зүгийг олох аргыг зөв сонгон авч ертөцийн зүг чигийг тооцоолж явах чигэл, болон орон зайн баримжааг бодож гаргах чадвартай болгосноороо практик хэрэглээ болно.

Шинэлэг тал: Суралцагчдад тухайн нөхцөлд зүг чигээ олоход тохирсон аргыг сонгон, явах чиглэлийнхээ төлөвлөлтийг гаргаж чадах чадварыг суулгаж өгч байна.

Түлхүүр үг: ертөнцийн зүг чигийг тооцоолох, сурагчид ажиглалт хийн таамаглал дэвшүүлэх, дэвшүүлсэн таамаглалаа сорил туршилтаар шалгах

Товч агуулга

Энэхүү судалгаат хичээл нь физикийн 7-р ангийн агуулгад “Одот тэнгэрийн ажиглалт”, Газарзүйн 7-р ангийн агуулгад “ГЕО-орон зайн дүрслэл”, Математикийн 8-р ангийн хичээлийн агуулгад Өнцөг, тойрог зэрэг 3 нэгж хичээл тус бүрд өөр өөрийн гол эзэмших ёстой онол, арга зүйн чадамжуудыг тусгагдан заагдахаар төлөвлөгдсөн байдаг. Үүний үр дүн суралцагчид ямар орчин нөхцөлд зүг чигээ зөв олох чадвар нь гурван хичээлийн агуулга тус бүрээр салангид суугддаг байсан бөгөөд энэ нь практик хэрэглээ байхгүй мөн багш нарт хичээл заахад бусад судлагдахууны мэдлэг дутагдах зэрэг бэрхшээл гарсан тул физикийн багш, газарзүйн багш математикийн багш нар хамтран “Төөрсөн

аялагчдад тусалцаагаар” нэгж хичээлийг 8-р ангийн а, б, в, г анги 7-р ангийн а, б, в, г ангиудад 2016 оны 04 сараас 10 сарын хугацаанд сайжруулах замаар нийт 6 удаа зааж танхимын болон танхимын бус туршилт хичээл орсон ба МХТ-ын цахим туршилт ашиглан ажиглалт туршилт хийж таамаглал дэвшүүлэх, дэвшүүлсэн таамаглалаа гарын доорх материал ашиглан сорил туршилт хийж гүйцэтгэх замаар шийдвэрлэх зэрэг алхамчлалтайгаар явагдсан.

Хичээлийн агуулгыг заахдаа “stellarium-10.2” цахим одон орны программ ашиглан өдрийн цагт од болон одны ордын байрлалыг судлах тухайн нутаг орны газарзүйн байрлалыг тооцоолон ангийн аль хэсэгт цацаж харуулах вэ? зэргийг харгалзан авч үзэж үнэн бодит шинжлэх ухаанч мэдээллийг сурагчдаар өөрсдөөр нь гаргуулж, тэдний шинжлэх ухаанд хандах сонирхлыг нэмэгдүүлж өгч чадсан.

Хүүхэд нэг бүрийг ажлын хуудас болон жишиг даалгавраар хөгжүүлэх нь

*Б.Дуламжав, Ч.Ууганбаяр, С.Чимис, С.Болор
Увс аймаг, Цогцолбор 2-р сургуулийн багш нар*

Зорилго: Бүтээлч эрэлхийллийн арга барилын үе шатуудаар дизайн технологи, түүх, орос хэл, газар зүйн хичээлийг бэлтгэн зааж, турших явцдаа суралцагч нэг бүрийн ахиц амжилт, төлөвшил, хичээлд хандах хандлага, түүнийг сайжруулах арга замыг илрүүлэхийг зорилоо.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд бүтээлч эрэлхийллийн арга барилын үе шатуудаар ажлын хуудас, жишиг даалгаврыг хийж Дизайн Технологи, Түүх, Орос хэл, Газар зүйн хичээлээр дунд ангийн сурагчдад хичээл заасан.

Судалгааны үр дүн: Энэхүү аргачлалаар ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулан хичээлийг туршиж зааснаар хүүхэд нэг бүр нэг нэгнээсээ суралцах бусдаас мэдээлэл олж авах бие даах чадварт сурсан.

Практик ач холбогдол: Бүтээлч эрэлхийллийн арга барилыг ашиглахад ээлжит хичээлийг боловсруулан зааж туршихад хүүхэд нэг бүр бүтээлчээр хандах, сурах идэвх өссөн мөн өөрөө өөрийгөө үнэлдэг болсон.

Түлхүүр үг: Багш, хүүхдийн хөгжил, бүтээлч эрэлхийллийн арга, ээлжит хичээл, ажлын хуудас

Товч агуулга

ЕБС-д суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд, багш нар хичээл сургалтаар бүтээлч эрэлхийллийн арга барилыг хүүхэд нэг бүрт эзэмшүүлэх, хүүхдийн төлөвшил, хандлагыг сайжруулах үүрэг өнөө үед тулгараад байгаа билээ.

Үүнээс гарах арга замыг шийдэхийн тулд бүтээлч эрэлхийллийн аргаар Дизайн технологи, Түүх - нийгэм, Орос хэл, Газар зүйн хичээлийг бэлтгэн зааж, турших явцдаа суралцагч нэг бүрийн төлөвшил, хичээлд хандах хандлага, ахиц, явцыг сурагч бүр өөрөө өөрийгөө үнэлэх, хичээлийн үе шат алхам бүрээр ажлын хуудас (жишиг даалгавар) бэлтгэх, мөн самбар төлөвлөлт, түүнийг сайжруулах арга замыг эрэлхийлэн хичээл сургалтандаа туршин хэрэгжүүлсэн. Ингэснээр хүүхэд бүрийн сэтгэлгээ шинэчлэгдсэн, шинэ зүйлийг соргоогоор хүлээж авах болсон өөрийгөө бие даан хөгжүүлж мэдлэг олж авч шинийг эрэлхийлж чаддаг болсон.

Гэрийн даалгаврыг хүүхдэд дарамт биш хөгжих боломж болгох нь

М.Энхтуул, А.Оюунгэрэл, Б.Даваадулам, Ч.Эрдэнэбулган
Сэлэнгэ аймаг Сайхан сум Хөтөлийн ЕБС-ийн бага ангийн
багш нар

Зорилго: Хичээлийн судалгааны явцад хичээлийн бүтцэд гэрийн даалгавар нь өмнөх мэдлэгийг бататгах сэргээх нэг чухал элемент болж өгдөг учраас багш гэрийн даалгаварт хандах хандлагаа шинэчилж, арга барилаа өөрчилснөөр өөрөө ёс зүйн зөрчилд орохгүй, сурагчийг хичээлд айдасгүй инээд хөөртэй ирэх боломжийг нээх явдал гэж үзэж энэхүү гэрийн даалгаврын судалгааг танилцуулж байгаа юм.

Судалгааны үр дүн: Энэхүү туршилт судалгаагаар багш нар гэрийн даалгаврыг сурагчдын түвшинд тохируулж боловсруулж өгснөөр сурагчдыг хөгжүүлэх боломж байгааг олж харсан. Сурагчдыг бид хангалттай, дэмжлэг хэрэгтэй сайн, онц гэх мэтээр дүгнэдэг хэрнээ түвшинд нь тохирох даалгавар боловсруулж өгдөггүй, тэдний чадварт тохирсон даалгаврыг боловсруулалгүй сурагчдынхаа саналыг сонсохгүйгээр, хэдий хугацаанд хийж гүйцэтгэхийг тооцож бодолгүй өгдөг нь сурагчдад хичээлээ бататган бие дааж сурах боломж биш харин ч дарамт болж байна гэдгийг бид олж хараад үүнийг өөрчлөхийн тулд судалж, туршин үзэж хэрэгжүүлж байна.

Практик ач холбогдол: Хүүхэд бүрийн хүлээн авах чадвар өөр өөр байдаг учраас даалгаврыг түвшинд нь тохируулж сонголттой хэлбэрээр боловсруулсан арга зүйн шийдлийг хэрэглэх боломжтой.

Шинэлэг тал: Гэрийн даалгаврыг сонголттойгоор түвшинд нь тохируулж хийсэн. Гэрийн даалгаврыг “Өөрийгөө хөгжүүлэх бие даалтын цаг” гэж нэрлэсэн нь сурагчдад “Би өөрийгөө хөгжүүлэхийн тулд өөртөө тохирсон зүйлээ хийх ёстой юм байна” гэсэн ойлголттой болж, сурагчдад тухайн өдрийн хичээлээс даалгавар сонгох боломж олгосон.

Урмын үгийн хэрэглээг судалж, туршсан байдал

*Б.Буянхишиг, Л.Галтмаа, Т.Эрдэнэцэцэг, О.Янжмаа, Э.Сэрсэндэмид
Дархан-Уул аймаг, “Жигүүр цогцолбор” сургуулийн бага ангийн багш нар*

Зорилго: Урмын үгийн өнөөгийн хэрэглээ, үнэ цэнийг судлах, турших

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Хичээлийн судалгаа хийх явцдаа дараах аргуудыг туршиж, сурагчдын суралцах идэвхт гарсан ахицыг ажиглан тэмдэглэл хөтөлсөн.

- Сурагчдын даалгавар хийсэн дэвтэрт урмын үг бичих
- Сурагчдад урмын үгийг олон хувилбараар хэлэх
- Сурагчдадаа урмын захидал бичих
- Эцэг эхчүүдэд, хүүхэдтэйгээ тоглонгоо урмын үг хэрэглэх зөвлөгөө өгч ажиллалаа.

Судалгааны үр дүн: Сурагчид бусдын шаардлагагүйгээр гэрийн даалгавраа тогтмол хийдэг, хичээлд идэвхтэй оролцож, багшаас ойлгохгүй зүйлээ чөлөөтэй асууж байна. Мөн багшдаа хариу талархлын захидал бичсэн. Багш нарын болон эцэг эхийн урмын үгийн, үгийн сан арвижиж, эцэг эхийн оролцоо нэмэгдсэн.

Практик ач холбогдол: Ээлжит хичээлийн явцад сурагчдыг урмын үгээр урамшуулан дэмжсэнээр тэдний хичээлд оролцох идэвх нэмэгдэж, зөв дадал хэвшилтэй болно.

Шинэлэг тал/санаа: Багш бид сурагчдынхаа зөв хийсэн үйлдэл, хийх гэж хичээж оролдсон оролдлого бүрийг урмын үгээр харамгүй шагнах, дэвтэрт урмын үг бичиж үлдээх, урмын захидал бичих зэргээр идэвхжүүлнэ.

Түлхүүр үг: Урмын үг, төлөвшил, үнэ цэнэ

Товч утга

Багш, эцэг эхчүүд бид сурагчдаа өөртөө итгэлтэй, зөв хүмүүжил төлөвшилтэй болгохын тулд хүмүүжлийн олон аргыг хүүхэд бүрийн онцлогт тохируулан хэрэглэдэг боловч тодорхой үр дүн харагддаггүй. Иймээс хүүхэд бүрт жоргүйгээр тохирох аргыг туршин судлах хэрэгцээ байна.

Сурагчид багшийн хэлсэн, бичсэн урмын үгэнд урамшин өөртөө итгэлтэй болж, даалгавраа хийе, номоо уншъя, цэвэрхэн бичье зэргээр өөртөө шаардлага тавьдаг болж байгаа нь судалгаат хичээлийн явцаас харагдлаа.

“Надад туслаач” нэгж хичээл

М. Хандсүрэн, Г. Хэрлэн, З. Золзаяа

Говьсүмбэр аймаг, Лабортори 5-р сургуулийн Бага ангийн багш нар

Зорилго: “Надад туслаач” сэдвийн хүрээнд өөрт болон бусдад тусламж үзүүлэх аргаас заах

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Нэгдүгээр ангийн Бэлтгэл хөтөлбөрийн хүрээнд “Надад туслаач” хичээлийг 4 цагийг интеграцлан хичээлийн судалгааг зохион байгуулсан.

Судалгааны үр дүн: Энэхүү аргачлалаар ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулж хичээлийн судалгаат хичээл зааснаар 1-р ангийн хүүхдүүд төсөөлөн ярьж, зурж, будаж, нугалж, нааж, дуулах, чадварт суралцсан.

Практик ач холбогдол: “Надад туслаач” хичээлийг 4 цагийн турш интеграцлах аргыг ашиглан агуулгын багтаамж ихтэй сэдвийг хүүхэд нэг бүрийг оролцуулан зохион байгуулж болно.

Шинэлэг тал / санаа: Агуулгын багтаамж ихтэй сэдвийг хүүхэд нэг бүрт амьдралд ойрхон энгийн аргаар ойлгуулан, зурах, будах, ярих, нугалах, хайчлах, наах, дуулах чадваруудыг зэрэг хөгжүүлнэ.

Түлхүүр үг: Бэлтгэл хөтөлбөр, Надад туслаач, интеграци, нэгж

Товч агуулга

1-р ангийн Бэлтгэл хөтөлбөрийн агуулгын хүрээнд сурах бичиг нь агуулга ихтэй боловч хүүхэд ажиллах дасгал даалгавар дутмаг байгаагаас үндэслэн дэлгэрүүлэн заах шаардлага гарч ирсэн. Дээрх бэрхшээлээс гарахын тулд интеграцлах арга зүйг боловсруулан зохион байгуулсан.

- 1-р цаг: “Үлгэрийн цаг” (сонсох, ярилцах, төсөөлөн бодох)
- 2-р цаг: “Миний найзын хувцас” (хайчлах, наах, тохируулах)
- 3-р цаг: “Гарцаар гарахад нь туслаарай” (будах, наах, нугалах, дасгал хийх)
- 4-р цаг: “Найздаа хэрхэн туслах вэ?” (жүжигчилсэн тоглолт хийх)

Энэхүү аргыг ашиглан заах нэгж хичээлийн боловсруулсан хөтөлбөрөө сайжруулан туршиж зааснаар суралцагчид үр бүтээлтэй, сурах тэмүүлэлтэй, хийсэн бүтээлээрээ бахархах, бусдад чин сэтгэлээр туслах чадварт суралцана.

Багшийн бүтээлч хандлага хүүхдийн хөгжилд нөлөөлөх нь

¹Ц.Нарантуяа, ²Ж. Гантуяа

¹БМДИ-ийн бага боловсролын нийгмийн ухааны сургалт хариуцсан арга зүйч, ²БЗД-ийн 87-р сургуулийн сургалтын менежер

“Шавийн эрдэм багшаас, зулын гал тосноос” гэсэн ардын сайхан зүйр үг бий. Энэ нь сайн юмны хаялга их гэсэн санаа юм хэмээн толь бичигт өгүүлсэн байна. Бид хүүхэд бүрийн хөгжил, төлөвшлийн асуудлыг багшийн эв дүй, ур ухаантай холбож ойлгох нь түгээмэл болсон энэ үед багшид хүүхдийн хэрэгцээ сонирхол, туршлага, чадвар чадамжид суурилсан тэдний бие даан турших, ашиглах, эргэцүүлэх тунгаах боломж бололцоог бодож төлөвлөхөд дэмжлэг болохуйц арга зүйн зарим санааг асуудал болгон дэвшүүлж хэрхэн яаж түүнд бүтээлч хандах вэ гэдэг талаас зөвлөмж болгон өгөхийг эрмэлзлээ. Өөрөөр хэлбэл бага боловсролын байгалийн ухааны хичээлийг багшийн бүтээлч үйлээр хэрхэн хөтлөх боломжтой вэ гэдгийг Японд 2 сар гаран суралцаж ирсэн туршлагад тулгуурлан багш нарт заах арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх явцдаа хичээлд ажиглалт хийж хүүхдэд гарч буй өөрчлөлт хөгжүүлэх боломжийг туршлага болгон бусдад хуваалцахыг хүслээ. Багш хүн илүү сайн багш болохын тулд өөрөө сэтгэлтэй зүтгэлтэй хүсэл зорилготой байх хэрэгтэй бөгөөд бусдаас суралцах, бие биедээ багшлах, эрэл хайгуул хийх, бүтээлчээр сэтгэх аргад их сайн суралцах хэрэгтэй юм байна. Учир нь яагаад хэрэгтэй, юугаараа чухал, нарийн нандин нь юунд байгааг сонирхон ойлгож мэдэрсэн сурагч тухайн агуулгыг эзэмшихийн төлөө хүчин чармайлт гаргаж чадна. Тэгэхээр сур гэж тулган шаардахаас урьдаар учир шалтгааныг мэдрүүлэхийн төлөөх оролдого хийх нь чухал.

Түлхүүр үг: Бүтээлч хандлага, хүүхдийн хөгжил, зөв төлөвлөлт

Луувангийн ач тус

Д.Лхагвабаасан

Улаанбаатар, Шинэ-Монгол сургуулийн багш

Судалгаат хичээлийг явуулах үндэслэл: 6 настай сурагчдад өөрийгөө илэрхийлэх, өөрт тулгарч буй бэрхшээлийг сонирхон судлах чадвар сул, энэхүү чадвар нь хүн орчин болон биологийн хичээл дээр төлөвших чадвар учир луувангийн ач тус сэдвийг сонгон авсан.

Судалгаа хийх хэрэгцээ, шаардлага: 6 настай сурагчид том хэрчсэн болон дутуу болсон, өвөрмөц амттай хүнсний ногоо /сонгино, лууван, байцаа/-г үдийн хоолонд идэхгүй хаях, үүнээс үүдэн өлсөх, сэтгэл тавгүйтэх, огих зэрэг үйлдлүүд илэрч байсан.

Судалгааны зорилго: Луувангийн ашиг тусыг сонирхон судлах, бусдад өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадварыг нь нэмэгдүүлэх, бусдын хийсэн зүйлийг үр ашиггүй хаях хандлагыг өөрчлөх, эцэг эхэд дээрх асуудал тулгарч байгаа эсэхийг судлан түүнийг хамтран шийдвэрлэх

Товч утга

Хүүхдэд тулгарч буй луувантай хоол идэж чадахгүй байгаа бэрхшээлийг олж харан түүнийг шийдвэрлэх арга замыг хайн бусад багш нартайгаа хамтран судалгаат хичээлийг явуулсан. Судалгаат хичээлийг “Хүн ба Орчин” хичээлийн ургамал бүлэг сэдвийн хүрээнд “Луувангийн ач тус” сэдвийг сонгон хичээлийг төлөвлөн зааж 5 удаа сайжруулсан бөгөөд сурагчид хичээлд маш идэвхтэй оролцож сонирхон суралцсан. Лууван болон бусад хүнсний ногоог идэх дургүй байсан сурагчид аминдэм С илрүүлэх туршилтыг хийсний дараа лууван, сонгино, байцайны ашиг тусыг мэдэрч ногоотой хоолыг идэх гэж хичээсэн. Огт лууван иддэггүй байсан 25 сурагчаас лууван жижиглэн хэрчсэн тохиолдолд 20 сурагч иддэг болсон. Тухайн хичээлийг эцэг эхэд зааснаар хүүхдэд тулгардаг бэрхшээлийг хамтран шийдэх боломж гарсан. Луувангийн ач тус судалгаат хичээл нь цөм хөтөлбөр хэрэгжихэд тулгарч буй бэрхшээлийг багш нарын хамтын үйл ажиллагаа, арга зүйн тусламжтай шийдвэрлэх, сурагчдад сонирхон судлах чадварыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх хичээл болсон.

Түлхүүр үг: Туршилт, аминдэм С, лууван, тамедины уусмал, бяцхан эрдэмтэд, ажиглагч эрдэмтэд

Хичээлийн шинжлэх ухаанч арга барилын шинжийг үнэлэхэд мониторингийн хуудсыг туршсан үр дүнгээс

¹Б.Энхбилэг, ²Ш.Сайнбилэг, ³Н.Оюунцэцэг

¹124-р сургуулийн химийн багш

²Магистр, МУИС, ШУС-ийн багш, sainbileg@num.edu.mn

³Доктор, МУИС, ШУС-ийн зөвлөх проф., nookooyoyn@yahoo.com

Бага боловсролын сургалтын шинэчилсэн цөм хөтөлбөр (2014 он)-ийг хэрэгжүүлэх хүрээнд байгалийн ухааны хичээлийн зорилго нь сурагчдад шинжлэх ухаанч арга барил төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэгдэж байгаа билээ. Харин сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл санааг анги танхимын хичээлд буулган хэрэгжүүлэх байдал сургууль багш нарт харилцан адилгүй байгаа бөгөөд хэрхэн үнэлж, хөгжүүлэх нь шийдвэрлэх шаардлагатай асуудлын нэг байсаар байна.

Иймд бид энэхүү судалгаагаар сурагчдад шинжлэх ухаанч арга барил төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулахад чиглэгдэж буй хичээл ямар шинжтэй болохыг судалж, түүнийг илрүүлж, үнэлэхэд хичээлийн мониторингийн хуудас ашиглах боломжтой эсэхийг туршиж судалсан болно. Ингэхдээ бага боловсролын байгалийн ухааны хичээлээр нэг улирлын хугацаанд нийт 24 цагийн хичээлийн судалгаа зохион байгуулсан.

Судалгаанд Бага боловсролын сургалтын шинэчилсэн цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын төвийн сургуулийг сонгон авсан бөгөөд харьцуулан судлах зорилгоор 5 дугаар ангийн нийт зургаан бүлгийг хамруулж, сонгосон бүлгийн хичээлийн судалгааг зохион байгуулахдаа гурван төрлийн хичээлийн мониторингийн хуудас ашигласан болно.

Судалгааны үр дүнг үнэлэхдээ хичээлийн нэгжийн хүрээнд сурагчдын эзэмшсэн мэдлэгийг илрүүлэхэд чиглэсэн сонгох хариултат даалгавар, шинжлэх ухаанч арга барилын чадварын илрэлийг үнэлэхэд чиглэгдсэн бүтээх даалгавар боловсруулж, сурагчдын гүйцэтгэлд анализ хийж, харьцуулсан.

Сонгох хариултат даалгаврыг боловсруулах, сурагчдын гүйцэтгэлийг үнэлэхдээ ITEM анализын аргыг, бүтээх даалгавар боловсруулж, сурагчдын гүйцэтгэлийг үнэлэхдээ рубрикийн аргыг ашигласан болно.

Судалгаагаар хичээлийн онцлог, шинж чанарт үндэслэн хичээлийн

мониторингийн хуудсын агуулга сонголтыг хийж хөгжүүлэн хэрэглэх нь илүү үр дүнтэй байна гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Түлхүүр үг: Хичээлийн судалгаа, шинжлэх ухаанч арга барил, хичээлийн мониторингийн хуудас

Туршилтаар хүүхдийн хөгжлийг дэмжих, мэдлэг бүтээлгэх арга зүй

*Г.Лхамноржин Ц.Түмэнжаргал Б.Бадамханд М.Мөнхбаяр Э.Бурмаа
Дархан-Уул аймаг, Шарын гол сум, 2-р сургууль*

Зорилго: Энэхүү ээлжит хичээлээр дамжуулан хүүхэд нэг бүрийн сонирхлыг төрүүлэхээр хялбар туршилтын аргуудыг таниулах, туршилтаа амьдралдаа хэрэгжүүлж аливаа уусмалаас ялгарсан бодисыг харагдах байдлаар чанар нь ямар болохыг танин мэдэх, бие даан туршилт хийж чадахаар хөгжүүлэх, хүүхдийн сурах үйл явцад хэрхэн дэмжлэг үзүүлж чадаж буйг судалгаат хичээлээр судлах үр дүнг тооцоход оршино.

Судалгааны загвар \ арга зүй\ хандлага: Бидний амьдралд гол байнгын хэрэглээ болох \ус+ бодис=уусмал\ давсыг сонгон авч бодисыг ялган авах туршилтад хичээлийг “Давс хаанаас үүссэн бэ” сэдвийн хүрээнд заахаар бэлтгэлээ. Судлагдахууны багийн багш нар хичээлээ сонирхолтой хүүхдийн анхаарал татахуйц болгохын тулд гарын доорх материалаар \Увс нуурын загвар махет, Увс аймгийн голуудыг төлөөлсөн хуулган гол, шахмал түлш \ өвөрмөц хэрэглэгдэхүүнийг бэлтгэж давсыг хэрхэн гаргаж авах аргыг ЕБС-ийн 4-р ангийн сурагчдыг өөрсдөөр нь туршилт хийлгэхдээ хөгжүүлэх, танин мэдүүлэх, мэдлэг бүтээлгэх арга зүйг боловсруулсан. “ Давс хаанаас үүссэн бэ” сэдэвт судалгаат хичээлийн агуулга арга зүйг танилцуулж байна.

Судалгааны үр дүн: Энэ хичээлийн гол хэсэг болох давсыг хаана байдаг, хаанаас авдаг тухай ойлголтыг бага насны хүүхдэд өгөхийн тулд эртний үлгэрээс санаа аван домгийг ярьж өгч, давс томоохон гол, нууранд байдгийг мэдэх, монгол орны хамгийн их давстай нуур Увс болохыг сонгон авч улмаар мэдээлэл олгох ба сонгон авсан монгол орны үзэсгэлэнт газраа төсөөлөх, юмс үзэгдлийг бодит байдлаар нь байгаа мэтээр хүртэж мэдрэх, ам дамжсан яриа үнэн болохыг туршилтад хичээлээр баталж нотлохыг хичээн уусмлаас бодисыг ялгаж салгах, тэдгээрийн найрлага дахь бодисыг таних, амьдрал дээр хэрэглээ болох энгийн аргуудыг мэдэж авч байгаа нь харагдсан.

Практик ач холбогдол: Уусмалаас бодисыг ялгаж авах аргуудыг мэдсэнээр ялангуяа хүүхдүүд гэртээ ээжийн чанасан цай, дуртай ундаагаа ямар уусмал болохоо өөрсдөө гэртээ плитка, ангидаа нарны тусгалаар туршиж мөн бодисыг ялгахад аль алинд хэр их хугацаа шаардлагатай болохыг тогтоох, ялган авсан бодисоо өөр юунд хэрэглэж болох талаар ярилцах нь ирээдүйд судлаач болоход ба дунд ангийн химийн хичээлийн анхан шатны мэдэхүйтэй болж байна.

Шинэлэг тал\ санаа:

- Хичээлийн сэдвийг сэдэлжүүлэхдээ бага насны хүүхдийн онцлогт тохируулан хүүхдийн сонсох дуртай үлгэрээ сэдэлжүүлэн үлгэр үнэн эсэхийг батлах туршилтад тулгуурласан.
- Сэдэлжүүлэлт хэсгийг маш сонирхолтойгоор хичээлд татан оролцуулахад нэмэр болохын зэрэгцээ өмнөхийг бататгахаа арай өөр хэлбэр болох 2-3 туршилтаар бататгасан.
- Мөн сурагчдыг эх орныхоо үзэсгэлэнт нутгаар аялах сэтгэгдэл төрүүлэхүйц орчинг бүрдүүлэхдээ танин мэдэхүйн мэдээлэл өгсөн.
- Уусмалаас бодисыг ялгах аргуудыг мэдэх, ахуй амьдралдаа юуны уусмал болохыг шууд танин мэдэх, ялгах энгийн аргыг өөрсдөө туршиж чадахаар болсон.

Түлхүүр үг: гарын доорх материал, туршилт, уусмал, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, судалгаат хичээл

Товч агуулга

Гарын доорх материал ашиглан бэлтгэсэн хэрэглэгдэхүүн, спиртэн дэн, туршилтын плитка ашиглан уусмалаас бодисыг ууршуулах аргаар ялгаж авах туршилтад хичээлийг зохион байгуулж, түүний агуулга арга зүйг хэрхэн сайжруулсан талаар судалгаат хичээлийн үр дүнг танилцуулж байна.

Энэхүү туршилтад хичээлээр хүүхдийг байгалийн шинжлэх ухааны хичээлд дур сонирхолтой болгож, өөрсдөө шинжээч судлаач болж юуг судлах гэж байгаа туршилтын зорилгыг тодорхой болгож, таамаглал дэвшүүлэн, тэрхүү таамаглалаа батлах туршилт явуулж, туршилтаас гарсан үр дүнгээ бусдадаа илтгэж дүгнэлт гаргуулав. Ингэхдээ туршилтад ашигласан хэрэглэгдэхүүн нь гарын доорх олдоц ихтэй материал ашигласан. Энэ туршилтад хичээлээ 4-5-аар ангийн нийт 8 бүлгийн нийт 218 сурагчдад 8 цагийн хичээлийг зааж туршсан. Хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн явц ажиглалт хэлэлцүүлгийн үр дүнд туршилтын үр дүн болон хичээлийн төгсгөл хэсгийг чанартай зохион байгуулахын тулд самбар төлөвлөлт, багшийн асуултууд нь сурагчдын суралцах үйл явцад нь хэрхэн дэмжлэг үзүүлж буй эсэх, мөн сурагчдын дэвшүүлсэн таамаглал, гаргасан алдаа, үл ойлгосон байдал, асуултанд хэрхэн хариулсан зэргийг нарийн тооцсон.

Соронз юуг татдаг вэ?

Ж.Урантогос, М.Энхчимэг, Л.Өнөржаргал,

Дорнод аймаг 8-р сургууль

Зорилго: “Хүн байгаль” хичээлийг бага ангид сорил туршилтаар мэдлэг бүтээх арга зүй, хэрэглэгдэхүүний судалгаанд суурилан хүүхэд бүрийн оролцоог хангах, бүтээлч үйлд хөтлөн чиглүүлэх арга зүйд тулгуурлан сайн хичээлийг зохион байгуулснаар суралцагчдын мэдлэг эзэмшилтэд эерэгээр нөлөөлж, түүнийгээ хэрэглэх, сэргээх чадвар сайжирна.

Судалгааны үр дүн: Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогийг харгалзан “Хүн байгаль” хичээлд төлөвлөж болох үйлийг хэрэглэгдэхүүний судалгаан дээр үндэслэн төлөвлөж, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн нь суралцагчдын мэдлэг эзэмшилтэд эерэгээр нөлөөлж, түүнийгээ хэрэглэх, сэргээх чадвар сайн байгааг тогтоосон.

Практик ач холбогдол: Соронзны хэрэглээний ач холбогдол мөн соронзны зөв хэрэглээнд суралцах анхан шатны мэдлэг, чадварыг туршилт сорилын үр дүнд эзэмшүүлэх боломжтой энэхүү хичээлийн арга зүйг 4-р ангийн “Соронзны үйлчлэл”, “Соронзон туйл”, сэдвийн хичээлийн бататгал, сэргээн сануулахад ашиглах боломжтой.

Шинэлэг тал/санаа: Арга зүй, хэрэглэгдэхүүний судалгааг нарийн хийж бүтээлч үйлд хүүхэд бүрийн оролцоог хангахад хөтлөн чиглүүлэх хичээлийн арга зүйг боловсруулсан ба хичээлийг сорил туршилтаар ээлжит хичээлийн хэрэгжилтийг бүхэлд нь харах, суралцагчдын мэдлэг эзэмшилтийн явцыг үнэлэх, үр дүнг тооцох боломжийг олж харсан нь шинэлэг тал болно.

Түлхүүр үг: Хичээлийн судалгаа, хүүхдийн хөгжил, хүүхдийн танин мэдэх онцлог, соронз, татагдах, татагдахгүй, төмөрлөг зүйлс

Товч агуулга

Хүн байгаль хичээлийн агуулгаар эзэмшсэн мэдлэг, чадвар нь хүний насан туршийн амьдралд хэрэглээ болон хэрэглэгддэг үр дүнтэй учраас хүн байгаль хичээлийн “Соронзон юу татдаг вэ?” судалгаат хичээлийг бэлтгэхдээ хэрэглэгдэхүүний судалгааг нарийн хийж бүтээлч үйлд хөтлөн чиглүүлэх хичээлийн арга зүйг боловсруулав.

Хичээлийг судлагдахууны багийн багш нар хамтын хэлбэрээр заан туршлаа. Хичээлд багийн гишүүд 7 үзүүлэлтээр ажиглалт хийн үнэлгээ өгч, хичээл тус бүрийн дараа хичээлийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хөтөлбөрөө сайжруулахдаа багшийн тавих асуултуудыг үйл ажиллагаа тус бүрд бэлтгэсэн. Мөн хичээлийн эхлэл хэсэг

сэдэлжүүлэлтийг засан сайжруулж суралцагчдын сонирхлыг татаж, идэвхийг өрнүүлэн ажилласан.

Тухайн хичээлийг 4 ангийн нийт 122 сурагчдад заан засан сайжруулалтыг тухайн цаг үед хийж дараагийн ангид зааж байсан. Хичээлийг заах явцад сурагч бүр өөрийн сонирхсон зүйлийг сонгон авч туршилтыг гүйцэтгэж байсан нь хүүхэд бүрийн оролцоог хангасан хичээл болж байгаа нь харагдаж байсан.

Соронз юуг татдаг вэ? сэдэвт хичээлээр бидний өдөр тутмын амьдралд хэрэглэгддэг эд зүйлсийг бүтээсэн материалууд нь өөр өөр ялгаатай ба тэдгээрийн ямар материалтайг нь соронз татдаг болохыг өөрсдөө туршилт хийн батлаад тайлбарласан.

Туршилт нь даалгаврыг илүү бодит болгодог учраас энэхүү судалгаат хичээлээ туршилт хичээлийн хэлбэрээр явуулж, соронз юу татдаг болоод түүний хэрэглээний ач холбогдол мөн соронзны зөв хэрэглээнд суралцах анхан шатны мэдээллийг танилцуулсан

Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаагаар сурагчдыг сэдэлжүүлэх нь

Г.Оюунтуяа, М.Хараа, Д.Оюунмаа

Дорнод аймгийн 12 дугаар сургуулийн багш нарын арга зүйн баг

Зорилго: Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаагаар хүүхдийн хөгжих үйл явцад хэрхэн дэмжлэг үзүүлж чадаж буйг судлах, үр дүнг тооцоход оршино.

Судалгааны загвар/арга зүй/хандлага: 5-р ангийн сурагчдын бие даасан бүтээлч санаачилгыг хөгжүүлэн сурах болон амьдрах арга барилд сургахад суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Энэхүү хичээлийн судалгаагаар орон нутгийн өвөрмөц онцлог, буриад ёс заншлын талаар сонгож судлах, өөрсдөө гар бие оролцож бүтээх, хийсэн бүтээлдээ үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, бүтээлчээр суралцахуйн үйлийг хэрэглүүлснээр сурагчдын мэдлэг, чадварт өөрчлөлт гарч байгааг тогтоосон.

Практик ач холбогдол: Амьдрах чадварын цагаар энэхүү сэдвийг сонгон судалж, бусад бага ангийн сурагчдад таниулснаар бага ангийн нийт 430 сурагч 100% буриад дээлтэй болж, буриад бүжгээ 100% бүжиглэж сурсан.

Шинэлэг тал/ашиг тус: Сургалтыг дэмжих цаг нь хүүхдийн хэрэгцээ сонирхолд нийцсэн, тэдэнд чөлөөтэй сэтгэн бодох, бүтээлчээр ажиллах нөхцөл бүрдүүлэн, сургууль, багш, байгууллага, иргэд, эцэг эхийн оролцоонд тулгуурлаж, танхимаас гадуур орчин, нөхцөлд зохион байгуулах онцлогтой үйл ажиллагаа юм.

Товч утга

Амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны цагийг зохион байгуулахдаа ахмад үеэсээ суралцах, уламжлал ёс заншлыг авч үзэх нь хүүхдийн төлөвшил, суралцах чадварт эерэг нөлөө үзүүлдэг болохыг нотлон харуулахыг зорьсон. Иймд энэхүү үйл ажиллагааг зохион байгуулах арга зүй, технологийн шинэчлэлд бага ч гэсэн хувь нэмэр оруулах, амьдрах чадварт суралцах цагийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, бусад багш нартай хамтран гарын доорх материал ашиглан өөрсдөө хэрэглэгдэхүүн бэлтгэж болохыг бага ангийн багш нарт таниулах болно.

Түлхүүр үг: сэдэв сонголт, хүүхдийн хөгжил, гарын доорх материал, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, танхимын бус арга

Дунд ангид ороход бэлэн үү

П.Болорцэцэг¹ Д.Цэрмаа² С.Хэрлэн³

УБ хот МУБИС-ийн харьяа ЕБС-ийн бага ангийн багш

Зорилго: Суралцагч бодит үйл ажиллагаанд оролцох явцдаа эрэл хайгуул хийх, асуудал олж харах, эргэцүүлэн бодох, дүгнэх, асуудлыг илүү сайнаар шийдвэрлэх арга барил, чадварт суралцана.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Сурагчид өөрийн тулгамдаж буй асуудлын хүрээнд “Дунд ангид ороход бэлэн үү” сэдвийг сонгон эрэл хайгуулын явцад бүтээлчээр хамтран ажиллах, өөрийн амьдрах арга ухааныг эргэцүүлэн бодох, суралцах хүсэл эрмэлзэл, бие даан ажиллах, суралцах, нийгэм амьдралын өөрчлөлтөд өөрийгөө бэлтгэн дасан зохицож амьдрах арга ухаанд суралцахад чиглүүлж 2014-2015, 2015-2016 оны хичээлийн жилүүдэд 5-р ангийн гурван бүлэгт үйл ажиллагааны агуулга, арга зүйг сайжруулан хичээлийн судалгааг хийсэн болно.

Судалгааны үр дүн: Энэхүү үйл ажиллагаагаар багаар ажиллах, янз бүрийн насны янз бүрийн мэргэжлийн хүмүүстэй харилцаа тогтоох, эргэцүүлэн бодох, дүгнэх, асуудлыг шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах, нийгмийн амьдралын өөрчлөлтөд өөрийгөө бэлтгэж /сэтгэлзүй/ цаашид суралцах хүсэл эрмэлзэл, ярих илтгэх чадварт ахиц өөрчлөлт гарч байгааг илрүүлсэн.

Практик ач холбогдол: АЧСҮА-ны цагаар эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийн байгууллага, сургууль болон удирдах ажилтан, бусад сургууль хамт олонтой үйл ажиллагаагаа нэгтгэн асуудлыг шийдвэрлэж хамтран ажилласан бөгөөд “Дунд ангид ороход бэлэн үү” багц цагийн хүрээнд 5-р анги төгсөөд 6-р ангид элсэн суралцахад сурагчид болон эцэг эхчүүд сэтгэлзүйн хувьд бэлтгэлттэй болж чадсан.

Шинэлэг тал, ашиг тус: “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа”-ны цагийг системтэй, шинжлэх ухааны үндэстэй, бүтээлч, тогтвортой олгох арга замыг тодорхойлоход оршино.

Түлхүүр үг: Амьдрах чадварт суралцах, тулгамдаж буй асуудал, асуудал шийдвэрлэх, арга замыг хайх, илрүүлэх, судалгааны гүйцэтгэл, үр дүн

Товч агуулга

Бага боловсролын цөм хөтөлбөрийн агуулгад “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны цаг” нь шинээр тусгагдсан, бага ангийн багш нарын хувьд шинэлэг, хэрхэн зохион байгуулах арга зүй ба туршлага дутмаг учраас энэхүү үйл ажиллагааны цагийг мэргэжил нэгт багш нартаа санаа авах үүднээс судалгаа туршилт явуулж тодорхой үр дүнд хүрснээ танилцуулж байна.

Бага ангийн сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх боломж

А.Мөнхжаргал

Дорнод аймаг 8 дугаар сургууль

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Сурагчдын бүтээлч сэтгэлгээ, хандлагад гарч буй өөрчлөлт, бүтээлч сэтгэлгээний дадал хэрхэн дээшилснийг а) дасгалыг туршин хэрэгжүүлсэн үр дүн б) сурагчдыг дасгал гүйцэтгэх явцад ажигласан үр дүн в) дасгалыг гүйцэтгэсний дараа сурагчидтай хийсэн ярилцлагын үр дүнгээр тус тус судаллаа.

Судалгааны үр дүн: Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх дасгалыг, идэвхтэй суралцахуйн арга зүйтэй хослуулан хэрэгжүүлснээр хүүхдийн бүтээлчээр сэтгэн бодохуй, суралцахуй, сэтгэлгээний хандлага, нийгэмшихүйд ахиц өөрчлөлт гарч байгааг тогтоосон ба энэ арга зүйгээр хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх боломжтой болохыг мэдэрсэн.

Шинэлэг тал/санаа: Хичээлийн агуулгыг сурагчдын хэрэгцээтэй холбож сэдэл тэмүүллийг төрүүлж, сэтгэлийг хөдөлгөн, би чадах юм байна, дахиад хийж үзэх юмсан гэсэн хандлага итгэлийг өгч, тэдэнд чөлөөтэй сэтгэн бодох, бүтээлчээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, аливаа асуудлыг шийдвэрлэх олон хувилбар байдгийг ухааруулах нь багшийн бүтээлч үйл ажиллагаа, арга зүйгээс шалтгаалж байна.

Түлхүүр үг: Бүтээлч сэтгэлгээ, ахиц, өөрчлөлт, сурагчийн оролцоо, хандлага, сэтгэн бодох чадвар, суралцахуйн чадвар

Товч агуулга

Хүүхдийн суралцахуйгаар нь дамжуулан шинэ санаа, сэдэл төсөөллийг бий болгох, сэтгэх хурд, сэтгэлгээний уян хатан чанарыг хөгжүүлэх, улмаар бүтээлч сэтгэлгээний дадалтай болгох зорилгоор 3 төрлийн дасгал, даалгаврын сантайгаар арга зүй технологийг боловсруулан хэрэгжүүлсэн ба үйл ажиллагааг явуулахдаа бүтээлч сэтгэлгээний БАГЦ аргыг хэрэглэн зохион байгуулав. Судалгаанд 5-р ангийн 3 бүлгийн 75 сурагч, бага ангийн 3 багш, 18 эцэг эхийг хамруулсан.

Бага насны хүүхдийн харагдах дүрээр ойлгох сэтгэхүй давамгайлдаг танин мэдэхүйн онцлог болон дүрслэн урлах сонирхол, хэрэгцээнд нийцүүлэн сэтгэн бодох, хувирган өөрчлөх, ургуулан бодох, дүрслэн зурах, тайлбарлан ярих зэрэг суралцахуйн бүтээлч үйлээр дамжуулан гүйцэтгэх даалгаврыг боловсруулсан.

Туршилтын явцад баримт бичгийн шинжилгээ, туршилт, ажиглалт, фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага зэрэг аргуудыг ашиглан өгөгдөл цуглуулж, тоон болон чанарын үнэлгээг хийхэд хүүхэд өөрийн мэдлэг туршлагадаа тулгуурлан, асуудлыг шийдвэрлэх, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдаас суралцах боломж бүрдсэнээр сэтгэл хөдлөл зоригийн, оюун ухааны, нийгэмшихүйн хөгжилд тодорхой ахиц, өөрчлөлт гарч байгаа нь багш нарын ажиглалт, судалгаа, сурагчид, эцэг эхийн ярилцлагаар батлагдсан.

Анхны тоог таниулах арга зүйн туршлага

Н.Оюунхүү¹, У.Алтанцоож¹, Б.Дүгэрмаа¹, Т.Мөнхцэцэг¹

Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн бага боловсролын багш нар

Зорилго: ЕБС-ийн 5-р ангид математикийн хичээлээр анхны тооны талаарх ойлголтыг өгөгдөл ашиглан, (100-тын хүснэгт) ажлын хуудсанд бүртгэл хөтлүүлэн таниулах арга зүйн санааг турших, судалсан үр дүнг түгээн дэлгэрүүлэх

Судалгааны загвар арга зүй хандлага: Бага боловсролын агуулгад анхны тооны нь шинээр тусгагдсан ойлголт юм. Тухайн агуулгыг заах арга зүй багш нарт дутагдалтай байдаг тул уг ойлголтыг сурагчдын идэвхтэй бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан ажлын хуудсанд тэмдэглэн бүртгэх замаар хүүхдэд сонирхолтой, үр дүнтэй явуулж болох арга зүйн хувилбарыг боловсруулж туршсан.

Судалгааны үр дүн: Энэхүү арга зүйн гол онцлог нь багш хүүхдийн хийх үйлүүдийн залгамж холбоо, уялдааг тооцон, нээлттэй асуултаар чиглүүлж, ажлын хуудсанд тэмдэглүүлэн бүртгүүлж тэдний өмнөх мэдлэг, чадвар, идэвхтэй бүтээлч үйл ажиллагаа, (таамаглах, тооцоолох, ажиглах, харьцуулах, нэгтгэх) нас сэтгэхүйн онцлогт тохирсон арга зүйгээр мэдлэгийг бүтээлгэж байгаад оршино.

Практик ач холбогдол: Өмнөх мэдлэг дээрээ тулгуурлан анхны тоог олох явцдаа аливаа зүйлийн холбоо хамаарал, мөн чанар, зүй тогтлыг өөрийн бүтээлч үйлээр \тооцоолох, тэмдэглэх, таамаглах, ажиглах тайлбарлах, нэгтгэх\ дамжуулан дүгнэлт гаргах чадварт суралцаж байгаагаараа хүүхдийн сурах арга барил, бүтээлч хандлагыг дэмжсэн. Энэхүү арга зүйн санааг ЕБС-ийн бага боловсролын багш нар өөрийнхөө хичээл үйл ажиллагаандаа туршин хэрэгжүүлэх боломжтой.

Шинэлэг тал санаа: Анхны тоог олох аргачлалыг өмнөх мэдлэг дээр нь тулгуурлан суралцагчдыг баг дотор хосоор зохион байгуулан хос бүрийн ажлын үр дүнг ажлын хуудсанд тэмдэглүүлж бүртгүүлэх замаар мэдлэг бүтээлгэсэн нь шинэлэг.

Түлхүүр үг: анхны тоо, тооны хуваагч хуваагдагч, 1 ба өөртөө хуваагддаг тоо, тооны хуваагдах шинж, өгөгдөлтэй ажиллах, бүртгэл хөтлөх, ажлын хуудас

Товч агуулга

Тооны хуваагч ба хуваагдагчийг таних, тооны хуваагдах шинжийн мэдлэг чадвар дээр нь тулгуурлан 1-10 хүртэлх тооны хуваагчийг олох хялбар даалгаврыг гүйцэтгүүлж ажиглуулснаар хуваагчуудын шинжийг тодорхойлох, зөвхөн 1 ба өөртөө хуваагддаг өөр хуваагчгүй тоонуудыг ялгах, энэхүү шинжид тохирох тоонуудыг 11-20 хүртэлх

тооноос олох тооцоолох, 21-100 —ийн тооноос тооны хуваагдах шинж, мөн үржүүлэх хуваах хүрд зэргийг ашиглан анхны тоог олж тэмдэглэн бүртгэх, ойлголтой болох, тодорхойлолт гаргах хялбар үйлийн үр дүнд эмх цэгцтэй мэдлэгийг бүтээж, ажиглалтын явцад дүгнэлт гарган баталж нотолж бүтээлчээр суралцах боломжийг олгосноороо хүүхдийн хөгжлийг дэмжсэн хичээл болж чадсан.

Суралцагчдын хийх үйлүүдийг алхамчлан тогтоож, нээлттэй асуултаар чиглүүлэн ажлын хуудсыг ашиглан бүртгэл тэмдэглэл хийлгэн мэдлэгийг бүтээлгэх нь ажиглах, эргэцүүлэн бодох, харьцуулах явцад дүгнэлтийг оновчтой гаргахад дөхөм болдог давуу талтай. Ээлжит хичээлийн төлөвлөлтийн үйлүүдийн уялдаа холбоо, шилжилт нь хүүхдэд ойлгомжтой, сонирхолтой, тэднийг идэвхтэй үйлд хөтөлсөн, энгийнээс нарийн руу хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн, тасралтгүй шинжтэй бөгөөд ажиглах, таамаглах, эргэцүүлэн бодох үйлүүдийн үр дүнд дүгнэлт нотолгоо гаргаж асуудал шийдвэрлүүлж байгаа нь аливаад эмх цэгц, эрэмбэ дараалалтай бүтээлчээр хандах хандлагыг өөрчлөх ач холбогдолтой.

Ээлжит хичээлээр хүүхэд бүрийн сэтгэхүйг хөгжүүлэх 5 хором

Ч. Түмэндэмбэрэл

Орхон аймаг "Наран" цогцолбор сургуулийн багш

Зорилго: Хүүхэд бүрийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх 5 хором арга зүйг боловсруулан хэрэгжүүлснээр хүүхдийн ажиглах, харьцуулах, хийсвэрлэх, учир шалтгаан холбоо хамаарлыг илрүүлэх, таамаглал дэвшүүлэх, таамаглалаа шалгах, нэгтгэн дүгнэх чадваруудыг хөгжүүлж байгаа арга туршлагаа танилцуулж байна.

Судалгааны загвар \арга зүй\ хандлага: Математикийн судлагдахууны I-V ангийн агуулгын хүрээнд сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан ээлжит хичээлээр хүүхэд нэг бүрийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх 5 хором арга зүйг боловсруулан хэрэгжүүлж ажиллав. Судалгааг хийхдээ ангийн сурагчдыг гарааны түвшинг тогтоож тусгайлан боловсруулсан тестээр шалгаж судлаад 3 түвшинд хуваагаад анги бүрийн агуулга болон сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан математикийн судлагдахууны сэтгэхүй хөгжүүлэх бодлогоо мөн 3 түвшинд хөнгөнөөс хүндрүүлэх зарчмаар хувааж даалгаврын сан бүрдүүлж, даалгаврын сангаа эрэмбэлж ээлжит хичээл бүр дээр арга зүйн туршилт явуулж ирлээ.

Судалгааны үр дүн: Бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх 5 хором арга зүйг боловсруулан хэрэгжүүлсний үр дүнд багш арга зүйгээ хөгжүүлж улмаар хүүхэд бүрийнх нь бүтээлч сэтгэхүй нь хөгжсөн.

Практик ач холбогдол: Энэ хичээлийн хөтөлбөр, хөгжүүлэх даалгаврын санг II-V ангийн математикийн хичээлүүдэд ашиглах боломжтой.

Шинэлэг санаа: ЕБС-ийн математикийн хичээлийн агуулгын хүрээ тоо тоолол, геометр, хэмжигдэхүүн, өгөгдөлтэй ажиллах, асуудал шийдвэрлэх гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй.

“Өгөгдөлтэй ажиллах”- ын суралцахуйн зорилтуудыг бусад хэсгүүдийн холбогдох зорилтуудтай хамтад нь хэрэгжүүлснээр сурагчдын бүтээлч сэтгэхүй хөгжинө гэж үзсэн. Иймээс ээлжит хичээл бүрийн явцад хүүхэд бүрийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх боломжийг судалж, арга зүй технологи боловсруулж, үр дүнг тооцсон. Хичээлийн төгсгөл хэсэгт “Хөгжүүлэх үе” шатыг оруулж 5 минутад хөгжүүлэх бодлогуудыг өдөр бүр бодуулж байснаар хүүхэд бүрийн сэтгэхүйн үйлдлүүдийг хийх чадварыг хөгжүүлснээрээ давуу юм.

Товч агуулга

Суралцагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх чиглэлийн даалгавруудыг гурван түвшинд хөнгөнөөс хүндрүүлэх зарчмаар хувааж даалгаврын сан бүрдүүлж, даалгаврын сангаа эрэмбэлж ээлжит хичээл бүрийн 5 хоромд гүйцэтгүүлж хүүхэд бүрийг сэтгэхүйг хөгжүүлэх боломж байгааг туршилтаар нотолж үр дүнг тооцсон


Бүтээлч сэтгэхүйг **“хөгжүүлэх 5 хором”** арга зүйг боловсруулан хэрэгжүүлснээр сурагчдад тайлбарлах, өөрийгөө илэрхийлэх чадвар, бусдыг сонсох чадварт ахиц гарлаа

Шулууны хувьд тэгш хэмтэй дүрс байгуулах

Ч.Агваантогтох Б.Оюумаа Д.Оюунтүлхүүр, Б.Мөнхтуяа Б.Ариунжаргал

Орхон аймаг, Баян-Өндөр цогцолбор сургуулийн багш

Зорилго: Дүрсийг шулууны хувьд тэгш хэмтэйгээр зурж байгуулахдаа суралдцагчдад тулгарах бэрхшээлийг туршилтаар учир шалтгааныг ойлгуулах арга зүйн шийдлийг хамтран шийдвэрлэхэд оршино.



Судалгааны загвар

Судалгааны үр дүн: Бага ангид тэгш хэм, паралель зөөлт, эргүүлэлт зэрэг сэдвийг заах нь агуулгын хувьд хүнд, шинэ учраас багш нарын заах барил дутмаг, цөм хөтөлбөрийн чадварыг эзэмшүүлэхийг зорьдог хэдий ч төдийлөн үр өгөөжтэй байж чаддаггүйг багш нартай хийсэн ярилцлагын арга болон сурагчдын өмнөх төсөөллийг судалгаагаар тогтоосон. “Дүрсийг тэгш хэмтэйгээр зурж байгуулах” сэдвийг бага ангийн сурагчдад ойлгуулах, энгийн арга зүйн шийдлийг судалгааны үр дүнд олж, бүх багш нар авч ашиглах боломжтой сайн хичээл болгосон.

Практик ач холбогдол: Дүрсийг тэгш хэмтэйгээр зурж байгуулах аргыг таниулахдаа хүүхэд бүрээр туршилт хийлгүүлж, түүнийх нь учир шалтгааныг ажиглуулж, дүгнэлт гаргуулснаар, дүрс тэгш хэмийн тэнхлэгээс 2 тийш ижил зайд оршдог гэдгийг ойлгох үйлийн баримжаа авах ач холбогдолтой.

Шинэлэг тал: Туршилтаар учир шалтгааныг ойлгуулж байгаа нь шинэлэг санаа гэж үзсэн. Онолын ойлголтыг хүндрүүлж биш, энгийн туршилтаар зааж ойлгуулсан. Хэрэглэгдэхүүнийг хүүхэд бүрийн гарт бариулснаар мэдлэг бүтээх үйл явцыг дэмжсэн.

Товч агуулга

Хүүхэд бүр хэрэглэгдэхүүн ашиглан цаасыг тэгш хэмтэйгээр нугалаад зүү хатган цэг үүсгэнэ. Цэгүүдийг холбож, дүрс үүсгэнэ. Дараа нь цаасыг дэлгээд, эсрэг талд үүссэн цэг болон дүрсийг ажиглах туршилт хийнэ.

Туршилтаас сурагчид “Тэгш хэмийн тэнхлэгийн хоёр талд ижил дүрс үүссэн байна”, “Дүрс ба цэгүүд нь харгалзан тэгш хэмийн тэнхлэгээс ижил зайд оршиж байна”, “Дүрсүүд тэгш хэмийн нэг тэнхлэгтэй байна” гэх мэтээр дүгнэж хэлж чадаж байсан учраас үйлийн баримжааг сайн авсан гэж хэлж болно. Үүний үр дүнд сурагчдын даалгавар гүйцэтгэх чадварын тоон үзүүлэлт 60-70% орчим хувиар ахисан төдийгүй сурагчдын идэвх сонирхол оролцоо нэмэгдэж, хичээлийг энгийн байдлаар ойлгуулж чадсан нь энэ арга зүйн давуу тал болсон. Манай багийн хамт олон өөрсдийн сайн хичээл болгосон “Дүрсийг тэгш хэмтэйгээр зурж байгуулах” ээлжит хичээлийн “Туршилтаар учир шалтгааныг ойлгуулах арга зүй”-г үр дүнтэй гэж үзэж, өөрийн сургуулийн 15 бүлгийн багшид түгээн дэлгэрүүлэн хамтран ажиллаж байна.

Чээж тооллоор сурагчдыг хөгжүүлэх нь

Ц.Мөнхцэцэг

Төв аймаг Заамар сум Шижир-Алт сургууль

Зорилго: Математик сэтгэлгээг хөгжүүлэх, математик хэллэгт сургах, бодох аргад суралцах, хялбар аргаар тооцоолох чадвар дээшилнэ.

Түлхүүр үг: чээж тоолол, хүүхэд, чадвар

Товч агуулга

Сурагчдын чээж тооллыг хөгжүүлснээр математикийн анхан шатны мэдлэг эзэмших, хэл сэтгэлгээг хөгжүүлэх, математикт сурах сонирхолтой болж, өдөр тутмын ахуйн асуудлыг тооцоолон шийдвэрлэх зорилгод хүрэхэд тус дөхөм болно.

Чээж тооллын дасгалыг тухайн хичээлийн сэдэв, зорилготой нягт уялдаж, эзэмшсэн чадвараа бататгах, сэргээх, гэрийн даалгавар шалгах болон шинэ сэдвийг судлахад бэлтгэх зорилгоор явуулдаг.

2011-2016 онд 5а ангийн сурагчдад чээж тооллыг явуулснаар тэдний тооцоолох чадварт гарсан ахицыг үнэлж, дутагдалтай талыг зассан. 1-3-р ангид сурч байх үед нь 7 хоногт 1-3 удаа чимээгүй чээж тооллыг \харааны байдлаар\ төрөл бүрийн тоглоомын аргаар, 4-р ангид хялбар тооцоолох аргаар, 5-р ангид тухайн хичээлийн сэдэв, зорилготой уялдуулан агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн бүрээр хичээлийн эхэнд, дунд үед 5 минутын хугацаанд явуулж, ахицыг харахын тулд хяналтын чээж тооллыг хичээлийн жилийн эхэнд, дунд, төгсгөл үед явуулсан.

Сурагчид математик хэллэг, нэршилд сайжирч, дасгал даалгаврыг хялбар аргаар зөв хийх, цаг барих чадварт суралцаж, сэтгэх, ажиглан харах чадвар, сонсголын ой, анхаарал төвлөрөлт сайжирч чээж тооллын гүйцэтгэлийн хувь 21%-аар ахисан.

5 жилийн ажиглалт, туршилтаас авч үзэхэд чээж тооллыг олон аргаар явуулах, сурагчдыг бүрэн оролцуулахын тулд хариуг бичгээр авах, хэрвээ сурагчид алдаа гаргах бол алдааг олуулж бодолтыг тайлбарлуулж байх мөн чээж тооллын дасгалыг ялгаатай даалгавар байдлаар боловсруулж байвал зүйтэй санагдлаа.

Эргүүлэлтээр хээ үүсгэх мэдлэг бүтээлгэх арга зүй

Ж.Эрдэнэцэцэг Б.Амарцэцэг У.Нямхүү

УБ. БГД 28-р сургууль 13-р сургууль

Зорилго: Монголчуудын нар зөв эргүүлдэг уламжлал, хас хээний тухай ойлголтыг хүүхдийн сурах үйл явцад дадлага ажлаар хэрхэн дэмжлэг үзүүлж байгааг судалгаат хичээлээр судлах, үр дүнг тооцоход чиглэгдэнэ.

Судалгааны загвар/арга зүй/: Эргүүлэлтээр хээ үүсгэхэд эргүүлэлтийн төв, чиглэл, 90градусын өнцөг зэргийг зайлшгүй мэдэх. Агуулгын хүрээнд 4-р ангид “Эргүүлэлт”, “Эргүүлэлтээр хээ үүсгэх” хоёр хичээлийн агуулга арга зүйг сайжруулсан хичээлийн туршилт судалгааг хэрэгжүүлсэн болно.

Судалгааны үр дүн: Хичээлийн бэлтгэл судалгааны үед тухайн агуулгыг хялбар ойлгох ямар арга зүй байгааг ярилцаж судалсан. Сурагчдад ойр мэдлэг бүтээх нөхцөл бүрдсэн, багш хөтлөх, хянах, судлах боломжтой байхаар мэдлэг эзэмшилтийн явцын судалгааг төлөвлөв. Яаж сэдэл төрүүлэх, ямар асуулт асуух, түүний хариу үйлдлүүд, даалгавар гүйцэтгэх дэс дараалал, аль болох олон хүүхдийг татан оролцуулах арга зүйн судалгааг хийсэн болно.

Хичээлд хэрэглэх хэрэглэгдэхүүнийг оновчтой, уялдаатай, сонирхолтой, бие даан ажиллах бүх боломжийг эрж хайсан.

Зөвхөн хүүхдийг үнэлэх биш зорилго, арга зүй, төлөвлөлт, хэрэглэгдэхүүн, туршилтын үр дүн зэргийг судлахыг зорьсон болно.

Практик ач холбогдол: Эргүүлэлтийн тухай агуулгыг заахад хүнд материал ховор санагдаж байгаа ч судалгааны үндсэн дээр 4, 5—р ангид судалах тохиромжтой гэж үзлээ.

Шинэлэг тал: Тухайн дүрсийн аль оройг эргүүлэлтийн төв болгон авснаас өөр өөр хээ үүсэх [чиглэл, өнцөг төв] зэргээс хамааран ахуй амьдралд хэрэглэдэг хээ, хүүхдүүдийн сэнс хийх шинэлэг санааг багш нарт хүргүүлж байна.

Түлхүүр үг: Тухайн дүрсийн аль оройг эргүүлэлтийн төв болгон авснаас өөр өөр хээ үүсэх туршилт, бэлтгэл судалгаа, хэрэглэгдэхүүний судалгаа, судалгаат хичээл

Товч агуулга

Дүрсийг 90 градусаар эргүүлэх нь бидний овоог нар зөв тойрох гэдэг ахуй амьдралын зүйлсээс үүдэлтэй болов уу. Агуулгын хүрээнд 4-р ангид “Эргүүлэлт, дүрсийг эргүүлэх хичээлийн судалгааг хийснээр

агуулга, арга зүй хэрэглэгдэхүүнийг хэрхэн сайжруулсныг багш нарын болон судалгаат хичээлийн үр дүнгээр үзүүлэхийг хичээв.

Судалгаат хичээл нь сурагчдыг математикийн хичээлээр зөвхөн илэрхийлэл, бодлого, тэгшитгэл бодох бус төрөл бүрийн хээ үүсгэх, дүрсийг тэгш хэмтэй зурах зэрэг олон сонирхолтой зүйлийг судалж өөрсдөө бие даан болон багшийн тусламжтай хийж болохыг судалгаат хичээлээр зааж үр дүнд багш нараар дүгнэлт гаргуулав.

Гео самбарыг ямар үед хэрэглэхэд ашигтай болохыг нарийвчлан судаллаа. Бид БГД-ийн ОУЦС, ЭУЦС, 20, 13, 28, 93-р сургуулийн нийт 6 багш, 240 сурагчдад зааж, хичээлд 6 сургалтын менежер, хөдөө орон нутгийн 120 гаруй багш нар ажиглаж 12 судалгаат хичээл заалаа. Хичээлийг хамтаараа хэлэлцэж шинэ санаа гарган, дараагийн сургуульд зааж бүрд хичээл маань улам боловсронгуй болж үр дүн гарч байв. Багш бүр өөр өөрсдийн арга зүйгээр зааж байгаа нь сонирхолтой бие биеэсээ суралцах, шинэ санаа давуу талыг олж харж судалж байлаа. 240 сурагчдын 232 буюу 96.1% нь ном бүтээх сонирхолтой байсан нь ажлын хуудсаа цаасан дээр өгснөөс өөрт үлдэцтэй ном хэлбэрээр өгөх нь илүү үр дүн өгснийг судалж ажиглалаа.

Тоо бүтээж тоглонгоо тоймлож сурцгаая

М.Хараа, Ч.Цагаанхүүхэн, Д.Оюунмаа, Г.Оюунтуяа

Дорнод аймаг, 12 дугаар сургуулийн сургалтын менежер, бага ангийн багш

Зорилго: Сурагчид өөрсдөө сургалтын хэрэглэгдэхүүнээ бэлтгэн, түүнийг хэрэглэх замаар шинэ мэдлэг, чадварыг бүтээх

Судалгааны загвар хандлага: Бага насны сурагчдын сонирхлыг татахуйц хэрэглэгдэхүүнийг хийлгэн, хүүхэд бүрд хүртээмжтэй, бодит амьдралд тохирсон байхаар бодож төлөвлөж боловсруулж, энэхүү хичээлийн хэрэглэгдэхүүн дээр хийж туршсан. Бага ангид “Сая хүртэлх тоо тоолол” сэдвийн хүрээнд сурагчид эдгээр тоог унших, бичих, тоймлох явцад тооны орон, ангийг будилах үүнтэй уялдан, тоог тоймлохдоо сайн ойлголгүй, алдаа гаргах тохиолдол багш бидний хувьд өмнөх хичээлийн жилүүдэд хичээл заах, мэдлэг, чадварт үнэлгээ хийх үед их гарч байсан

Судалгааны үр дүн: Сурагч бүр өөрийн гараар хийсэн хэрэглэгдэхүүнтэй, мөн багш түүнтэй адил хэрэглэгдэхүүнийг хийж, самбарт байрлуулсан нь хүүхдүүдэд их сонирхолтой зааврын дагуу

өөрсдөө шинэ мэдлэгээ бүтээн дор бүрд нь багшийн самбар дахь хариутай тулган, мөн өөрсдийгөө хянан, алдаагаа олж, тайлбарлаж байсан нь хичээлийн үр дүнг сайн болгосон. Мөн огт үзэг, цаас бариагүй боловч хүүхдүүд хэрэглэгдэхүүн дээр сайн ажиллаж, олон оронтой тоог тоймлох аргад богино хугацаанд суралцсан.

Практик ач хобогдол: Суралцагчдад хэрэглээ болгохын тулд хүүхэд бүрд тохирох сургалтын хэрэглэгдэхүүнийг багш өөрөө бэлтгэхэд их хугацаа шаарддаг учраас сурагчдаар богино хугацаанд өөрсдөөр нь бэлтгүүлэн, түүнийгээ ашиглан, хүртэх замаар хялбар аргаар ойлгуулахыг зорьсон

Шинэлэг тал/санаа: Энэхүү хэрэглэгдэхүүнийг \0-9-ийн цифр\ ашигласнаар сурагчид яг өөрсдийн гараар барьж, орон, ангиа нэрлэн олж, өргөх, дээш нь болгон байрлуулах, ялган тавих зэрэг үйлдлийг хийснээр олон оронтой тооны анги, орноо олох чадвар их хурдан сайжирч, улмаар тоог тоймлох үйл явцыг ойлгоход их хялбар болж байсан

Түлхүүр үг: Тоо бодлого, хэрэглэгдэхүүн, тоог тоймлох, бэлтгэл судалгаа, цифр

Товч агуулга

Сурагчдын “Сая хүртэлх тоог унших, бичих” чадварыг судлахад уншихдаа сайн байгаа боловч сая хүртэлх тоог үгээр өгч, цифрээр бичүүлэхэд орон, ангиа сайн ухаарахгүй алдаа гаргаж байв. Өмнөх хичээлийг бататгах замаар шинэ мэдлэг бүтээхэд аяндаа орохуйц сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулан, сурагчдаар гарын доорх материал хийлгэсэн.

Дараа нь өөрсдийн бэлтгэсэн хэрэглэгдэхүүнийг ашиглан тоглонгоо олон оронтой тоог тоймлож сурах гэж байгааг багш танилцуулж, үүний дараа багшийн зааврын дагуу дараах үйлдлийг гүйцэтгэхэд сурагчид эргэлзсэн үед найзаасаа асуун, хурдан гүйцэтгэв.

- Аравтын орныг олуулан, бага зэрэг доош болгон ширээн дээр байрлуулна.
- Аравтыг орны арын цифр хэд болохыг асууж, 5-аас ямар болохыг хэлүүлнэ. \Арын цифр 7 нь 5-аас их байна. \Ийм үед тоймлох гэж байгаа орон хэрхэн өөрчлөгдөхийг сурагчдаар хэлүүлнэ. \Тоймлож байгаа орон дээр 1 нэмэгдэнэ.
- Сурагчид 5-ын цифр дээр 1 нэмэгдэж, 6 болох учраас 5-ыг 6-аар сольж байрлуулна. Арын цифр ямар болохыг асууж \0 болно\, 7-гийн цифрийг эргүүлж 0 болгоно. \Цифр бүрийн ард 0 бичсэн\

Ийм алхмуудаар 10-т, 100-т, 1000-т, 10000-тын орон хүртэл тоймлосон.

Хүүхэд бүрийг ярих урлаг ба жүжигчилсэн тоглолтоор хөгжүүлэх нь

Н.Наранжаргал

Баянхонгор аймгийн Соого сейко ахлах сургууль

Зорилго: Сурагчдын ном унших арга барил эзэмшилт, хандлагыг судлан, сурагчдаар номыг бүтээлчээр уншуулах замаар ярих чадварыг хөгжүүлэх аргыг эрэлхийлэн гаргана.

Суралцагчдын бүтээлчээр ярих чадварыг хөгжүүлж болохуйц оновчтой арга зүйд эрэл хайгуул хийж, түүнийгээ туршиж, энэхүү арга зүй нь тэдний ярих, бичих чадварт хэрхэн нөлөөлсөн талаар гарах үр дүнд дүгнэлт гаргахад судалгааны ажил чиглэнэ.

Түлхүүр үг: Бүтээлчээр унших, дүрийн тоглолт, ярих-сонсох-унших-чадвар, сурах арга барил, хөгжих,

Сургалтын арга зүй: Хүүхэд тоглоом хоёр салшгүй нөхөд гэдгийг хэн бүхэн мэднэ. Тэгвэл дүрийн тоглолт нь хүүхдэд илүү ойр байдаг бөгөөд энэ л урлагаар дамжуулан хүүхдийг хөгжүүлэхийг зорьсон.

Зохиолын агуулгыг дүрээр илэрхийлэхийн тулд агуулга ба дүрийн хоорондын харьцаа хамаарлыг ойлгон унших, өөрт болон бусдад өгөх санааг тэмдэглэн бичих, дүрийн сонголтыг хамтран хийж хүүхэд бүр өөр өөрийн үүрэгтэй байхыг ухаарах үйлийг гүйцэтгэнэ.

Практик ач холбогдол: Сурагчдын хувьд ном сурах бичиг дэх зохиолын агуулгыг судлах, зохиолын агуулга ач холбогдлыг дүрээр болон зургаар илэрхийлэх нь сонирхолтой байхаас гадна, бүтээлч байдлыг төлөвшүүлж байгаа нь ажиглагдсан. Иймд ангийн сурагчдыг хамтын ажиллагаанд суралцуулахад түлхүү анхаарч ажилласан нь сургалтыг маш үр дүнтэй болгосон.

Товч агуулга

4-5-р ангийн сурагчдын чөлөөт сэтгэлгээ нь илүү хөгжсөн, бусдын дэмжлэггүйгээр өөрийгөө ямар нэгэн байдлаар илэрхийлэх чадварт суралцаж байгаагаараа онцлог байна.

Бид сурах бичгийн зохиолын агуулгын хүрээнд зөвхөн уншуулж, ач холбогдлыг нь ярилцаад л өнгөрдөг нь багш бидний дутагдал болдог.

Түүний оронд хүүхэд тэр зохиолоос ямар ач холбогдолтой зүйлийг олж харж байна түүнийгээ өөрийнхөөрөө уран сайхны аргаар хэрхэн илэрхийлэхийг хүсэж байгааг харгалзан тэдэнтэй хамтарч тэдний ертөнцийг бүтээх нь чухал. Хүүхэд өөрөө хүссэн зүйлээсээ илүү ихийг сурч мэдэж байдаг.

Хүүхэд нэг бүрийн ярих сонсох чадварыг хөгжүүлэхийг зорьсон арга зүй нь тэдний зөвхөн өөрийгөө илэрхийлэх төдийгүй, зөв бичих зүй, найруулан бичих, бичгийн хэв зэрэгт зөв нөлөө үзүүлж байгаа нь үнэлгээгээр илэрч байна.

Дуурайн бичих аргаар сурагчдыг чадваржуулах арга зүй

Б. Долгорсүрэн, Н.Оюунгэрэл, Д.Содномпэлжээ, А.Долгормаа, Одгэрэл,
Г.Цэндорж

Завхан аймаг Эрдэнэхайрхан сумын сургууль

Зорилго: Хүүхдийн унших бичих арга зүйд суурилан дуурайн бичих дадал эзэмшүүлэх

Судалгааны үр дүн: Сурагчдад унших бичих чадвар дээр нь суурилан дуурайн бичих дадал эзэмшүүлэх нь тэднийг өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх улмаар зөвхөн дуурайн бичих биш шүлэг зохиох арга барилд сурах арга зүйг эзэмшсэн бүтээлч үйл болсон нь харагдсан. Түүнчлэн шүлэг бичих нь амар хялбар зүйл биш бөгөөд уйгагүй хөдөлмөр чармайлтын үр дүн гэдгийг ухаарч өөртөө итгэлтэй байх чадвар дадал олгосон үр дүн гарлаа.

Практик ач холбогдол: Зөвхөн монгол хэл биш бусад хичээлээр хүүхэд юмыг хийхдээ олон талаас нь олж харах, дүгнэх чөлөөтэй сэтгэх чадвар нэмэгдэх боломжтой болсон.

Шинэлэг санаа: Амжилтад хүрэх хамгийн тодорхой зам бол олон дахин давтсан оролдлого юм.” гэсэн эрдэмтний үгийг санаж, нэг зохиосон шүлгээ олон дахин сайжруулах аргаар сайн зохион бичдэг болсноор хүүхэд илүү чөлөөтэй сэтгэх, бүтээлч арга барилд суралцах боломжтой.

Энэ арга зүйд суралцсанаар хүүхэд өөрийн дуу хоолойгоо сонсож, өөртөө итгэх итгэл нэмэгдсэнээр хичээл үйл ажиллагааг сонирхолтой болгох хөшүүрэг болж чадсан.

Түлхүүр үг: дуурайн зохиох, чадваржилт, өөртөө итгэлтэй болох

Товч агуулга

“Дуурайн зохиох арга” сэдэвт сайн хичээлийг 4а ангид зааж, хэлэлцүүлэг хийн засан сайжруулсан хөтөлбөрөөр дахин заалаа. Багаар хамтран ярилцаж, сурагчдад дуурайн зохиох дадал эзэмшихэд анхаарах санамж, зөвлөгөөг гаргаж хичээлдээ тусгасан нь үр дүнтэй

байлаа. Сурагчдын эхлээд дуурайн зохиосныг харьцуулан ажиглавал өөр өөрсдийн бодлоор өдөр тутмын амьдрал эргэн тойрны бодит зүйлс дээрээс ажигласан байдлаас зохиосон байсан. Дараа нь сэдвээ өөрчлөн шүлэг дуурайн зохиох дадлага хийсэн. Шүлэг дуурайн зохиохоос өмнө сурах бичиг дээрх шүлгүүдийг шууд уншуулахыг урьтал болголгүй эхлээд сурагчдаар өөрсдийнх нь мэддэг, чээжлээд мартаагүй, эсвэл өмнө нь уншаад, сэтгэл нь хөдөлж байсан шүлгүүдээс уншуулж, ярилцсан.

Шүлгийн утгын тухай сурагчдаар чөлөөтэй яриулж, товч хэлэлцүүлэг өрнүүлэх ажлыг хийсэн нь хүүхдүүд өөрсдөө шүлэг дууриан зохиох буюу чөлөөт сэдвээр шүлэг зохиоход үр дүнгээ өгсөн. Судалгаат хичээл болон чадваржсанаа үнэлэх тайлант хичээлийг эцэг эхчүүдтэй хамтран зохион байгуулж, хүүхдүүдийнхээ хөгжлийн ахицыг үнэлсэн. Энэ нь эцэг эхийн хүүхдэдээ урам өгөх, хүүхдээрээ бахархах миний хүүхэд чадах юм байна гэсэн итгэлийг төрүүлсэн ажил боллоо. Судалгаат хичээлийн явцад хүүхдүүдийн дуурайн зохиох чадварт гарч буй ахицыг хүүхдүүд болон багш нар үнэлж ажилласнаар чөлөөт сэдвээр шүлэг зохиох чадвартай боллоо.

Энэ технологи нь бусад ямар ч хичээлийн хувьд агуулгын залгамж холбоонд нь тулгуурлан, суурь мэдлэгийг сайн өгч чадвал алхам бүр нь тодорхой багшийн оролцоо бага суралцагчийн сэтгэх чадвар, оюун ухаан хөгжсөн, бүтээлээрээ бахархсан “сайн хичээл” заах, “сайн үйл” бүтээх, хүүхдийг чадваржуулах боломж байгааг тодрууллаа.

Дуурайн бичих арга зүйгээр хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх нь

Сумьяажав Болортуяа

Төв аймаг Баяндэлгэр сумын ЕБС

Боловсролын шинэчлэлийн хүрээнд бага боловсролыг хүний хөгжлийн үндэс, эх хэлний суурь чадамжийг эзэмших үе гэж тодорхойлсон нь багш бидэнд итгэл үнэмшил хариуцлага өгч ээлжит болон нэгж хичээлийн чанар үр дүнг дээшлүүлэн шинэлэг арга зүйг туршин хэрэгжүүлж, хүүхэд нэг бүрээ судлан судлагдахуун тус бүрээр хөгжүүлэх нь боловсролын чанарын шинэчлэлд оруулах хувь нэмэр хийх үйлийг маань зааж тодорхойлсон тул багш бид хичээлээ төлөвлөхдөө өөрийн давуу талаа ашиглан хүүхэд нэг бүрийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх асуудлыг оновчтой тодорхойлж зохион байгуулах шаардлага гарсан.

Зорилго: Монгол хэлний судлагдахуунаар 2-р ангиас дуурайн бичих агуулга орж байгаа нь бага ангийн хүүхдүүдийн үгийн баялаг бага, энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш нарын арга зүй санал санаачлага чухал хэрэгтэй тул хүүхэд нэг бүрээ дуурайн бичих арга зүйгээр хөгжүүлэхийг зорин ажилласан Зжилийн туршилт өөрийн судалгааны багшлахуйн арга зүйн технологийн шийдлийг мэргэжил нэгт нөхөдтэйгээ хуваалцахыг зорилоо.

Судалгааны арга зүй: Энэ судалгаагаа 3 жилийн хугацаанд өөрийн заах арга зүйдээ анализ дүгнэлт хийн асуулга тестийн, ажиглах, харьцуулах, сурвалжлага хийх, анкет бөглүүлэх, туршилтын аргыг хэрэглэн туршсан.

Судалгааны үр дүн: Хүүхэд нэг бүрээ өөрийн туршиж хэрэгжүүлсэн “Дуурайн бичих арга зүй” –ээр хөгжүүлсний үр дүнд эцэг эх, олон нийт сургууль анги хамт олны ажилд идэвхтэй оролцдог болсон төдийгүй номыг уншихаа байсан сэтгэхүй, орчныг өөрчилж хүүхэд бүртээ өөртөө итгэлтэй би чадна гэсэн итгэл өгч дуурайн зохион бичдэг зохиолч болох хүсэл мөрөөдөлтэй гэрэлт ирээдүйг төсөөлөн боддог чадвартай болгосон маань энэ гурван жилийн хөдөлмөрийн судалгааны үр дүн гэж үзэж байна.

Практик ач холбогдол: Багш бид нар сурах бичгийн хүрээнд агуулгаа судлаад өөрийн болон сурагчдын сонирхлын тандалт хийж тухайн сэдвийг хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагтайгаа холбон гүнзгийрүүлэн судалж энэ ажилдаа эцэг эх олон нийтийг татан оролцуулж хүүхэд нэг бүрээ хөгжүүлж болдгийг туршин хэрэгжүүлж амжилтад хүрч, бүс аймгийн хэмжээнд туршлагаа түгээн дэлгэрүүлж энэ сэдвээр зүүн бүсийн 6 сургууль судалгаа хийж туршин 2015-2016 оны хичээлийн жилийн сайн хичээл үйл ажиллагааны туршлага солилцох зөвлөгөөнд хөрш Мөнгөн морьт сум түрүүлсэн нь энэ арга зүйн чухал амжилт, ач холбогдол гэж үзэж байна.

Шинэлэг тал \санаа\ Аливаа нэгэн судлагдахуунаар сурагчдаа өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд сэтгэл зүйн орчныг сайн бүрдүүлж эцэг эх олон нийтийг татан оролцуулж чадсан нь сум орон нутагтаа шинэлэг чухал ажлын нэг болж чадсан. Хүүхдийг номтой нөхөрлүүлж, номыг дээдэлж ном унших дур сонирхолтой болгохын тулд олон талт соёл хүмүүжлийн ажлыг эцэг эхтэй нь хамтран зохион байгуулсан нь тэднийг өөртөө итгэлтэй би чадна, миний хүү охин чадна гэсэн урам өгч хамтран ажиллах

Түлхүүр үг: хүүхэд нэг бүр, ертөнцийн гурав, шүлэг зохиох, эрэл хайгуул, өөртөө итгэх итгэл

Товч агуулга

Цөм хөтөлбөр хэрэгжсэнээр багш бид сурах бичиг, хөтөлбөр агуулгаа судлан өөрийн сонирхол мэдлэг чадвараа ашиглан хүүхэд бүрийг хөгжүүлэхийг зорьсон. Багш миний хувьд хөдөө орон нутгийн эцэг эхчүүд улирлын эхэнд хүүхдээ авчирч орхиод мартдаг сургууль ангиас зохиосон аливаа ажилд оролцдоггүй, хүүхдийн хөгжлийг анхаардаггүй байдлыг багасгаж тэдний сонирхол идэвхийг өрнүүлж хүүхдийн сурлага, хүмүүжил хөгжилд эцэг эхийн оролцоо хэрэгтэй гэдгийг давхар мэдрүүлэхийг бодсон. Хүүхдийг дуурайн бичих арга зүйгээр хөгжүүлэхийн тулд эцэг эх гэр бүлийг хамтад нь сургаж хөгжүүлж сэтгэл зүйн орчныг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой байсан. Мэдээлэл технологийн эрин зуунд амьдарч байгаа хүүхдүүд ном уншихаа байсан тул тэднийг номд дурлуулж, номтой нөхөрлүүлж, номыг шимтэн уншиж, ирээдүйд би зохиолч болно гэсэн итгэлтэй болгоход олон төрлийн соёл хүмүүжлийн ажлыг зохиож энэ ажилдаа эцэг эхээ татан оролцуулсан нь зөв алхам болсон. Бид хөтөлбөрийн дагуу хичээлийн цагаараа хүүхэд бүрийг хөгжүүлэх боломж хомс байсан. ХГСҮА хичээлээр сурсан мэдсэнээ өргөжүүлэн сонгож судлан хүүхэд бүрээ хөгжүүлэх боломж бий болсон. Багш миний судалж туршсан дуурайн бичих арга зүйгээр хүүхэд бүрээ хөгжүүлсэн туршлага мэргэжил багш нарт маань ажилдаа тусган авах санаа болоосой гэж бодож байна.

ТАВ. ХАНЫН ИЛТГЭЛ

Төлөвшилд хүрсэн сургуулийн соёл

*О.Мөнхгэрэл, Г.Бүдтуяа, Ч.Цогзолмаа,
Р.Оюунтуяа, Л.Нямсүрэн, Я.Наранбаяр, Д.Галцолмон
Дорнод аймгийн Хан-Уул цогцолбор сургуулийн багш нар*

Зорилго: Хүүхэд нэг бүрийн хөгжил, төлөвшил, хандлагын өнөөгийн байдлыг судалж, хэрхэн ямар арга замаар ахиц, амжилттай байхыг туршин хэрэгжүүлсэн үйл ажиллагаан дээрээ тулгуурлан үр дүнг тооцож түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Судалгааны загвар /арга зүй/ хандлага: Онолын болон баримт бичгийн судалгаа, харьцуулалт хийхээс гадна үйл ажиллагааны явцыг ажиглах, хүүхэд бүрийн ахиц амжилтыг ажиглан, хос харьцуулалт, ажиглалт, туршилт, нээлттэй асуулга, фокус ярилцлага, математик-статистикийн аргуудыг хэрэглэж, word, excel, power point программуудыг ашиглалаа.

Судалгааны ажлын ач холбогдол: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх ажлыг багш нар 5 чиглэлээр төлөвлөн ажиллах нь хүүхдийн хөгжил, төлөвшлийн ахицыг тооцон ажиллахад илүү дөхөм болсон.

Судалгааны ажлын шинэлэг тал /Дэвшүүлж буй санаа/: Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэж байх үедээ сурагч бүрийг зөв төлөвших хамгийн оновчтой зүйл юу болохыг их л олон зүйл дээр туршин үзэж, харьцуулалт хийсэн. Сургуулийн соёлыг хүүхэд бүрийн саналыг тусгасан, хүүхэд бүрд ойлгомжтой, тэдний нүдэнд ил, ойлгоход энгийн үг хэллэгтэй, зураг дүрс ашиглан боловсруулан мөрдөж байх нь хүүхдийн хөгжил, төлөвшилд үр дүнтэй юм гэсэн саналыг дэвшүүлж байна.

Түлхүүр үг: Сургуулийн соёл, дэг, хүүхдийн хөгжил, төлөвшил, мэдлэг чадвар

Товч агуулга

Боловсролын чанарын шинэчлэлийг эх хэл, үндэсний соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг, сурах арга барилтай, авьяас чадвараа нээн хөгжүүлдэг, өөртөө итгэлтэй, бүтээлч сэтгэлгээтэй, хамтран ажиллаж, амьдрах чадвартай иргэн болж төлөвших боломж бүрдүүлэх зорилготойгоор боловсролын түвшин бүрд, үе шаттайгаар зохион байгуулж байгаа билээ.

Хүний төлөө тэднийг дэмжин хөгжүүлэх агуулгаар хүмүүнлэг үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн насан туршийн тасралтгүй хөгжлийг хангахад чиглэгдэнэ. Зөв монгол хүн төлөвших үйл явцыг зөвхөн сургуулиар бус бие хүний төлөвшил, нийгмийн төлөвшлийн харилцан хамаарлын өргөн хүрээнд авч үзнэ. Иймээс сургууль нь нийгэм, олон нийтийн оролцоонд тулгуурласан, гэр бүл, нийгмийн хөгжилд үүрэг гүйцэтгэдэг хүний хөгжлийн төв болж хөгжих учиртай юм.

Манай нутагт ургадаг ургамал

Д.Пунсал

Булган аймаг 12 жилийн 1 дүгээр бүрэн дунд сургууль

Зорилго: Хичээлийн судалгаагаар дамжуулан багш, сурагчдыг хөгжүүлэх оновчтой арга зүй бий болгохыг зорьсон.

Судалгаат хичээлийг зохион байгуулах үндэслэл: Хичээлийн судалгааны арга зүйг дэлгэрүүлэх, багаар ажиллахын давуу талыг харуулах өөрийнхөө нутагт ургадаг ургамлыг мэдэх, ялгааг нь ойлгох судалж мэдэхийг хүсч “Манай нутагт ургадаг ургамал” сэдвийг сонгох болсон.

Шинэлэг тал: Энэхүү хичээлийн шинэлэг тал нь танхимын ба танхимын бус сургалтыг хослуулан явуулж, шинжлэх ухааны мэдлэгийг бодит үйл ажиллагаатай холбож өгснөөрөө өдөр тутмын хичээлээс шинэлэг болсон.

Практик тал: Өмнө нь хүн орчин хичээлийг танхимын сургалтаар явуулж хэвшсэн байсан. Эсвэл дан ганц аялал экскурс зохион байгуулж сургалт явуулж ирсэн. Харин миний энэхүү хичээл нь багш нарын багаар ажиллаж бэлтгэл судалгааг хийж, танхимын ба танхимын бус сургалтыг хослуулснаараа онцлог.

Судалгааны арга зүй: Энэ хичээлээр сурагчдын өмнөх төсөөллийг судалж, бодит ургамал, амьд биетэй танилцуулж, хүүхдүүд өөрсдөө бодож, туршиж, мэдэрч, бие биенээсээ суралцаж, шинжлэн судлах замаар асуудлыг шийдвэрлэх арга зүйг хэрэглэсэн.

Хичээл нь “Орчноо ажиглаж судалъя” нэгж хичээлийн 5 дугаар цагийн ээлжит хичээл байсан бөгөөд өөрийнхөө орон нутагт ургадаг ургамлуудыг мэдэх, ялган таних, нэрлэж сурахыг зорьсон юм.

Судалгааны үр дүн: Энэхүү хичээлээр багш төсөөллийн судалгааг авч, аялал экскурс хийж, асуултаа эмх цэгцтэй, дэс дараалалтай тавьж, сурагчдын өөрсдийн нь өдөр тутмын амьдралаас олж авсан мэдлэг дээр тулгуурлаж хичээлээ зааж чадвал сурагчид өөрсдөө

мэдлэгийг бүтээж, өөрийгөө үнэлж бие, биеэсээ суралцаж, бие даан бодож сэтгэж чаддаг гэдгийг харуулж өгсөн.

Товч агуулга

Суралцагчийн өөртөө итгэх итгэлтэй бүтээлч хариуцлагатай, насан туршдаа суралцах чадвартай иргэн болгон төлөвшүүлэх явдал чухлаар тавигдаж байна. Иймээс суралцагчаа зөв чиглүүлэх сургалтын чанарыг дээшлүүлэхэд “Хичээлийн бэлтгэл” чухал байр суурийг эзэлж байна. Багшийн хичээлийн бэлтгэл сайжирвал багшлах арга зүй өөрчлөгдөнө. Арга зүй өөрчлөгдсөнөөр хүүхдүүд хөгжинө. Хүүхэд хөгжинө гэдэг бол мэдлэг бүтээх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож бусадтай хамтран ажиллаж, харилцаж өөрийгөө хөгжүүлнэ гэсэн санаа юм. Хичээлийн гол амин сүнс болсон юуг, яаж заах, сурагчдаар ямар мэдлэгийг хэрхэн бүтээлгэх вэ? гэдэг нь хичээлийн нэгэн элемент болох “өмнөх төсөөллөөс” шалтгаална. Үүнийг оновчтой төлөвлөж, янз бүрийн орчноос өөр өөр сэтгэл зүйтэй ирсэн сурагчдыг нэг түвшинд аваачиж хичээлээ зааснаар хичээл амжилттай болж хүүхдийн хөгжилд нөлөөлөх боломжтой байна.

Сургуульд суурилсан байгалийн ухааны хичээлийн судалгааг зохион байгуулж буй туршлагаас

У.Энхтуяа, С.Алтанзул

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, I сургууль

Зорилго: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын I сургуульд суурилсан бага, дунд, ахлах ангид хичээлийн судалгааг 2011 оноос зохион байгуулж, сүүлийн жилүүдэд тус сургуулийн багшийн арга зүй, ур чадвар, хүүхдийн хөгжил төлөвшил, эцэг эхийн хандлагад тодорхой ахиц амжилт гарч байна. Ийм учраас хамт олны хуримтлуулсан туршлагаасаа аймгийн хэмжээнд ЕБС-ийн сургалтын менежер, байгалийн ухааны багш нартай хуваалцахын зэрэгцээ түгээн дэлгэрүүлэхийг зорьсон.

Судалгааны загвар /аргазүй/ хандлага: Суралцагчдын суралцахуйг дэмжих аргазүйн хөгжил” төслийн I, II шатны сургалтаар болон Япон улсад “Математик-Байгалийн ухааны багш нарын мэргэжил дээшлүүлэх курс”-ийн сургалтаар хичээлийн судалгааны арга зүй, туршлагыг судалж, улмаар өөрийн сургуулийн онцлогт тохируулан сургуульд суурилсан хичээлийн судалгааг мэргэжлийн багш нар, сургалтын менежер, сургуулийн удирдлага, эцэг эхтэй хамтран явуулж ирсэн.

Судалгааны үр дүн: Байгалийн ухааны хичээлийн судалгаа явуулснаар хичээлийн үр өгөөж, чанарт ахиц гарч, багшийн арга зүй, ур чадвар, эв дүй сайжирч, хүүхдийн мэдлэг чадвар, бүтээлч хандлага, хөгжил, төлөвшилд тодорхой ахиц амжилт гарсан. Судалгаанаас харахад манай сургуульд 1-12-р ангид элсэн суралцах хүүхдийн тоо 2012-2016 оны хичээлийн жилд 13.6%-иар нэмэгдсэн байна. Мөн орон нутгийн уралдаанд багш, сурагчид маань амжилттай оролцож байгаагийн нэг үзүүлэлт нь хичээлийн судалгааг сайжруулж, үр дүнтэй явуулж байгаагийн илрэл юм.

Шийдвэрлэсэн арга зам: Сүүлийн 2 жилд багш нарын хамтын ажиллагаа манай сургуульд улам бүр өргөжин тэлж, дараах байдлаар багийн зохион байгуулалтаар ажиллаж байна.

Сургуулийн нийт багш нар багийн зохион байгуулалтад орсноор багш нар хамтарч ажиллах, хамтын бүтээл гаргах, хамтдаа хөгжих таатай орчин бүрдэж байгаа бөгөөд энэ үйл ажиллагааг зохион байгуулахад багш бүрийн ажлын цагийн нарийн төлөвлөлт хэрэгтэй юм. Ажлын цагаа нарийн төлөвлөх нь багш бүр ажлын ачааллыг зохицуулах, стрессгүй ажиллах, аливаа ажлыг цаг тухайд нь чанартай гүйцэтгэх, хийх ажлаа тодорхой цэгцтэй болгох гэх мэт ач холбогдолтой. Манай сургуулийн дунд, ахлах ангийн 68 багш өөрийн ажлын цагийн төлөвлөлтийг хийж, түүнийгээ мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн сургалтын менежер хичээлийн хуваарийг оновчтой төлөвлөн багш нартайгаа хамтран гаргаж, хичээлийн судалгаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Мөн ахлах ангийн сурагчдын хичээл сонголт, бүлэг зохион байгуулалтыг хийснээр ахлах ангид хичээлийн ажиглалт, судалгаа хийх боломжийг бүрдүүлсэн.

Практик ач холбогдол: Багш бүр ажлаа оновчтой төлөвлөж, ажлын цагаа зохицуулж, судлагдахуун болон бусад багаар хамтран хичээлийн судалгаа, сургалт, хүмүүжил явуулах боломж бүрдэнэ.

Шинэлэг санаа: Судлагдахуун тус бүрээр багш нар хичээлээ хамтран бэлтгэх, хичээлээ удирдан чиглүүлэх, хэлэлцүүлэх, сайжруулах үйл ажиллагааг аймгийн хэмжээнд цогц байдлаар шийдвэрлэх боломжтойг тодорхойлж чадсан.

Түлхүүр үг: Сургуульд суурилсан хичээлийн судалгаа, багшийн ажлын цагийн төлөвлөлт, хичээлийнхуваарь

Товч агуулга

Сургууль бүр өөрсдийн өнөөгийн нөхцөл байдал нөөц, хэрэгцээ шаардлагаа судлаад багш бүрийн ажлын цагийн төлөвлөлт, хичээлийн хуваарийг оновчтой төлөвлөн багш нар, сургалтын менежерүүдтэй хамтран гаргаж, хичээлийн судалгаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх нь чухал юм.

Бүтээлээр хүүхдийг хөгжүүлэх нь

З.Тунгалаг, Л.Дашдолгор, С.Ариунаа

УБ хот 23 дугаар сургуулийн бага боловсролын багш нар

Зорилго: Суралцагчдын бүтээл нь хүүхдийн сурах үйл явцад хэрхэн дэмжлэг үзүүлж чадаж буйг судалгаат хичээлээр судлах, бүтээлээр хөгжүүлэх технологио хэрэгжүүлэх явцдаа сурагчдын хөгжил оролцоонд гарах эерэг өөрчлөлтийг илрүүлэх

Судалгааны үр дүн: Энэ хичээлийн судалгаагаар бүтээлээ хийж урам авахаас гадна бүтээлээ хичээлийнхээ хэрэглэгдэхүүн болгож хэрэглэх болсон. Дүрслэх урлагийн хичээлийн хувьд харилцаа холбоонд нь хүүхдийн чадварыг илрүүлэх шалгуур үзүүлэлтийг хийж дүгнэхэд сурагчдын урлагийг мэдрэх, бүтээлч эрэл хайгуул хийх, гүйцэтгэх ур чадвар дээшилж, сурагчдын 95% нь өгсөн даалгаврыг эзэмшиж чадаж байгаа нь харагдаж байсан нь хичээлийн судалгаа хийж сайжруулалт хийсний үр дүн гэж ойлгож байна.

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар хичээлийн санаа: Бүтээл дээр суурилан хүүхэд бүрийн хөгжлийг хангах, хүүхэд бүрийн өөрийнх нь онцлогийг харгалзан үзэж судлах, алхам бүр дээр ажиглах, ахиц өөрчлөлтийг тэмдэглэх ажлыг хэрэгжүүлж хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэхийг зорьж ажилласан нь энэ хичээлийн судалгааны онцлог байсан.

Практик ач холбогдол: Дүрслэх урлагийн хичээлд суурилан бусад хичээлийн интеграцийг хийж бүтээлчээр мэдлэгээ олж авдаг болох, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдлэгээ өөрөө эрж хайх замаар олж чаддаг чадвартай болж байгааг харуулах боломжтойг нотолж байна.

Шинэлэг тал: Хичээлийн судалгаанд тулгуурлан сурагчдыг бүтээлээр хөгжүүлэх технологийг боловсруулан хэрэгжүүлж үр дүнд хүрч байгаа нь бусад багш нарт хүн ба нийгмийн хичээлээр сурагчдын түлхэц болоход шинэ санаа болж чадна.

Түлхүүр үг: Бүтээлээр хөгжүүлэх, урлах, илтгэх чадвар, бүтээлч эрэл хайгуул

Товч агуулга

Бүтээлээр хүүхэд хөгжүүлэх зорилтын хүрээнд 3 жилийн хугацаанд уг судалгаат хичээлийг удаа дараа засан сайжруулж, сурагчдын оролцоог хэрхэн нэмэгдэж байгааг мөн хүүхдүүдэд хэрхэн дэмжлэг үзүүлж байгааг, бүтээлээрээ хэрхэн хөгжиж байгааг судалж, оношилж үр дүнг гаргаж дүгнэлтээ хийсэн. Туршилт судалгаа хичээлийн

ажиглалтаар хүүхдүүдийн оролцоо нэмэгдэж байгааг өөрчлөлтөөр нь харьцуулан үнэлэлт дүгнэлт хийж үзэхэд 5А,5В,4Г,2Г ангийн суралцагчдын 70-85% нь бүтээлээ хийхдээ дуртай, бүтээл урлах явцдаа өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж сурсан, бусдын үзэл бодлыг хүндэтгэн үздэг болсон нь судалгааны явцад илэрч байсан. Судалгаат хичээл бүрийн дараа сурагчдын оролцоонд үнэлэлт дүгнэлт өгөх, хийж буй бүтээлдээ хандаж буй хандлага нь 15-20% иар нэмэгдэж байна.



БАГШИЙН МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ

Сүхбаатар дүүрэг, VIII хороо,
Энх тайвны өргөн чөлөө
Багшийн хөгжлийн ордон
Улаанбаатар хот - 14191

МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН
СУДАЛГААНЫ НИЙГЭМЛЭГ

Багшийн хөгжлийн ордон
6-р давхар, 604 тоот